



Страсбург, 2021.02.22
Санал № 1004/2020

CDL-AD(2021)001

ХУУЛИАР АРДЧИЛАЛ ТОГТООХ ЕВРОПЫН КОМИСС
(ВЕНЕЦИЙН КОМИСС)

ХУВЬ ХҮНИЙ ҮНДСЭН ХУУЛИЙН ШҮҮХЭД ХАНДАХ ЭРХ ШИНЭЧИЛСЭН ТАЙЛАН

МУИС-ийн Үндсэн хуулийн эрх зүйн хүрээлэн
2023

ХУУЛИАР АРДЧИЛАЛ ТОГТООХ ЕВРОПЫН КОМИСС
(ВЕНЕЦИЙН КОМИСС)

ХУВЬ ХҮНИЙ ҮНДСЭН ХУУЛИЙН ШҮҮХЭД ХАНДАХ ЭРХ ШИНЭЧИЛСЭН ТАЙЛАН

Венецийн Комиссын 2020 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн
125 дахь удаагийн цахим нэгдсэн хуралдаанаар батлав.
(2020.12.11-12)

Эрхэм Гагик ХАРУТЮНЯН (Гишүүн, Армен)
Эрхэм Анжелика НУССБЕРГЭР (Гишүүн, Герман)
Эрхэм Питер ПАКЗОЛАЙ (Хүндэт Ерөнхийлөгч)
нарын тайлбаруудыг үндэслэн гаргасан болно.

МУИС-ийн Үндсэн хуулийн эрх зүйн хүрээлэн

Хуулиар ардчилал тогтоох Европын комисс (Венецийн комисс)

ХУВЬ ХҮНИЙ ҮНДСЭН ХУУЛИЙН ШҮҮХЭД ХАНДАХ ЭРХ
ШИНЭЧИЛСЭН ТАЙЛАН

МУИС-ийн Үндсэн хуулийн эрх зүйн хүрээлэн Венецийн комиссоос өгсөн зөвшөөрлийн дагуу энэ тайланг монгол хэл рүү орчуулж эрхлэн гаргав.

Орчуулсан: МУИС-ийн Үндсэн хуулийн эрх зүйн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний гэрээт ажилтан, хууль зүйн магистр, хуульч
Н.ЭНХЦЭЦЭГ
МУИС-ийн Хууль зүйн сургуулийн оюутан С.БИЛЭГТ-ОЧИР

Хянасан: МУИС-ийн Үндсэн хуулийн эрх зүйн хүрээлэнгийн захирал,
Хууль зүйн сургуулийн профессор, хууль зүйн доктор
О.МӨНХСАЙХАН

Техникийн баг: Эрх зүйч О.ЭНХЖИН
МУИС-ийн Хууль зүйн сургуулийн оюутан Т.ЭМҮЖИН

Анхны хэвлэл

Монгол орчуулгын эрх © 2023 МУИС-ийн Үндсэн хуулийн эрх зүйн хүрээлэн

Бүх эрх хуулиар хамгаалагдсан болно. Энэхүү бүтээлийг МУИС-ийн Үндсэн хуулийн эрх зүйн хүрээлэнгийн зөвшөөрөлгүйгээр бүтнээр нь буюу хэсэгчлэн цахим, цаасан, аудио болон бусад хэлбэрээр хэвлэх, хувилах, тараах болон бусад ямар нэг хэлбэрээр олшруулах, түгээхийг хориглоно.

АГУУЛГА

I. ЕРӨНХИЙ ТАЙЛБАР	7
II. УДИРТГАЛ	2
III. ТҮҮХЭН ХӨГЖИЛ	2
A. Үндсэн хуулийн хяналтын хөгжил	2
B. Үндсэн хуулийн хяналтын хоёр төрөл: төвлөрсөн бус ба төвлөрсөн систем	3
C. Сүүлийн үеийн хөгжил, чиг хандлага	6
IV. ХУВЬ ХҮН ҮНДСЭН ХУУЛИЙН ХЯНАЛТАД ХАНДАХ ТӨРЛҮҮД	9
A. Шууд хандалт	9
1. Хувь хүний гомдол	10
2. <i>Actio popularis</i>	13
B. Шууд бус хандалт	15
1. Ердийн шүүх	15
2. Омбудсмeны байгууллагууд	20
C. Холимог шийдэл	22
V. ХЯЗГААРЛАЛТ	23
A. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэх нөхцөл (“шүүлтүүр”)	24
1. Өргөдөл гаргах хугацаа	24
2. Хууль ёсны төлөөлүүлэх үүрэг	25
3. Шүүхийн хураамж	26
4. Бичгэн хэлбэр	27
5. Илт үндэслэлгүй, хөнгөмсгөөр хандсан, урвуулан ашигласан, давтан гаргасан өргөдөл	27
6. Эрх зүйн хамгаалалтын бүх арга хэрэгслийг хэрэглэж дуусгах	28
7. Шууд болон гэнэтийн хор уршиг	29
8. Хохирол барагдуулах боломж	29
9. Урьдчилсан хүсэлтийн шүүлтүүр	30
10. Ижил төрлийн хэргийг нэгтгэх	30
B. Үндсэн хуулийн шүүхийн хэрэг сонгох байдал	31
C. Танхимын шүүх хуралдаан	32
D. Хүлээж авахаас татгалзсан шийдвэрийг давж заалдах нь	35
VI. ҮНДСЭН ХУУЛИЙН ШҮҮХЭД ХАНДАХ	35
A. Материаллаг эрх	35
B. Процедурын баталгаа	38
1. Мэтгэлцэх систем	38
2. Нээлттэй байх зарчим	40
3. Аман процессын ажиллагаа	40
C. Хяналтын хамрах хүрээ	42
1. Хянаж буй хэм хэмжээг тайлбарлах нь	42
2. Хянаж буй хэм хэмжээний хамрах хүрээг өргөтгөх нь	43
3. Гомдлын хүрээг өргөтгөх	44
D. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг зогсоох	45
1. Өргөдлийг буцаасан тохиолдолд хяналтыг зогсоох	46
2. Маргаантай акт хүчин төгөлдөр бус болж хэрэг хянах ажиллагаа зогсох	46
3. Шийдвэр гаргах хугацаа	47

VII. ШИЙДВЭРҮҮД	48
A. Түр арга хэмжээ	48
1. Баталгаажуулах болон түдгэлзүүлэх арга хэмжээ	49
2. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлэх	50
B. Эцсийн шийдвэрүүд	51
1. <i>Ratione personae</i> нөлөө	52
2. <i>Ratione temporis</i> нөлөө	60
3. <i>Ratione materiae</i> нөлөө	63
4. Үндсэн хуулийн шийдвэрийг эцэслэх нь	65
VIII. ЕВРОПЫН ХҮНИЙ ЭРХИЙН ШҮҮХ	66
A. Конвенцод нийцүүлэн тайлбарлах	67
B. Үндсэн хуулийн хяналтыг ЕХЭШ-ээр орлуулах нь	67
1. Эрх зүйн хамгаалалтыг бүгдийг хэрэглэх	68
2. Үр дүнтэй хамгаалуулах эрх: үндсэн хуулийн иж бүрэн гомдол	69
3. Үндсэн хуулийн иж бүрэн гомдлыг дотоодын “шүүлтүүр” болгох нь	72
4. Үндсэн хуулийн хяналтыг ЕХЭК-оор орлуулах нь	75
C. ЕХЭШ болон шударга шүүхээр шүүлгэх эрх	76
D. Дотоодын хэмжээнд хэрэг сэргээх	79
IX. ДҮГНЭЛТ	81

ӨМНӨТГӨЛ

Хуулиар ардчилал тогтоох Европын комисс (Венецийн комисс) нь ардчилал, хууль дээдлэх ёсыг төлөвшүүлэх, хүний болон иргэний эрхийг хангах чиглэлээр олон арван удирдамж, гарын авлага, тайлан гаргадаг. Тус комиссоос хувь хүний үндсэн хуулийн шүүхэд хандах эрхийн талаарх судалгааны тайланг 2021 онд шинэчлэн хэвлэснийг МУИС-ийн Үндсэн хуулийн эрх зүйн хүрээлэнгээс монгол хэлнээ хөрвүүлэн эрхлэн гаргаж буйд баяртай байна.

Монгол Улсад үндсэн хуулийн хяналт бий болж, Үндсэн хуулийн цэцийг байгуулснаас хойш 30 гаран жил болж байна. Энэ хугацаанд иргэд хууль тогтоомж Үндсэн хуульд нийцсэн эсэх зэрэг абстаркт асуудлаар өргөн хүрээнд мэдээлэл (actio popularis)-ийг Цэцэд гаргаж ирсэн. Гэвч үндсэн эрхийн тодорхой зөрчлийг ердийн шүүхээр хянуулсны дараа уул эрх нь зөрчигдсөн хэвээр гэж үзсэн иргэд Цэцэд өргөдөл гаргах зохицуулалтыг бий болгож, Цэцийг Үндсэн хуулийн шүүхийн түгээмэл чиг хандлагад нийцсэн, үндсэн эрх зөрчигдсөн тохиолдлыг хянан шийдвэрлэхэд онцгой үүрэгтэй шүүх болгон хөгжүүлэх эрх зүйн шинэтгэлийг эхлүүлэх явдал нэн чухал билээ. Мөн, иргэний мэдээллийг халах буюу хүрээг нь зохистойгоор хумих, эсхүл Үндсэн хууль зөрчсөн тухай маргаан үүсгэх эх үүсвэр биш, харин нэгэнт үүсгэсэн маргааныг шийдвэрлэхэд ач холбогдолтой үндэслэл, судалгаа гэж үзэх (*amicus curiae*) нь зүйтэй юм.¹

Тус тайланд “үндсэн хуулийн иж бүрэн гомдол” гэж тодорхойлсон нэг бүрчилсэн акт болон түүний үндэслэл болж буй норматив акт үндсэн эрхийг нь зөрчсөн эсэх гомдлыг хувь хүн Үндсэн хуулийн шүүхэд гаргадаг механизмын талаар олон улс орны тэргүүн туршлага оржээ. Мөн үндсэн эрх зөрчигдсөн эсэх тухай маргааныг омбудсмен эсхүл хүний эрхийн бусад байгууллага өөрийн санаачилгаар, эсхүл хувь хүний нэрийн өмнөөс буюу түүний хүсэлтээр аливаа хэм хэмжээ үндсэн хуульд нийцсэн эсэхийг хянуулдаг зохицуулалт олон улсад хэрэгждэг байна.

Хувь хүний үндсэн хуулийн шүүхэд хандах боломжийн талаар өргөн цар хүрээтэй тус судалгааны тайлан нь Монгол Улсад иргэний өргөдлийг үндсэн хуулийн гомдлын агуулгаар хөгжүүлэх, Цэцийн тухай хууль тогтоомжийг шинэчлэхэд төдийгүй олон улсын тэргүүн туршлага, маргаантай асуудлаар гарсан шүүхийн шийдвэр нь манай улсын Үндсэн хуулийн болон хуулийн хэрэглээнд чухал ач холбогдолтой гэдэгт итгэж байна.

УИХ-ын 2021 оны 12 дахь тогтоолоор баталсан Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлд Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай болон Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулиудын шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж

¹ Munkhsaikhan Odonkhuu, *Towards Better Protection of Fundamental Rights in Mongolia: Constitutional Review and Interpretation* (Nagoya University. CALF Books 4. 2014).

Венецийн комисс

өргөн мэдүүлэхээр тусгасан. УИХ-ын Хууль зүйн байнгын хорооноос 2021 оны 09 дүгээр сарын 28-ны өдөр эдгээр хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах, УИХ-д өргөн мэдүүлэх үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан. Ажлын хэсэг дэргэдээ хуулийн төслийг боловсруулахад мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх дэд хэсгүүдийг ажиллуулж байна. МУИС-ийн Үндсэн хуулийн эрх зүйн хүрээлэнгээс энэхүү тайланг 2022 оны зун орчуулсан байсныг Ажлын хэсэг, түүний ахлагч УИХ-ын гишүүн Ц.Мөнх-Оргил сайшааж, тус хүрээлэнтэй хамтран ажилласанд талархаж байна.

“Хувь хүний үндсэн хуулийн шүүхэд хандах эрх шинэчилсэн тайлан”-г орчуулах зөвшөөрөл өгсөн Венецийн комисст, ялангуяа түүний дэд нарийн бичгийн дарга Шнүц Рудолф Дүрр (Schnutz Rudolf DÜRR, Deputy Secretary of the Venice Commission)-т талархаж буйгаа илэрхийлье. Мөн, тайланг орчуулсан тус хүрээлэнгийн гэрээт эрдэм шинжилгээний ажилтан, хууль зүйн магистр, хуульч Н.Энхцэцэг, МУИС-ийн Хууль зүйн сургуулийн оюутан С.Билэгт-Очир, техникийн багт ажилласан эрх зүйч О.Энхжин, МУИС-ийн Хууль зүйн сургуулийн оюутан, тус хүрээлэнгийн дадлагажигч Т.Эмүжин нарт талархаж байна.

О.МӨНХСАЙХАН

МУИС-ийн Үндсэн хуулийн эрх зүйн хүрээлэнгийн захирал,
Хууль зүйн сургуулийн профессор, хууль зүйн доктор

I. ЕРӨНХИЙ ТАЙЛБАР

1. Сүүлийн 70 жилийн хугацаанд хүний эрхийг үндсэн хуулиар хамгаалах шаардлага Европ болон бусад улс орнуудад гарсан. Өнөө үед хүний эрхийг хүндэтгэх нь аливаа ардчилсан нийгмийн нэн чухал хэсэг гэж зүй ёсоор тооцогддог.¹ Үүний үр дүнд үндсэн хуулиар олгогдсон эдгээр эрхээ хувь хүн шууд болон шууд бусаар эдлэх боломжийг хангасан механизм улам бүр чухал болж байна. Энэхүү тайлан нь Венецийн Комиссын гишүүн болон ажиглагч улс орнуудад хүний эрхийн зөрчлийг шүүхээр шийдвэрлэхийн тулд үндсэн хуулийн шүүхэд хандах арга замыг хамарсан болно.² Уг тайлан нь хэрэгжиж ирсэн олон янзын шийдлийг илүү сайн ойлгоход хувь нэмэр оруулах зорилготой.³
2. Тус тайлан нь Венецийн Комиссын CODICES мэдээллийн санд агуулагдаж буй үндсэн хууль, эрх зүйн эх бичвэрүүд дээр үндэслэсэн.⁴ Венецийн Комисс нь Үндсэн хуулийн шийдвэрлэсэн хэргийн тухай цахим мэдээллийн товхимол, CODICES мэдээллийн санд болон энэхүү тайланг шинэчлэхэд хувь нэмрээ оруулсан ажилтнууддаа талархал илэрхийлж байна.
3. Энэхүү тайлан нь есөн хэсгээс бүрдэнэ. Зарим ерөнхий болон удиртгал үгийн дараа (I ба II хэсэг), III бүлэг нь үндсэн хуулийн хяналтын түүхэн хөгжил, хувьслын тоймоор дамжуулан харьцуулсан судалгааны ерөнхий хүрээ, түүнчлэн үндсэн хуулийн хяналтын олон хэлбэр, сүүлийн үеийн хөгжил, чиг хандлагыг тодруулсан. IV бүлэгт үндсэн хуулийн хяналт хийх олон арга замыг шинжилж, үндсэн хуулийн хяналтын ажиллагааг санаачилж болох оролцогчдыг тодорхойлсон. V бүлэгт үндсэн хуулийн шүүхэд хандах хязгаарлалт болон, хувь хүний үндсэн хуулийн хяналт хийлгэх эрх ба үндсэн хуулийн шүүхэд хэт ачаалал үүсгэх эрсдэл хоёрыг тэнцвэржүүлэхэд уг хязгаарлалтын гүйцэтгэх үүргийг тайлбарласан. VI бүлэгт үндсэн хуулийн шүүхэд хандах тухай, тэр дундаа хамгаалагдсан эрхүүд, процедурын ажиллагааны янз бүрийн баталгаа, хяналтын хамрах хүрээг өргөтгөх боломж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг зогсоох

¹ Venice Commission, CDL-STD(1995)015, “The protection of fundamental rights by constitutional courts”, Science and Technique of Democracy, no. 15.

² Энэхүү тайланд багтсан улсууд: Албани, Алжир, Андорра, Аргентин (Ажиглагч улс), Армени, Австри, Азербайжан, Беларусь, Бельги, Босни Герцеговина, Бразил, Болгар (Холбооны гишүүн), Канад (Ажиглагч улс), Чили, Хорват, Кипр, Чех, Дани, Эстони, Финлянд, Франц, Гүрж, Герман, Грек, Унгар, Исланд, Ирланд, Израиль, Итали, Япон (Ажиглагч улс), Казахстан, Солонгос (Бүгд найрамдах улс), Косово, Киргизстан, Латви, Лихтенштайн, Литва, Люксембург, Мальта, Мексик, Молдова, Монако, Монтенегро, Марокко, Нидерланд, Хойд Македон, Норвеги, Палестин (Тусгай статуст), Перу, Польш, Португал, Румын, Орос, Сан Марино, Серби, Словак, Словени, Өмнөд Африк (Тусгай статуст), Испани, Швед, Швейцарь, Тунис, Турк, Украин, Их Британи, Америкийн Нэгдсэн Улс, Уругвай (Ажиглагч улс).

³ Энэхүү тайланд хамрагдсан үндсэн хуулийн шүүхүүдийн хяналт нь Европын Холбооны Шүүхийн хяналтын зарим хэсэгтэй төстэй ч ЕХ-ны хууль тогтоомж болон гишүүн орнуудын үндэсний хууль тогтоомжийн хоорондын хамаарлыг судлаагүй болно.

⁴ CODICES -уудыг www.codices.coe.int хуудаснаас харах боломжтой.

Венецийн комисс

асуудлыг судалсан. VII бүлэгт үндсэн хуулийн хяналтын үр нөлөө, түүний дотор урьдчилсан шийдвэр болон эцсийн шийдвэрийн үр дагаварт дүн шинжилгээ хийсэн. Эцэст нь VIII хэсэгт үндсэн хуулийн хяналтыг дотоодын түвшинд хувь хүмүүст хүртээмжтэй болгоход Европын хүний эрхийн шүүхийн гүйцэтгэх үүргийг шинжилсэн. Тайлангийн төгсгөлд гол дүгнэлт, зөвлөмжийг нэгтгэсэн.

II. УДИРТГАЛ

4. Европын Зөвлөлийн ХБНГУ-ын Байнгын төлөөлөгч ноён Эберхард Кёльш Германы Засгийн газрыг төлөөлөн 2009 оны 4-р сарын 21-ний өдөр илгээсэн захидалдаа үндсэн хуулийн хяналтыг хувь хүмүүст хүртээмжтэй болгох талаарх дүгнэлт авах хүсэлт гаргасан. Тэрээр “ийм судалгаа нь хүний эрхийн зөрчлийг арилгах үндэсний арга хэрэгслийг дэмжихэд үнэтэй хувь нэмэр оруулж, улмаар Европын хүний эрхийн шүүхийн урт хугацааны үр нөлөөг баталгаажуулахад ихээхэн нэмэртэй” гэж онцолсон байдаг. Ноён Харутюня, хатагтай Нуссбергер болон ноён Пакзолай нар илтгэгчээр оролцсон бөгөөд энэхүү тайланг тэдгээрийн үндсэн хуулиудад үндэслэн, Венецийн Комиссын гишүүн, ажиглагч орнуудын үндсэн хуулийн шүүхтэй харилцах ажилтнууд мөн өөрсдийн эрх зүйн системийн тухай мэдээллийн үнэн зөвийг шалгаж ажилласан гишүүдийн оруулсан хувь нэмэрт үндэслэн бэлтгэсэн болно.

5. Анхны судалгааны эхний төслийг (*CDL-AD(2010)039rev.*) Венецийн Комиссын Үндсэн хуулийн хяналтын хамтарсан зөвлөлийн 9-р хурлаар (Венец, 2010 оны 6-р сарын 1-2) хэлэлцсэн. Комисс 2010 оны 9-р сарын эцэс гэхэд энэ бичвэрийн талаар санал асуулгад хариу өгөхийг холбогдох ажилтнуудаас хүссэн. Анхны судалгааг Венецийн Комисс 85-р хурлаар (Венец, 2010 оны 12-р сарын 17-18) баталсан. 2019 онд Венецийн Комисс энэхүү тайлангийн шинэчилсэн хувилбарыг сүүлийн үеийн хөгжил, өөрчлөлтүүдийг багтааж гаргахыг хүсэж дахин холбогдох ажилтнуудад хандсан. Венецийн Комисс үнэ цэнтэй туслалцаа үзүүлсэн холбогдох ажилтнуудад талархал илэрхийлж байна.

6. *Энэхүү шинэчилсэн тайланг Венецийн Комисс 125 дахь удаагийн нэгдсэн хуралдаанаар (Венец, 2020 оны 12-р сарын 11-12) баталлаа.*

III. ТҮҮХЭН ХӨГЖИЛ

A. Үндсэн хуулийн хяналтын хөгжил

7. Үндсэн хуулийн хяналтын санаа нь 18-р зууны эхэн үеийн Их Британийн “Нууц зөвлөл”-ийн үйл ажиллагаанаас үүдэлтэй бөгөөд уг зөвлөл нь хэрэв колони улсын хууль тогтоогчдын актууд нийтлэг эрх зүй (common law) эсхүл Британийн парламентаас тэдгээр колони улсуудад зориулж баталсан хууль тогтоомжтой зөрчилдвөл тухайн актыг хүчингүй болгож байв. Үндсэн хуулийн хяналтыг анх

1803 онд АНУ хэрэгжүүлсэн. АНУ-ын Дээд шүүхийн алдартай хэрэг *Мэдисон э. Марбури*-н шийдвэрээр хэрэв хууль тогтоомж, хэм хэмжээ, засгийн газрын зарим үйл ажиллагаа АНУ-ын Үндсэн хуулийг зөрчсөн тохиолдолд иргэд шүүхэд хандаж, хүчингүйд тооцуулах эрхтэй болсон. Колоничлолын дараах АНУ-д жам ёсны эрх зүйн үзэл баримтлал буюу хувь хүний эрхийг илүү чухалчилдаг эрх зүйн хэм хэмжээ болон иргэд нь төр засгаас тэдний өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхийг шаардаж болох нийгмийн гэрээний үзэл тогтож байв. Институтийн хувьд эрх мэдлийн босоо болон хэвтээ байдлаар хуваасан тогтолцооны гажилт болон ирээдүйд институт хоорондын зөрчил гарах аюул нь ийм зөрчилдөөнөөс зайлсхийх эсхүл түүнийг шийдвэрлэх тогтолцоог бий болгох шаардлагатай байгааг харуулж байсан. *Мэдисон э. Марбури* - н хэргээс хойш АНУ-ын Дээд шүүх нь Үндсэн хуулийн эцсийн тайлбар гаргах эрхтэй байгууллага болсон.

8. Хувь хүн үндсэн хуулийн гомдол гаргах боломжийг анх Европт 1849 оны Германы Үндсэн хуульд (*Paulskirchenverfassung*) тодорхой заасан байсан.⁵ Гэвч уг хууль хүчин төгөлдөр болоогүй. Бельги, Франц, Швейцарт мөн ижил төстэй загварыг хэлэлцсэн боловч мөн л хэрэгжүүлээгүй. 1867 онд Австри улс *Рейхсгерихт* (“Эзэн хааны шүүх”) -д иргэдийн үндсэн хуулиар баталгаажсан эрх зөрчигдсөн гэх гомдлыг хянан шийдвэрлэх эрхийг олгосон.⁶ Норвегийн Дээд шүүх 1866 онд хууль тогтоомжийг үндсэн хуульд нийцэж байгаа эсэхийг хянах эрхтэй гэж өөрийгөө тунхагласан юм⁷ (өнөөгийн Норвегийн Үндсэн хуульд мөн тусгасан болно⁸). 1912 онд Румын Улсын хяналтын шатны шүүх ч мөн үүнтэй адил эрх мэдэлтэй болсон.⁹ Монако 1911 оны Үндсэн хуулиар энэ үүргийг Дээд шүүхэд олгосон ба Дээд шүүх байгуулах үндсийг тавьж, улмаар Үндсэн хуульд баталгаажсан хүний эрх, эрх чөлөөтэй холбоотой зөрчлийг шийдвэрлэхээр 1919 онд Дээд шүүхийг байгуулжээ.

В. Үндсэн хуулийн хяналтын хоёр төрөл: төвлөрсөн бус ба төвлөрсөн систем

9. Түүхээс үзвэл ердийн шүүгчид төвлөрсөн бус хяналтаар үндсэн хуулийн хяналтын гол хэлбэрийг хэрэгжүүлж байв. Жишээлбэл, хамгийн анхны үндсэн хуулийн хяналтын загвар болох Америк загвар нь төвлөрсөн бус хяналтын системийн шинжийг агуулна. Энэ загварын дагуу хувь хүмүүс аливаа хэм хэмжээний акт, нэг бүрчилсэн актыг үндсэн хуульд нийцэж байгаа эсэхийг

⁵ 126 дугаар зүйл, г хэсэг.

⁶ Staatsgrundgesetz über die Einrichtung eines Reichgerichtes, Art. 3 lit. b.

⁷ Holmøyvik, E., “Årsaker til utviklinga av prøvingsretten i Noreg og Danmark”, Tidsskrift for Rettsvitenskap, no. 5 2007, pp. 718-779; Bruzelius, K.M., “Judicial Review within a Unified Country”, World Conference on Constitutional Justice in Cape Town, 2009.

⁸ 2015 оны 6 дугаар сарын 1-нд баталсан Норвегийн Үндсэн хуулийн 89 дүгээр зүйл.

⁹ Conac, G., “Une antériorité roumaine: le contrôle juridictionnel de la constitutionnalité des lois”, Mélanges Slobodan Milacic, Démocratie et liberté: tension, dialogue, confrontation, Bruylant, Belgique, 2007.

ердийн шүүхээр хэлэлцүүлж, тухайн асуудалд дүгнэлт гаргадаг. Зарчмын хувьд тодорхой хэрэгт хамааралтай аливаа эрх зүйн хэм хэмжээ, нэг бүрчлэн зохицуулсан актыг эсэргүүцэх боломжтой. Өөрөөр хэлбэл, тухайн хувь хүн өөрийн оролцож байгаа хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хэрэглэгдэх аливаа хуулийг үндсэн хуульд нийцэж байгаа эсэх талаар асуулт тавьж болно.

10. Гомдол гаргагчийн зүгээс харахад үндсэн хуулийн төвлөрсөн бус хяналтын гол давуу тал нь үндсэн хуульд нийцэж буй эсэх талаар гомдол гаргахаас өмнө хувь хүн шүүхээр эрхээ хамгаалуулах арга замаа ашиглаж дууссан байхыг шаарддаггүй. Төвлөрсөн бус хяналтыг ямар ч шүүгч ердийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аль ч шатанд хийх боломжтой. Тухайн хүн үндсэн хуулийн шүүхэд үндсэн хуулийн талаар тодорхой гомдол гаргах шаардлагагүй. Тиймээс үндсэн хуулийн хяналт ердийн шүүх хуралдаанд оролцож байгаа хүн бүрд нээлттэй.

11. Энэ хэлбэрийн сул тал нь ердийн шүүхүүд нэг хэм хэмжээ үндсэн хуульд нийцэж байгаа эсэх талаар өөр өөрөөр тайлбарлаж болох явдал юм. Энэ нь уялдаа холбоогүй, тодорхойгүй байдал (uncertainty), зөрчилтэй шийдвэрт хүргэж болзошгүй юм. Гэсэн хэдий ч энэ нь хууль эрх зүйн плюрализм болон экспериментийг хөхүүлэн дэмжиж болох бөгөөд бүхий л төвлөрсөн бус системийн адил илүү сайн хууль гаргах үр дүнд хүргэж болно. Өөр нэг сул тал нь үндсэн хуулийн шүүх хүртэл бүхий л замаар давж заалдсанаар шүүх ажиллагааг сунжирсан, зардал ихтэй байдалд хүргэж болно. Хэрэв маргааны талууд давж заалдахаас татгалзвал тухайн хууль үндсэн хуулийн тайлбар гаргасан шийдвэргүйгээр тодорхой бус байдалд үлдэж болно.¹⁰ Гэсэн хэдий ч төвлөрсөн бус хяналт нь үндсэн хуулийн хяналтын сайн хэрэгжиж буй хэлбэр хэвээр байна.¹¹

12. Энэ төрлийн хяналт нь тухайн этгээдийн шүүхэд эрхээ хамгаалах чадвар, хүсэл зориг болон үндсэн эрхийн зөрчлийг шалгах шүүгчийн чадвар, хүсэл эрмэлзлээс хамаарна. Энэ хоёр нөхцөл үргэлж хамтдаа хангагдахгүй байж болно.¹² Эрх зүйн соёлд нь ийм ухамсар сайн төлөвшсөн АНУ, Канад, Ирланд, Норвеги зэрэг улс орнуудад эл систем сайн ажилладаг.

13. Хорьдугаар зуунд төвлөрсөн бус загвараас ялгаатай төвлөрсөн хяналтын загварыг Ханс Келсен 1920 оны Австрийн Үндсэн хуулийн жишээн дээр

¹⁰ Kau, M., Bundesverfassungsgericht und US Supreme Court: Die Bedeutung des United States Supreme Court für die Errichtung und Fortentwicklung des Bundesverfassungsgerichts, Springer, Berlin/Heidelberg, 2007, p.304. f.

¹¹ Venice Commission, CDL(1998)059, Opinion on the reform of Constitutional Justice in Estonia, p.3.

¹² Philippe, X., "Le contrôle de constitutionnalité des droits fondamentaux dans les pays européens", L'effectivité des droits fondamentaux dans les pays de la communauté francophone, AUPELF-URFF Montréal, p. 412.

боловсруулсан.¹³ Төвлөрсөн системээр ихэвчлэн ердийн шүүхийн тогтолцооноос тусдаа бие даасан шүүхэд хэм хэмжээний актууд үндсэн хуульд нийцэж байгаа эсэхийг шалгах, үндсэн хууль зөрчсөн актуудыг хүчингүй болгох бүрэн эрх олгогдсон байдаг. Ийм системд үндсэн хуулийн хяналтыг үндсэн хуулийн шүүх эсхүл дээд шүүх дангаар хэрэгжүүлдэг бөгөөд дээд шүүх хэрэгжүүлэх тохиолдолд хяналтын журмаар хэрэг шийдвэрлэхээс гадна үндсэн хуулийн хяналтыг хэрэгжүүлэх бүрэн эрхийг давхар хэрэгжүүлдэг (жишээлбэл, Эстони).

14. Төвлөрсөн загварт хоёр гол давуу тал бий. Нэгдүгээрт, энэ нь маргааны харьяаллыг илүү нэгдмэл болгодог. Хоёрдугаарт, энэ нь хуулийн хэрэглээг ойлгомжгүй болгож болзошгүй үндсэн хуультай холбоотой асуудлаар санал зөрөлдөөнтэй шийдвэр гаргахаас сэргийлдэг тул хууль зүйн тодорхой байдлын зарчмыг (*legal certainty*) илүү дэмждэг.

15. Төвлөрсөн хяналтын гол сул тал нь ердийн шүүх болон үндсэн хуулийн шүүхийн хооронд хурцадмал байдал, зөрчилдөөн үүсэж болзошгүй юм. Үндсэн хуулийн шүүх ердийн шүүхийн шийдвэрийг хянахдаа ердийн шүүхийн хууль тогтоомжийн хэрэглээ, тайлбарыг дүгнэж, тодорхой хэрэгт хөндлөнгөөс оролцдог. Үндсэн хуулийн шүүх хуулийг зөвхөн хийсвэрээр бус, бас тохиолдол тус бүрээр хянадаг ба гаргаж буй тайлбарууд нь бараг бүх эрх зүйн салбарыг хөндөж, ердийн шүүхийн "өөрийн" хуулийг тайлбарлах уламжлалт үүргийг зөрчиж, тэдний хуулийн зүйл заалт хэрэглэх хүрээг хязгаарладаг.

16. Төвлөрсөн хяналтын тогтолцоотой улс орнууд ихэвчлэн хууль тогтоомж болон хуулийн хүчин чадалтай хэм хэмжээний актуудад үндсэн хуулийн хяналт тавьдаг. Энэ нь үндсэн хуулийн төвлөрсөн хяналтыг нэвтрүүлэхтэй холбоотой уламжлалт зорилтуудын нэг болох үндсэн хуулийн дэг журмыг хамгаалахтай нийцэж байгаа юм. Хувь хүний эрхийг хамгаалахын ач холбогдлыг хүлээн зөвшөөрөх хандлага ихсэх хэрээр нэг бүрчилсэн актыг хянан шалгах явдал мөн нэмэгдэж байна.

17. Мөн үндсэн хуулийн дэг журам болон хувь хүний эрхийг хамгаалах гэсэн хос зорилго нь мөн авторитар дэглэмээс ардчилалд шилжсэн орнууд төвлөрсөн хяналтын загварыг илүү сонирхож сонголт хийхэд хүргэсэн.¹⁴ Тухайлбал, Дэлхийн хоёрдугаар дайны дараа Герман, Итали уг загварыг нэвтрүүлж, 1970-аад

¹³ Анхны Үндсэн хуулийн шүүх Австрид биш, харин 1920 оны 2 дугаар сард Чехословак улсад байгуулагдсан. Хэдэн сарын дараа буюу 1920 оны 10 дугаар сард Австрийн шүүх, жилийн дараа 1921 оны 10 дугаар сард Лихтенштайны Үндсэн хуулийн шүүх байгуулагджээ.

¹⁴ Л. Гарликки нь "Дарангуйллын засаглалын дараа шүүхүүдийн бүтцийн бие даасан байдал, оюуны хүчтэй байдлын баталгаа хангалтгүй байсан" гэж дүгнэсэн. (Garlicki, L., "Constitutional courts versus supreme courts", *International Journal of Constitutional Law*, vol. 5(1), 2007, p. 45, Дараахаас харах боломжтой: <http://icon.oxfordjournals.org/cgi/content/full/5/1/44#FN59#FN59>),

Венецийн комисс

оны сүүлээр Испани,¹⁵ Португали нэвтрүүлсэн. Түүнчлэн коммунизм нуран унасны дараа Эстониыг эс тооцвол Төв болон Зүүн Европын бараг бүх улсууд төвлөрсөн хяналтын загварыг нэвтрүүлсэн.

18. Өнөөдөр ихэнх улс орнууд төвлөрсөн хяналтын системтэй байна (жишээлбэл, Албани, Алжир, Андорра, Армен,¹⁶ Австри, Азербайжан, Бельги, Беларусь, Хорват, Чех, Франц, Гүрж, Герман, Унгар, Итали, Бүгд Найрамдах Солонгос, Латви, Лихтенштайн, Литва, Люксембург, Марокко, Хойд Македон, Польш, Орос, Сан-Марино, Серб, Словак, Словени, Испани, Тунис, Турк, Украин). Цөөхөн хэдэн улс орнуудад үндсэн хуулийн хяналтын тогтолцоо нь бүхэлдээ төвлөрсөн бус загвартай байдаг (жишээлбэл, Канад, Дани, Финланд, Исланд, Норвег, Швед, Америкийн Нэгдсэн Улс). Латин Америкийн зарим орнууд өргөн хүрээтэй хяналт, хүчтэй дээд шүүхтэй Америкийн загварыг дагаж мөрддөг (жишээлбэл, Бразил, Мексик гэх мэт), бусад нь (жишээлбэл, Перу, Чили) тусдаа үндсэн хуулийн шүүхтэй байдаг.

19. Үндсэн хуулийн хяналтын системийг зөвхөн төвлөрсөн бус эсхүл төвлөрсөн гэж ангилахад бэрхшээлтэй. Жишээлбэл, Өмнөд Африкт ердийн шүүх аливаа хуулийг үндсэн хууль зөрчсөн гэж үзэж болох ч уг тогтоолыг нь Үндсэн хуулийн шүүх баталгаажуулж байж л хүчин төгөлдөр болдог.

С. Сүүлийн үеийн хөгжил, чиг хандлага

20. Дэлхийн хоёрдугаар дайны дараа үндсэн эрхийг хамгаалахын ач холбогдол өсөн нэмэгдэхийн хамтаар үндсэн хуулийн шүүхээр дамжуулан хувь хүний суурь эрхийг хамгаалах, үндсэн хуулийн шүүхэд хандах боломж олгох механизмыг нэвтрүүлэх тодорхой парадигмийн шилжилт бий болсон. Тодруулбал, эдгээр механизм нь хувьд хүнд үндсэн эрхэд нь халдсан байж болзошгүй норматив буюу нэг бүрчилсэн акт үндсэн хуульд нийцэж буй эсэхийг хянуулахаар үндсэн хуулийн шүүхэд хандах боломжийг олгодог.

21. Үндсэн хуулийн шүүх нь сонгогчдоос шууд сонгогддоггүй бөгөөд тэдний өмнө хариуцлага хүлээдэггүй хэр нь парламентын баталсан актуудыг хүчингүй болгож болдог тул үндсэн хуулийн хяналт нь парламентын эрх мэдлийг сорьж,

¹⁵ Испани 1978 оноос өмнө “Tribunal Constitutional Guarantees” нэртэй Үндсэн хуулийн шүүхтэй байсныг тэмдэглэх нь зүйтэй. Тус шүүх нь 1931 оны Бүгд Найрамдах Улсын Хоёрдугаар Үндсэн хуулийн дагуу байгуулагдсан бөгөөд 1978 он хүртэл үргэлжилсэн цэргийн дарангуйлал тогтсон үе болох Испанид иргэний дайн дэгдэх хүртэл буюу 1936 он хүртэл ажиллаж байсан.

¹⁶ Бүгд Найрамдах Армен Улсын Үндсэн хууль болон Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн бүх эшлэл нь энэхүү шинэчилсэн тайланг гаргах үед хүчин төгөлдөр мөрдөж байсан эх сурвалжид үндэслэсэн болно. Гэхдээ, Арменд үндсэн хуулийн шинэчлэл үргэлжилж байгаа бөгөөд Бүгд Найрамдах Армен улсын эрх зүйн зохицуулалттай холбоотойгоор энэхүү тайланд дурдсан зарим эшлэл, дүгнэлтүүд өөрчлөгдсөн байж болзошгүй.

мөн сонгогдоогүй, хариуцлага хүлээхгүй шүүгчдээс засгийн газар эмээх байдалд хүргэж болзошгүй юм. Гэсэн хэдий ч үндсэн хуулийн шүүхийн бүрэлдэхүүнийг ихэвчлэн ардчилсан замаар сонгогдсон, хариуцлага хүлээдэг байгууллагаас тодорхойлон бүрдүүлэхийн зэрэгцээ үндсэн хуулийн дэг журам, хувь хүний эрхийг хамгаалах гэсэн хоёр зорилго нь үндсэн хуулийн шүүхэд ерөнхийдөө парламентаас баталсан актуудыг хүчингүй болгох хангалттай хууль ёсны эрх мэдлийг олгодог. Тийм ч учир парламентын эрх мэдлийг хадгалахын тулд парламентаас гаргасан хууль тогтоомжийн үндсэн хуулийн хяналтыг нэвтрүүлэхээс татгалзсаар ирсэн уламжлалтай улс орнууд ч үндсэн хуулийн хяналтыг нэвтрүүлэх нь нэмэндэж байна.

22. 2008 онд Франц улс хууль тогтоомж үндсэн хуульд нийцэж байгаа эсэхэд одоо байгаа урьдчилсан (*a priori*)¹⁷ хяналтын зэрэгцээ хууль батлагдсаны дараах (*a posteriori*) хяналтыг нэвтрүүлсэн. Францад Төрийн Зөвлөл (*Conseil d'Etat*) нь зөвхөн хууль тогтоомжоос доогуур эрэмбэтэй хэм хэмжээг үндсэн хуульд нийцэж байгаа эсэхийг хянах эрхтэй байдаг. Франц улс хууль тогтоомжийг шүүхээр хянадаг уламжлалт байдлаа орхиж, *Үндсэн хуульд нийцсэн эсэх талаарх нэн тэргүүний асуултын журам (Question Prioritaire de Constitutionnalité* буюу “*QPC*”) нэвтрүүлсэн.¹⁸ Энэ журам нь аливаа хувь хүн ердийн шүүгчид хандан ‘тухайлсан эрх зүйн хэм хэмжээ Үндсэн хуулиар баталгаажуулсан эрх, эрх чөлөөг нь хязгаарлаж байгаа’ гэсэн үндэслэлээр гомдол гаргах боломжийг олгодог. Дараа нь шүүгч уг асуудлыг Төрийн зөвлөл эсхүл давж заалдах шатны шүүхэд шилжүүлэх эсэхийг шийдэх бөгөөд улмаар уг асуудлыг үндсэн хуулийн хяналт хийлгэхээр Үндсэн хуулийн зөвлөлд (*Conseil constitutionnel*) шилжүүлэх эсэхийг шийднэ. Алжир¹⁹ болон Марокко²⁰ өөрсдийн үндсэн хуульд энэ журмыг нэвтрүүлсэн байна.

23. Тухайлбал, Их Британи нь уламжлалаараа парламентын засаглалыг төрийн бусад салбараас илүүд авч үздэг. Парламентын бүрэн эрхт байдлын тухай онолоор Их Британийн парламент аливаа хуулийг батлах эсхүл хуулийн хүчин төгөлдөр байдлыг “дуусгаж” болдог бөгөөд тус улсын хувьд хууль зүйн дээд эрх мэдэлтэй байна. Ерөнхийдөө шүүх улсынхаа хууль тогтоомжийг хүчингүй болгож болохгүй ба парламент ирээдүйн парламентын хувьд өөрчлөх боломжгүй хууль баталж болохгүй. Гэхдээ 1998 онд Их Британийн Хүний эрхийн тухай хууль батлагдсанаас хойш дээд шатны шүүхүүд Их Британийн ердийн хууль

¹⁷ *Priori* хяналтыг зөвхөн үндсэн хуульд заасан, эсхүл үндсэн хуулийн шүүх байгуулах аливаа хуульд заасан тодорхой этгээд санаачилж болох ба уг хяналтыг хувь хүмүүс ингэх боломжгүй.

¹⁸ Францын 2008 оны 7 дугаар сарын 23-ний Үндсэн Хууль.

¹⁹ 2020 оны 11-р сарын 1-ний өдөр нэмэлт өөрчлөлт оруулсан Алжирын Үндсэн хуулийн 195 дугаар зүйл. 2020 оны 11-р сарын 1-ний өдрийн Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн дагуу Үндсэн хуулийн зөвлөлийг үндсэн хуулийн шүүх болгон байгуулна гэдгийг тэмдэглэх нь зүйтэй.

²⁰ Мароккогийн Үндсэн хуулийн 133 дугаар зүйл.

тогтоомжийг Европын хүний эрхийн конвенцоор хамгаалагдсан хүний эрхтэй²¹ нийцэж байгаа эсэхийг шалгаж болдог болсон.²² Үндсэн эрхийг шүүхээр хамгаалах асуудал Их Британид чухал болж байгаа бөгөөд хуулийн үл нийцлийн талаарх шүүхийн тогтоол нь парламентад нөлөөтэй байдаг. Гэсэн хэдий ч шүүх аливаа хэм хэмжээг дээр дурдсан эрхүүдтэй нийцэхгүй гэж үзсэн байсан ч хууль хүчин төгөлдөр хэвээр байх бөгөөд түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох асуудал бүхэлдээ парламентад үлдэнэ.²³ Түүнчлэн шүүхүүд захиргааны актыг хянах цогц систем бий болгосон ба үүнд тэдгээрийн хууль ёсны байдал, конвенцын эрхтэй нийцэж буйг хянах хяналт мөн багтана.

24. Нидерланд хууль тогтоомжийн үндсэн хуулийн хяналтыг шууд хориглосон цорын ганц улс юм. Нидерландын Үндсэн хуульд хувь хүн хууль тогтоомжийг үндсэн хуульд нийцэж байгаа эсэх тухай гомдол гаргах арга замыг заагаагүй ба шууд бусаар урьдчилан хүсэлт гаргах ч боломжгүй. Нидерландын Үндсэн хуулийн 120 дугаар зүйлд “Парламентаас баталсан хууль тогтоомж болон олон улсын гэрээ хэлэлцээрийг Үндсэн хуульд нийцэж байгаа эсэхийг шүүх хянахгүй” гэж заасан. Энэ утгаараа хууль тогтоох байгууллага нь хууль тогтоомжийг үндсэн хуульд нийцүүлэх эцсийн эрх мэдэлтэй байна. Гэхдээ шүүх тодорхой хэмжээнд парламентаас баталсан хууль тогтоомжийн зэрэглэлээс доод түвшний актууд Үндсэн хуульд нийцэж байгаа эсэхийг хянах боломжтой. Түүнчлэн шүүхүүд дотоодын хууль тогтоомж, тэр дундаа парламентын гаргасан хууль тогтоомжийг олон улсын гэрээ болон олон улсын байгууллагын шийдвэрийн шууд хэрэгжих зүйл заалтуудтай нийцэж байгаа эсэхийг хянах үүрэгтэй. Хэрэв дотоодын хууль олон улсын эрх зүйг зөрчсөн гэж шүүх үзвэл тухайн авч хэлэлцэж буй хэрэг маргаанд уг хуулийг хэрэглэхгүй байж болно. Эдгээр олон улсын эрх зүйн олон заалтууд нь Нидерландын үндсэн хуулийн эрх зүйтэй ижил төстэй тул Нидерланд улсыг үндсэн хуулийн хяналтыг шууд бусаар хангасан гэж үзэж болно.

25. 2010 онд анхны судалгааг гаргаснаас хойш хэд хэдэн улс хувь хүн үндсэн хуулийн шүүхэд хандах боломжийг өргөжүүлсэн. Унгар 2012 онд Үндсэн хуулийн шүүхэд хувь хүн гомдол гаргах эрхийг нээж, өмнө нь байсан *actio popularis*-ыг орлуулжээ. Мөн онд Туркийн Үндсэн хуулийн шүүх 2010 онд хувь хүн гомдол гаргах журмыг нэвтрүүлсний дараа анхны гомдлоо хүлээн авсан. Тун саяхан

²¹ Хүний эрхийн тухай хуульд үндэслэсэн хууль тогтоомжийг хянах нь Шотланд, Уэльс, Умард Ирландын хууль тогтоох байгууллагуудад хамаарна. Эдгээр хууль тогтоогчдын хувьд Конвенцод заасан эрхтэй нийцэхгүй байгаа хууль тогтоомжийг *ultra vires* буюу тухайн хууль тогтоох эрх мэдлээ хэтрүүлэн баталсан хууль гэж үзэж болно.

²² 1998 оны Хүний эрхийн тухай актын 4 дүгээр зүйлийг дараахаас харах боломжтой: <https://www.legislation.gov.uk/ukpga/1998/42/contents>. Энэ асуудлаарх Брекситын үр нөлөөг одоо ч харах боломжтой.

²³ Kavanagh, A., *Constitutional Review Under the UK Human Rights Act*, Cambridge University Press, Cambridge, 2009, pp. 455.

Украин 2016 онд Үндсэн хуулийн шүүхэд гомдол гаргах эрхийг хувь хүмүүст олгосон²⁴ бөгөөд үүнийг нь 2019 онд Литва мөн тийнхүү шийдсэн.

IV. ХУВЬ ХҮН ҮНДСЭН ХУУЛИЙН ХЯНАЛТАД ХАНДАХ ТӨРЛҮҮД

26. Үндсэн хуулийн шүүхэд ерөнхийдөө хувь хүн эсхүл төрийн тодорхой байгууллагууд хандаж болдог. Хувь хүн шүүхэд хандах асуудлын хувьд энэхүү тайлан шууд болон шууд бус хандалтыг ялгаж заагласан. Шууд хандалт гэдэг нь гуравдагч этгээдээр дамжуулалгүйгээр Үндсэн хуулийн шүүхэд шууд өргөдөл гаргах эрх зүйн бүхий л боломжийг хэлнэ. Үүний эсрэгээр, шууд бус хандалт гэдэг нь хувь хүн өөр төрийн байгууллагаар дамжуулан үндсэн хуулийн шүүхэд хандахыг ойлгоно. Судалгаанд хамрагдаж буй ихэнх улс орнууд хувь хүмүүст үндсэн хуулийн шүүхэд шууд хандах зарим боломжийг олгосон. Олон улс орнууд шууд болон шууд бус хандалтын аргыг хослуулсан холимог системтэй байна.

27. Олон төрлийн эрх зүйн актыг үндсэн хуулийн хэм хэмжээтэй нийцэж байгаа эсэхийг хянуулах боломжтой. Энэхүү тайлангийн зорилгоор, Венецийн Комисс нь нэг бүрчилсэн акт болон норматив актыг ялгаж үзсэн болно. Үүнд, нэг бүрчилсэн акт нь тодорхой хэргийг шийдвэрлэж буй төрийн оролцогч (захиргааны байгууллага, шүүх)-ийн аливаа үйлдлийг хэлнэ.²⁵ Харин, норматив акт нь харин хуулийн хүчин чадалтай ерөнхий хууль, хэм хэмжээний акт болон олон улсын гэрээ²⁶, тухайлж хаягласан тодорхой эзэнгүй, нийтээр дагаж мөрдөх үйлчлэл бүхий гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагын тогтоол, дүрэм, орон нутгийн өөрөө удирдах байгууллагын ерөнхий журам хамаарна.

A. Шууд хандалт

28. Олон улс оронд өргөдөл гаргагч нь үндсэн хуулийн шүүхэд норматив болон нэг бүрчилсэн актыг өөрсдийн хэрэгт хамааралтайгаар хянуулах, эсхүл *actio popularis* зарчмын дагуу хийсвэрээр хянуулах хүсэлт шууд гаргаж болно.

²⁴ Venice Commission, CDL-AD(2016)034, Opinion on the draft Law on the Constitutional Court of Ukraine, paras. 67-68.

²⁵ Нэг бүрчилсэн акт нь ихэвчлэн: “захиргааны хэргийн шүүхээр хянуулах боломжгүй төрийн эрх бүхий байгууллагын шийдвэр болон ердийн шүүхийн эцсийн шийдвэр; холбогдох эрх бүхий байгууллагаас гаргасан эрх зүйн акт буюу бусад акт зэрэг шийдвэрийн албан ёсны шалгуурыг хангаагүй боловч хувь хүн, хуулийн этгээдийн эрх, хуулиар хамгаалагдсан ашиг сонирхлыг шууд хөндсөн, хөндөж болзошгүй шийдвэр, бусад акт; түүнчлэн зарим системд нийтлэг хэм хэмжээ биш бөгөөд зөвхөн нэг хүнд хандсан эсхүл фактуудыг тусгайлан хөндсөн актууд байна (“нэг бүрчилсэн хууль”).” (Venice Commission, CDL-AD(2018)012, Georgia - Amicus curiae brief for the Constitutional Court of Georgia on the effects of Constitutional Court decisions on final judgments in civil and administrative cases, para. 25).

²⁶ Олон улсын гэрээний заалтууд нь үндсэн хуулийн хүчин чадлын хувьд бага бол норматив акт гэж үзнэ.

29. Янз бүрийн субъект үндсэн хуулийн шүүхэд шууд хандах эрхтэй байдаг. Ихэнх улс орнууд аливаа хүнийг үндсэн хуулийн гомдол гаргахыг зөвшөөрдөг. Зарим улс орнууд хуулийн этгээдийн гомдол гаргах эрх зүйн байдлыг зохицуулдаг (жишээ нь, Австри, Армени, Бельги, Герман, Испани, Словени, Литва, Монтенегро, Швейцар, Серб, Киргизстан, Орос, Турк). Зарим нь бүр засаг захиргааны нэгжүүдийг хүртэл үндсэн хуулийн талаар гомдол гаргахыг зөвшөөрдөг (жишээлбэл, Герман, Орос). Цөөн хэдэн улс иргэдэд хувь хүний үндсэн хуулийн гомдол гаргах эрхийг хязгаарладаг (жишээлбэл, Хойд Македон, Орос).

1. Хувь хүний гомдол

30. Хувь хүн өөрийн тухайн хэрэг маргаантай хамааралтай асуудлаар "үндсэн хуулийн иж бүрэн гомдол" эсхүл "норматив үндсэн хуулийн гомдол" гэсэн хоёр төрлийн гомдлыг гаргаж болно.²⁷ Үндсэн хуулийн иж бүрэн гомдол нь нэг бүрчилсэн акт болон аливаа үндэслэл болж буй норматив актын үндсэн хуульд нийцсэн эсэх тухай гомдол байдаг бол норматив үндсэн хуулийн гомдол нь зөвхөн норматив актын үндсэн хуульд нийцэх эсэхийг шалгадаг.

31. Тодорхой хэрэгт төвлөрсөн бус хяналт байх шаардлагатай. Төвлөрсөн бус хяналтын систем нь үндсэн хуулийн иж бүрэн гомдлыг шийдвэрлэхэд ихэвчлэн хэрэглэгддэг. Өөрөөр хэлбэл, тодорхой хэрэгт хамааралтай нэг бүрчилсэн эсхүл норматив актын эсрэг гомдол гаргаж болно. Энэ нь хувь хүний эрхийг хамгаалах уламжлалт зорилттой нийцдэг. Үүний эсрэгээр, төвлөрсөн хяналт нь абстракт байж болохын зэрэгцээ тодорхой хэрэгт хамааралтай байж болно.

а. Үндсэн хуулийн иж бүрэн гомдол

32. Хувь хүн өөрийн үндсэн эрхийг зөрчсөн төрийн эрх бүхий байгууллагын аливаа нэг бүрчилсэн актын эсрэг үндсэн хуулийн иж бүрэн гомдол гаргаж болно. Үндсэн хууль зөрчсөн аливаа нэг бүрчилсэн акт нь үндсэн хуульд бүрэн нийцсэн норматив актыг үндсэн хууль зөрчиж хэрэглэснээс үүдэлтэй байж болох ч үндсэн хуульд нийцээгүй норматив актад үндэслэгдсэн байж бас болно. Үндсэн хууль зөрчсөн норматив хэм хэмжээний актад үндэслэгдсэн тохиолдолд заавал үндэс суурь болсон норматив актын эсрэг үндсэн хуулийн бүрэн гомдол гаргаж болно.

33. Практикт, хүний эрхийн зөрчил ихэнхдээ үндсэн хууль зөрчсөн хуулийг "техникийн хувьд зөв" хэрэглэснээс бус харин үндсэн хуультай үл нийцэх нэг бүрчилсэн актын үр дагавар байдаг ба энэхүү акт үндсэн хуультай нийцсэн хуульд үндэслэгдсэн байж болно. Иймээс хүний эрхийн зөрчил нь ихэвчлэн

²⁷ Герман хэлэнд хэрэглэгддэг нэр томъёо нь "unechte Grundrechtsbeschwerde" (Venice Commission, CDLJU(2001)022, Report "Der Zugang des Einzelnen zur Verfassungsgerichtsbarkeit im europäischen Raum", p. 26).

үндсэн хуульд нийцсэн норматив актад үндэслэсэн үндсэн хууль зөрчсөн нэг бүрчилсэн актаас үүддэг тул²⁸ хувь хүний өргөдлөөр нэг бүрчилсэн захиргааны акт, шүүхийн шийдвэрийг үндсэн хуульд нийцэж буй эсэхийг хянах хандлагатай байна.²⁹ **Венецийн Комисс үндсэн хуулийн иж бүрэн гомдлыг илүүд тооцож байна. Учир нь энэ арга зам нь үндсэн хуулийн шүүхэд хувь хүн хандах хамгийн өргөн хүрээтэй хэлбэр бөгөөд хувь хүний эрхийг хамгаалах хамгийн цогц хамгаалалт юм.**³⁰

34. Үндсэн хуулийн иж бүрэн гомдол гаргах боломжтой улсууд гэвэл Албани, Андорра, Австри, Бельги, Босни Герцеговина, Хорват, Кипр, Чех, Герман, Лихтенштайн, Мальта, Монтенегро, Перу, БНСУ,³¹ Серби, Словени, Өмнөд Африк, Испани,³² Швейцар, Словак байна.

b. Норматив үндсэн хуулийн гомдол

35. Норматив үндсэн хуулийн гомдол нь үндсэн хууль зөрчсөн норматив актыг хэрэглэхийн эсрэг чиглэсэн байдаг. Хувь хүн норматив актад үндэслэсэн нэг бүрчилсэн акт өөрийнх нь үндсэн эрхийг зөрчсөнтэй холбоотойгоор норматив актыг нь хянуулахаар үндсэн хуулийн шүүхэд гомдол гаргаж болно.³³ Иймд хэдийгээр тухайн хэрэгт хамааралтайгаар хяналт хийх ч гомдлын гол агуулга нь

²⁸ Venice Commission, CDL-AD(2011)040, Opinion on the Law on the Establishment and Rules of Procedure of the Constitutional Court of Turkey, para. 7; Venice Commission, CDL-AD(2004)24, Opinion on the draft constitutional amendments with regard to the Constitutional Court of Turkey, para. 4.

²⁹ Venice Commission, CDL-AD(2008)029, Opinion on the draft laws amending and supplementing 1) the Law on Constitutional Proceedings and 2) the Law on the Constitutional Court of Kyrgyzstan, para. 23; Venice Commission, CDL-AD(2011)018, Opinion on the draft constitutional law on the constitutional chamber of the Supreme Court of Kyrgyzstan, paras. 27-28; Venice Commission, CDL-AD(2015)014, Joint Opinion on the draft law "On introduction of changes and amendments to the Constitution" of the Kyrgyz Republic, paras. 88-89.

³⁰ Venice Commission, CDL-AD(2013)034, Opinion on Proposals Amending the Draft Law on the Amendments to the Constitution to strengthen the independence of judges of Ukraine, para. 11.

³¹ Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн 68.1-д зааснаар "Үндсэн хуулиар баталгаажсан үндсэн эрх нь шүүхийн шийдвэрээс бусад, төрийн эрх мэдлээ хэрэгжүүлсэн буюу эс хэрэгжүүлсний улмаас зөрчигдсөн аливаа этгээд үндсэн хуулийн гомдлоо хянан шийдвэрлүүлэхээр Үндсэн хуулийн шүүхэд хандаж болно. Хэрэв бусад хууль тогтоомжоор өөр бусад эрх зүйн хамгаалалт заасан бол эдгээр бүх эрх зүйн хамгаалалтыг дуусгахгүйгээр үндсэн хуулийн гомдол хянан шийдвэрлүүлэхээр хүсэлт гаргаж болохгүй."

³² Испанийн *amparo*-г үндсэн хуулийн иж бүрэн гомдол гэж үзвэл зохино. Учир нь тус ажиллагаа нь Үндсэн хуулийн шүүхийн өмнө эцсийн шатны журмаар явагддаг. 2007 оны шинэчлэлд *amparo*-г хэрэгжүүлэх шинэ нөхцөлийг тусгасан нь тухайн хэрэгт хөндөгдсөн асуудал нь заавал "үндсэн хуульд хамааралтай" байхыг шаардсан явдал юм. Испанийн *amparo*-г Латин Америкийн ихэнх орнуудад (Чили, Перу, Аргентин, Мексик гэх мэт) байдаг *recursos de amparo*-тай андуурч болохгүй. *Recursos de amparo* нь тухайн хувь хүнд өөрийн эрхээ үндсэн хуулийн шүүхээр бус ердийн шүүхээр хамгаалуулах боломжийг олгодог өөр төрлийн үндсэн хуулийн гомдол бөгөөд эцсийн шатанд үндсэн хуулийн шүүхэд хандах боломжтой.

³³ Venice Commission, CDL-AD(2018)012, Georgia - Amicus curiae brief for the Constitutional Court of Georgia on the effects of Constitutional Court decisions on final judgments in civil and administrative cases, para. 30.

Венецийн комисс

нэг бүрчилсэн актын норматив үндэслэл байхаас биш, нэг бүрчилсэн акт үндсэн хуульд нийцэж буй эсэх асуудал биш юм. Үүний үр дүнд норматив акт хэрэглэсэн нэг бүрчилсэн актыг Үндсэн хуулийн шүүхээр хэлэлцэхгүй ба, Үндсэн хуулийн шүүх норматив актын хэрэгжилтийн хүрээнд үүсэх асуудалд анхаарал хандуулах боломжгүй юм.

36. Норматив үндсэн хуулийн гомдлын гол үндэслэл нь хувь хүний эрхээс илүүтэй үндсэн хуулийн дэг журмыг хамгаалах явдал юм. Мөн тус төрлийн гомдол үндсэн хуулийн шүүхийн хэт их ачааллын эрсдэлийг бууруулдаг. Онолын хувьд үндсэн хуулийн шүүх болон ердийн шүүх хоорондын харилцаа нь үндсэн хуулийн иж бүрэн гомдлын механизмаас илүү норматив үндсэн хуулийн гомдлын үед бага зөрчилдөөнтэй байх хандлагатай. Учир нь Үндсэн хуулийн шүүх ердийн шүүхийн норматив актын хэрэглээг шууд хянахгүй.³⁴ Гэхдээ хүний эрхийн ихэнх зөрчлүүд үндсэн хуульд нийцээгүй норматив актаас илүүтэй үндсэн хуульд нийцээгүй нэг бүрчилсэн актаас шалтгаалсан байдаг тул хүний эрхийн олон зөрчил норматив гомдлоор шийдэгддэггүй. Иймээс **хэрэв үндсэн хуульд нийцээгүй асуудал хэм хэмжээнд өөрт нь биш харин үүний хэрэглээнд оршиж байвал норматив үндсэн хуулийн гомдлын механизм үр дүнтэй арга хэмжээ болж чаддаггүй.**³⁵

37. Норматив үндсэн хуулийн гомдлын механизм (ихэвчлэн үндсэн хуулийн бусад гомдлын төрөлтэй хамт) тухайлбал Армени,³⁶ Австри, Бельги,³⁷ Эстони,³⁸ Гүрж, Унгар,³⁹ Польш, Латви, Люксембург, Орос, Румын, Украин улсад хэрэглэгдэж байна. Украинд норматив үндсэн хуулийн гомдлын механизмыг

³⁴ Sadurski, W. (ed.), *Rights before Courts: A Study of Constitutional Courts in Postcommunist States of Central and Eastern Europe*, (2nd ed.), Springer Netherlands, Dordrecht, 2014, p.36.

³⁵ Venice Commission, CDL-AD(2016)034, *Ukraine - Opinion on the draft Law on the Constitutional Court*, para. 38; Venice Commission, CDL-AD(2018)012, *Georgia - Amicus curiae brief for the Constitutional Court of Georgia on the effects of Constitutional Court decisions on final judgments in civil and administrative cases*, para. 31.

³⁶ Арменийн Үндсэн хуулийн 169(8)-д зааснаар "Шүүхийн эцсийн шийдвэр гарч, шүүхээр эрхээ хамгаалуулах эрх зүйн хамгаалалтын бүхий л арга хэрэгсэл дуусаж, өөрийнх нь хэрэгт хэрэглэсэн эрх зүйн хэм хэмжээний актын холбогдох заалт үндсэн хуультай харшилж байгаа ба үүнээс болж Үндсэн хуулийн 2 дугаар бүлэгт хамгаалагдсан үндсэн эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж маргаж байгаа тусгайлсан хэрэгт хамаарах хүн бүхэн тухайн заалтын хэрэгжиж буй практик тайлбарыг мөн хамааруулан Үндсэн хуулийн шүүхэд хандаж болно.

³⁷ Venice Commission, CDL-JU(2008)032, *Report on the "Introduction of a Constitutional Review of Laws: Benefit, Purpose and Modalities"*, para. 7.

³⁸ Хуучин коммунист орнуудаас ялгаатай нь Эстони тусдаа үндсэн хуулийн шүүх байгуулаагүй. 1992 онд батлагдсан Үндсэн хуулиар Дээд шүүхэд (Риигикохус) ердийн болон үндсэн хуулийн шүүх гэсэн давхар чиг үүргийг олгосон. Уг шүүхэд Үндсэн хуулийн хяналтын танхим гэж тусдаа байдаг. Хувь хүмүүс Улсын дээд шүүхэд зөвхөн Ерөнхийлөгч болон парламентын зөвлөлийн нэг бүрчилсэн зарим актын эсрэг шууд гомдол гаргаж болно. Гэхдээ хувь хүмүүс захиргааны шүүхийн шийдвэрийг Дээд шүүхэд хянан хэлэлцүүлэх замаар бусад нэг бүрчилсэн актыг хянуулахаар хандаж болно.

³⁹ Venice Commission, CDL-AD(2012)009, *Opinion on Act CLI of 2011 on the Constitutional Court of Hungary*, para. 26.

хувь хүнд үр дүнтэй арга хэрэгсэл байлгахын тулд Үндсэн хуулийн шүүх болон ердийн шүүх хоёрыг хамтран ажиллахыг шаарддаг. Үндсэн хуулийн шүүх хянагдаж буй норматив акт үндсэн хуулийн дагуу ч хэрэглээ нь үндсэн хуультай нийцээгүй гэж үзвэл энэ тухай шийдвэрийнхээ үндсэн хэсэгт заана. Хувь хүн шүүхийн эцсийн шийдвэрийг хянуулахаар өөрийн хэргийг дахин нээхийн тулд үндсэн хуулийн шүүхийн энэ шийдвэрийг ердийн шүүхэд ашиглаж болно. Энэ утгаараа тус гомдол үндсэн хуулийн иж бүрэн гомдолтой дөхүү юм.⁴⁰ Гэвч энэ үйл явц нь Үндсэн хуулийн шүүх болон ердийн шүүх хоёрыг илүү сайн хамтын ажиллагаа, харилцан ойлголцолтой байхыг шаардана. Мөн тухайн зүйл заалтын талаар цаашид гарах гомдлыг хүлээн авах боломжгүй болно.⁴¹

2. *Actio popularis*

38. Үндсэн хуулийн шүүх тодорхой хэрэгт холбогдуулан тухайн хууль, тогтоомж, дүрэм журмыг хянахаас гадна тэдгээрийг абстракт байдлаар хянах боломжтой юм. Абстракт хяналт нь ерөнхийдөө *actio popularis* хэлбэрээр явагддаг. Учир нь абстракт хяналт нь тодорхой хэрэг, эсвэл хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай хамааралгүй байдаг тул ихэвчлэн төвлөрсөн хяналтын системд хэрэглэгддэг.

39. *Actio popularis* зарчмаар аливаа этгээдэд ямарваа нэг норматив акт батлагдсаны дараа тухайн акт өөрт нь шууд болон тухайн мөчид нөлөөлж буй гэдгийг нотлох шаардлагагүйгээр тус акттай холбогдуулан гомдол гаргах эрх олгодог. *Actio popularis* нь аливаа хувь хүнд үндсэн хуулийн шүүхэд гомдол гаргах боломж олгодог тул үндсэн хуулийн шүүхэд хандах хамгийн өргөн хүрээтэй арга зам юм.⁴² *Actio popularis* нь иргэн бүрд үндсэн хуулийн хамгаалагч болох боломжийг олгодог. Жишээлбэл, Өмнөд Африкт хувь хүн нийтийн ашиг сонирхлыг хамгаалах үүднээс шүүхэд хандаж болно.⁴³

⁴⁰ Venice Commission, CDL-AD (2018)012-e, Georgia - Amicus curiae brief for the Constitutional Court of Georgia on the effects of Constitutional Court decisions on final judgments in civil and administrative cases, para. 33.

⁴¹ Venice Commission, CDL-AD(2016)034, Ukraine – Opinion on the draft Law on the Constitutional Court, para. 45.

⁴² Van Aaken, A., "Making International Human Rights Protection More Effective: A Rational-Choice Approach to the Effectiveness of Ius Standi Provisions", Preprints of the Max Planck Institute for Research on Collective Goods, no. 2005-16, 2005, p. 14, available at: https://papers.ssrn.com/sol3/papers.cfm?abstract_id=802424.

⁴³ Беларусьд хувь хүмүүс "норматив эрх зүйн актуудын хуулийн цоорхой, зөрчил, хийдлийг" арилгуулахын тулд Үндсэн хуулийн шүүхэд хандаж болдог (Үндсэн хуулийн шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 158-р зүйл; жишээлбэл, D-1101/2017 шийдвэрийг үзнэ үү: <http://www.kc.gov.by/document-47153> болон CODICES-ээс үзэж боломжтой.) Гэхдээ тэд үндсэн хуулиар олгогдсон эрх нь зөрчигдсөн асуудлаар Үндсэн хуулийн шүүхэд шууд хандах боломжгүй (мөн доорх 66-р хэсгийг үзнэ үү). Үндсэн хуулийн шүүх нь үндсэн хууль зөрчсөн хуулийг хүчингүй болгох боломжгүй ч хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг Сайд нарын зөвлөлд гаргаж болно.

40. Нөгөөтээгүүр, *actio popularis* нь урвуулан ашигласан гомдол гаргах нөхцөл болж болно. Энэ шалтгааны улмаас ихэнх улс орнууд *actio popularis*-ыг хэрэглэдэггүй. Практикт *actio popularis*-ыг зөвшөөрдөг улс орнууд үндсэн хуулийн шүүхээ хэт ачааллаас сэргийлэхийн тулд гомдол хэд хэдэн нөхцөлийг хангасан байхыг шаарддаг (жишээлбэл, Лихтенштайн,⁴⁴ Мальта,⁴⁵ Перу). Зарим улс орнууд *actio popularis*-тай төстэй өөр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг бий болгосон байна. Мөн тэрчлэн, хүний эрхийн байгууллага болон бусад байгууллагууд нийтийн эрх ашгийг хамгаалах зорилгоор "нийтийн өргөдөл гаргагч"-ийн хувиар өргөдөл гаргаж болно. Эдгээр бүлгүүд хэдийгээр засгийн газар эсхүл норматив акт шууд нөлөөлсөн хувь өргөдөл гаргагчдын өмнөөс гомдол гаргаж болох ч өргөдөлд хувийн ашиг сонирхлоо илэрхийлэх шаардлагагүй. Сан Маринагийн иргэд (сонгогчдын 1.5 хувийн саналаар дэмжигдсэн олонхын саналаар) шинээр гаргасан актыг хүчин төгөлдөр болсноос хойш 45 хоногийн дотор Үндсэн хуульд нийцэж байгаа эсэхийг хянуулахаар Үндсэн хуулийн шүүхэд шууд хүсэлт гаргаж болдог.⁴⁶

41. Венецийн Комисс **үндсэн хуультай холбоотой асуудалд *actio popularis*-ыг хэрэглэх нь Европын стандарт гэж үзэх боломжгүй гэдгийг онцлон тэмдэглэж байгаа бөгөөд тэр ч байтугай *actio popularis*-ыг нэвтрүүлэхээс сэрэмжлүүлж байна.**⁴⁷ Энэ асуудлын хүрээнд Комисс *Actio popularis*-аас болж Үндсэн хуулийн шүүх хэт ачаалалтай болсон Хорватын жишээг дурдаж байна. Энэ асуудалд Венецийн Комисс шүүмжлэлтэй хандсаар ирсэн.⁴⁸ Венецийн Комисс улс орнуудад **зөвхөн эрх нь зөрчигдсөн хохирогчид л үндсэн хуулийн асуудлаар гомдол гаргах эрхтэй гэдгийг тодорхой болгохыг үргэлж зөвлөсөөр ирсэн.**⁴⁹

⁴⁴ Захирамжид чиглэсэн *actio popularis*-ыг явуулах боломж бий. Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн 20(1)(с) -д зааснаар "Үндсэн хуулийн шүүх нь захирамж, түүний аливаа заалт Үндсэн хууль, хууль тогтоомж, олон улсын гэрээнд нийцэж байгаа эсэхийг сонгуулийн эрх бүхий 100 -аас доошгүй иргэний өргөдлөөр, хэрэв өргөдлийг тухайн захирамж Лихтенштайны Хууль зүйн мэдээллийн сэтгүүлд нийтлэгдсэнээс хойш нэг сарын дотор гаргасан бол хянана" гэж заасан байдаг.

⁴⁵ Venice Commission, CDL-JU (2001)22, Report on "Der Zugang des Einzelnen zur Verfassungsgerichtsbarkeit im europäischen Raum", p. 35.

⁴⁶ Law 26 February 2002, no. 36, Art. 7.3.a) and Qualified Law 25 April 2003, no. 55, Art. 12

⁴⁷ Venice Commission, CDL-AD(2008)030, Opinion on the Draft Law on the Constitutional Court of Montenegro, para. 11; Venice Commission, CDL-AD(2011)001, Opinion on three legal questions arising in the process of drafting the new Constitution of Hungary, paras. 55-69.

⁴⁸ Venice Commission, CDL-AD(2008)030, Opinion on the Draft Law on the Constitutional Court of Montenegro, para. 11; Venice Commission, CDL-AD(2012)009, Opinion on Act CLI of 2011 on the Constitutional Court of Hungary, para. 49

⁴⁹ Venice Commission, CDL-AD(2014)026, Opinion on the Seven Amendments to the Constitution of "The former Yugoslav Republic of Macedonia" concerning, in particular, the Judicial Council, the Competence of the Constitutional Court and Special Financial Zones, para. 87; Venice Commission, CDL-AD(2014)020, Opinion on the Draft Constitutional Law on Introduction Amendments and

В. Шууд бус хандалт

42. Хувь хүний шууд бус хандалтын хүрээнд төрийн байгууллагууд өөрсдийн санаачилгаар, эсхүл хувь хүний нэрийн өмнөөс буюу түүний хүсэлтээр аливаа хэм хэмжээг үндсэн хуульд нийцсэн эсэхийг хянуулах эрхтэй. Хамгийн түгээмэл нь омбудсмен болон ердийн шүүх юм.⁵⁰

1. Ердийн шүүх

43. Ердийн шүүх тухайн хэрэгт хэрэглэх шаардлагатай заалтыг үндсэн хуульд нийцэж байгаа эсэхийг тодруулахын тулд үндсэн хуулийн шүүхэд урьдчилсан асуулт тавьж үндсэн хуулийн талаар асуудал дэвшүүлж болно. Урьдчилсан асуулт нь хувь хүний шууд бус хандалтын хамгийн түгээмэл арга. Энэ нь олон төрлийн загваруудтай. Загвараасаа хамааран урьдчилсан асуултыг талуудын аль нэг нь эсхүл ердийн шүүгч өөрөө санаачилж болно. Ийм төрлийн хяналт нь үндсэн хуулийн хяналтын төвлөрсөн бус хяналтын системд тун ховор, учир нь ердийн шүүх өөрсдөө үндсэн хуульд нийцэж буй эсэх асуудлыг өөрсдөө шийддэг (жишээлбэл, Канад, Дани, Финланд, Исланд, Норвег, Өмнөд Африк, Швед, Швейцар, Их Британи гэх мэт). АНУ харин өөр. Давж заалдах шатны бүх шүүхүүд АНУ-ын Дээд шүүхээс хуулийн аливаа асуудлаар зааварчилгаа авахаар хүсэлт гаргаж болох бөгөөд Дээд шүүх маргаантай асуудлын хүрээнд заавал биелүүлэх зааварчилгаа өгөх эсхүл өөрөө шийдэхийн тулд бүх тэмдэглэлийг шаардаж болдог. Зөвхөн цөөн тооны төвлөрсөн хяналтын системд урьдчилсан асуулт тавих зохицуулалтгүй (жишээ нь, Латви, Монако, Серби).

44. Үндсэн хуулийн шүүхэд урьдчилсан асуулт тавих эрхийг ердийн шүүхүүдэд олгож буй нь эдгээр шүүхүүдийн байр суурь үндсэн хуулийн эрх зүйг хамгаалах тэргүүн эгнээнд байгааг хүлээн зөвшөөрч буй явдал юм. Шүүхүүд хууль хэрэглэснээс үүдэн гарч болох үндсэн хуулийн асуудалтай хамгийн түрүүнд тулгардаг. Тиймээс үндсэн хуулийн заалтуудын талаарх тэдний ойлголт нь үндсэн хуулийн дэг журмаар хангагдсан хамгаалалтын ерөнхий чанарыг тодорхойлно. Улмаар үндсэн хуулийн шүүх үндсэн хуулийн маргаан үүссэн даруйд нь шийдвэрлэж болох тул үндсэн хуулийн урьдчилсан шийдвэр нь хохирсон хувь хүнд учрах хохирлыг илүү хурдан, шууд арилгах боломжийг ердийн шүүхэд олгож болно.

45. Урьдчилсан асуултын давуу тал нь ердийн шүүхүүд мэдээлэл сайтай байж, үндэслэлтэй асуулт гаргах чадвартай байдаг. Ердийн шүүхүүд нь эхний шалгуур шүүлтүүрийн үүрэг гүйцэтгэдэг бөгөөд зүй бус эсхүл удаа дараа давтагдсан

Additions to the Constitutional Law on the Constitutional Chamber of the Supreme Court of Kyrgyz Republic, para. 10.

⁵⁰ Зарим улс орон парламентын гишүүдэд иргэдийн өргөдлийн үндсэн дээр үндсэн хуулийн шүүхэд асуулт тавих боломжийг олгодог. Гэхдээ энэ тухай тус тайланд хэлэлцэхгүй.

Венецийн комисс

хүсэлтийн тоог багасгахад тустай байдаг. Түүнчлэн, урьдчилсан шийдвэр гаргах журам нь тухайн зүйл заалтыг хэрэглэж байгаа эсхүл хэрэглэх ёстой тодорхой бодит нөхцөл байдлаас үүдсэн хяналтын ажиллагааг хөнгөвчилдөг.⁵¹ Гэхдээ үүнд сул талууд бас бий. Урьдчилсан асуултын үр дүнтэй байдал нь үндсэн хууль зөрчсөн байж болзошгүй норматив актыг олж тогтоох, урьдчилсан асуултыг Үндсэн хуулийн шүүхэд тавих ердийн шүүгчдийн чадвар, хүсэл эрмэлзлээс ихээхэн хамаарна. Энэ нь загвараасаа хамааран уг процедурыг хэрэгжүүлэх хувь хүний чадвараас бага хэмжээгээр хамаарна.

46. Португал, Швейцараас бусад үндсэн хуулийн хяналтын төвлөрсөн тогтолцоотой ихэнх улсуудад урьдчилсан асуултын арга бий. Зарим улсад урьдчилсан асуулт нь хувь хүмүүсийн үндсэн хуулийн шүүхэд хандах хандалтын цорын ганц хэлбэр болдог (жишээ нь, Франц). Үндсэн хуулийн хяналтын төвлөрсөн бус тогтолцоотой улсуудад үндсэн хуультай холбоотой асуудлыг өөрсдөө үнэлэхийн тулд ердийн шүүхээс урьдчилсан асуулт гаргах нь нийтлэг бус.

47. Олон улс орнуудад бүх ердийн шүүхүүд үндсэн хуулийн шүүхэд урьдчилсан асуулт тавих эрхтэй (жишээлбэл, Албани, Андорра, Армени, Австри, Бельги, Босни Герцеговина, Чили, Хорват, Чех,⁵² Гүрж, Герман, Унгар, Итали, Казахстан, БНСУ, Лихтенштайн, Литва, Люксембург, Монтенегро, Марокко (2011 оноос хойш),⁵³ Хойд Македон, Польш, Румын, Орос, Сан-Марино, Словак, Словени, Испани, Турк, Украин болон Уругвай). Чили улсад хэрэв ердийн шүүгчид хуулийг үндсэн хуульд нийцээгүй гэж үзвэл Үндсэн хууль зөрчсөний улмаас хэрэглэх боломжгүй гэсэн бичгийг Дээд шүүхэд гаргаж болно. Дараа нь Дээд шүүх түүнийг нь хянаад, Үндсэн хууль зөрчсөн учраас тухайн хэрэгт уг заалтыг хэрэглэхгүй гэж тогтоож болно.

48. Зарим улс орнууд ямар шүүх урьдчилсан асуулт гаргаж болох тал дээр хязгаарлалт тавьдаг. Азербайжан, Беларусь, Болгар, Грек, Бүгд Найрамдах Молдав, ОХУ-д өргөдлийн чанарыг хангахын тулд зөвхөн дээд шатны шүүхүүд урьдчилсан асуулт тавих эрхтэй байдаг. Францад *Үндсэн хуульд нийцсэн эсэх нэн тэргүүний асуултын журамд* ("QPC") урьдчилсан асуулт тавихын тулд хоёр түвшин бүхий шүүлтүүрийн систем заасан байдаг. Нэгдүгээрт, аливаа ердийн шүүгч зөвхөн хэргийн оролцогчдын аль нэгнийх нь хүсэлтээр урьдчилсан

⁵¹ Venice Commission, CDL-INF(1996)010, Opinion on the draft Law on the Constitutional Court of the Republic of Azerbaijan, p. 4.

⁵² Ердийн шүүх аливаа хэм хэмжээ Үндсэн хуульд нийцэж байгаа эсэхэд урьдчилсан асуулт тавих талаар тусгайлсан журам байхгүй байсан ч ердийн шүүх тухайн хууль тогтоомж үндсэн хуульд нийцэж байвал түүнийг болон түүний зарим заалтыг хүчингүй болгох тухай хүсэлтийг Үндсэн хуулийн шүүхэд гаргаж болно. Харин үндсэн хуулийн шүүх нь уг хүсэлтэд хөндсөн хууль тогтоомж нь үндсэн хуулийн дэг журамтай харш байвал хүчингүйд тооцож болно.

⁵³ Урьдчилсан хүсэлт гаргах журам Мароккод хараахан байхгүй байна.

асуултыг дээд шатны шүүхэд гаргаж болно. Хоёр дахь шатанд, дээд шүүх нь Үндсэн хуулийн зөвлөлд энэ асуултыг тавьж болно. Кипрт зөвхөн гэр бүлийн асуудал хариуцсан шүүхүүд урьдчилсан асуулт гаргаж болдог.

49. Үндсэн хуулийн шүүхэд урьдчилсан асуулт хэлэлцүүлэхээр оруулахыг хязгаарлах нь урьдчилсан хүсэлтийн тоог багасгах үр дүнтэй бөгөөд нэг шүүх ажиллагааг дуусгаж байж өөр шүүх ажиллагаа явуулах логиктой (хувь хүн шүүх хуралдааны ердийн дарааллыг баримтлах ёстой) нийцэж байгаа боловч энэ нь доод шатны шүүхүүд хууль үндсэн хуульд нийцэж байгаа эсэхэд нь эргэлзээтэй байсан ч уг хуулийг хэрэглэх үүрэгтэй бол урт хугацааны туршид үндсэн хуульд нийцээгүй байж болох нөхцөл байдалд талуудыг үлдээнэ. **Венецийн Комисс хүний эрхийг хамгаалах үүднээс бүх шатны шүүхүүдэд үндсэн хуулийн шүүхэд урьдчилсан асуулт тавих эрхийг олгох нь илүү үр дүнтэй гэж үзэж байна.**

50. Урьдчилсан асуултыг ердийн шүүх хуралдаан даргалагч шүүгчийн санаачилгаар тавьж болно. Мөн эдгээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогчид үндсэн хуулийн шүүхэд урьдчилсан асуулт хэлэлцүүлэхээр оруулахыг ердийн шүүгчээс хүсэж болно

a. Ердийн шүүгчийн санаачилгаар урьдчилсан асуулт гаргах нь.

51. Хэрэв ердийн шүүгч тодорхой хэрэгт хэрэглэх норматив акт нь үндсэн хууль зөрчсөн эсэхэд эргэлзэж байвал тухайн шүүгч (*iudex a quo*) үндсэн хуулийн шүүхэд уг актын үндсэн хуульд нийцсэн эсэх талаарх урьдчилсан асуулт (*iudex ad Quem*) гаргахаар шийдвэрлэж болно.

52. Ердийн шүүхүүд үндсэн хуулийн шүүхэд урьдчилсан асуулт хэлэлцүүлэхээр оруулах эсэх, хэзээ асуулт явуулах талаар өөр өөр зохицуулалт бий. Зарим улс оронд ердийн шүүх тухайн хэрэг маргаанд хэрэглэх шаардлагатай заалт нь үндсэн хуульд нийцэж байгаа эсэхэд эргэлзээ төрүүлж болзошгүй асуудалилруулэх бүрдээ урьдчилсан асуулт гаргах үүрэгтэй байдаг (жишээ нь, Албани, Австри, Бельги, Босни Герцеговина, Өмнөд Солонгос,⁵⁴ Литва, Хойд Македон, Бүгд Найрамдах Молдова болон Румын). Бусад улс орнуудад шүүгчид тухайн норматив актыг үндсэн хуультай нийцээгүй ба түүнийг үндсэн хуульд нийцүүлэх тайлбар байхгүй гэдэгт итгэлтэй байгаа тохиолдолд л үндсэн хуулийн шүүхэд урьдчилсан асуулт тавих боломжтой (жишээлбэл, Болгар, Чех, Герман, Унгар, Люксембург, Мальта, Орос, Сан Марино, Словак, Словени, Турк гэх мэт).

⁵⁴ Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн 41.1-т зааснаар "Хэрэв хууль Үндсэн хуульд нийцсэн эсэх асуудлыг шийдвэрлэх нь шүүхэд тухайн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны урьдчилсан нөхцөл бол тухайн хэргийг хянан шийдвэрлэх шүүх (цаашид цэргийн шүүхийг оролцуулан нэгэн адил хэрэглэнэ) бүрэн эрхийнхээ хүрээнд, эсхүл оролцогч талын гаргасан хүсэлтийн дагуу хууль Үндсэн хуульд нийцсэн эсэх тухай асуултыг шийдвэрлүүлэхээр Үндсэн хуулийн шүүхэд хүсэлт гаргана."

Венецийн комисс

Францад ердийн шүүгчид ямар нэгэн хэм хэмжээ Үндсэн хуульд нийцэж байгаа эсэхэд ноцтой эргэлзэж байгаа тохиолдолд л Үндсэн хуулийн зөвлөлд урьдчилсан асуулт хэлэлцүүлэхээр оруулж болно. Яаралтай тохиолдолд Үндсэн хуулийн зөвлөл хариугаа өгөөгүй байсан ч ердийн шүүгч шийдвэрээ гаргаж болно. Үүний эсрэгээр, Итали болон Сан-Мариногийн хувьд үндсэн хуулийн шүүхэд урьдчилсан асуулт хэлэлцүүлэхээр оруулж байгаа шүүх уг норматив акт нь үндсэн хууль зөрчсөн гэдэгт итгэлтэй байх шаардлагагүй бөгөөд зөвхөн хэргийн асуудал илт үндэслэлгүй биш байхад болно.⁵⁵

53. Ердийн шүүх тухайн зүйл заалтыг үндсэн хуульд нийцээгүй гэж үзвэл үндсэн хуулийн шүүхэд тухайн хэм хэмжээний эсрэг урьдчилсан шийдвэр гаргуулах хүсэлт гаргаж болдог байвал зохино гэж Венецийн Комисс үзэж байна. Хувь хүн үндсэн хуулийн шүүхэд шууд хандах боломжгүй тохиолдолд ердийн шүүгч л аливаа зүйл заалтыг үндсэн хуультай нийцээгүй гэж үзсэн нөхцөл байдалд урьдчилсан асуулт тавих боломжийг хязгаарлах нь хэт өндөр босго болно гэж Комисс мөн тэмдэглэж байна. Ийм нөхцөлд ноцтой эргэлзээ байхад хангалттай юм.⁵⁶

б. Талуудын санаачилгаар урьдчилсан хүсэлт гаргах

54. Олон улс оронд ердийн шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогчид тухайн ажиллагаанд хэрэглэгдэх хуулийн Үндсэн хуульд нийцэж байгаа эсэхэд эргэлзэж байвал үндсэн хуулийн шүүхэд урьдчилсан асуулт⁵⁷ хэлэлцүүлэх хүсэлтийг ердийн шүүгчид гаргаж болдог (жишээ нь: Албани, Алжир,⁵⁸ Андорра, Армени, Австри, Бельги, Болгар, Хорват, Чех, Франц, Унгар, Итали, Люксембург, Литва, Бүгд Найрамдах Молдова Улс, Польш, Сан Марино, Словак, Испани, Турк болон Украин). Ихэвчлэн шүүгч уг хүсэлтийг хянан үзэж, үндсэн хуулийн шүүхэд асуулт оруулахаас татгалзвал үндэслэлээ гаргах үүрэгтэй байдаг.⁵⁹

55. Ердийн шүүгчид ихэвчлэн урьдчилсан асуултыг хэлэлцүүлэхээр оруулах саналыг зөвшөөрөх эсхүл татгалзах эрхтэй байдаг (жишээ нь: Алжир, Андорра,⁶⁰

⁵⁵ Италийн талаар 87/1953 хуулийн 23-р зүйлийг үзнэ үү. Мөн Италийн Үндсэн хуулийн шүүхийн 42/2017 дугаар шийдвэрийг үзнэ үү.

⁵⁶ Venice Commission, CDL-INF(2001)28, Interim Opinion on the Draft Law on the Constitutional Court of the Republic of Azerbaijan, p. 5.

⁵⁷ Энэхүү процессын эрх хамгаалах арга хэмжээг заримдаа “үндсэн хууль зөрчсөнөөс бусад тохиолдол”, эсхүл “конкрет хяналт” гэдэг.

⁵⁸ Organic Law No. 18-16 of 2 September 2018.

⁵⁹ Испанид шүүгч бүрэн чөлөөтэй бөгөөд зөвхөн Үндсэн хуулийн шүүх рүү асуултыг шилжүүлэхээс татгалзсан шийдвэрээ үндэслэн тайлбарлах үүрэгтэй (Үндсэн хуулийн шүүхийн органик хуулийн 35.2 -ийг үзнэ үү).

⁶⁰ Шилжилтийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 2 дугаар зүйлд үндсэн хуулийн шүүхэд урьдчилсан хүсэлт гаргах тухай ердийн шүүхийн шийдвэрээс өмнө Үндсэн хуулийн шүүх өөрийн санаачилгаар урьдчилсан асуулт тавих, эсхүл хэрэг хянан шийдвэрлэх

Бельги, Беларусь, Чех, Франц, Унгар, Итали, Люксембург, Мальта, Польш, Словак, Испани, Румын, Украин). Ердийн шүүх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогчийн хүсэлтийг хүлээн авсны дараа урьдчилсан асуултыг хэлэлцүүлэхээр оруулахгүй байхаар шийдэх эрх нь түүний бүрэн эрхийн асуудал юм. Гэхдээ зөвхөн тодорхой хязгаарлагдмал үндэслэлээр урьдчилсан хүсэлт оруулахаас татгалзаж болно (жишээ нь, урьдчилсан асуулт нь илт үндэслэлгүй гэх мэт⁶¹). Харин зарим улс орнууд ийм тохиолдолд (жишээ нь, Бельги, Хойд Македон, Румын) асуулт тавихыг үүрэг болгосон байдаг.

56. Ердийн шүүгчийн шийдвэр ихэвчлэн эцсийнх бөгөөд давж заалдах боломжгүй (үндэслэлгүй эсхүл зарим хэлбэрийн алдаанаас бусад тохиолдолд). Уругвайд талууд шүүхийн татгалзсан хариуг шууд давж заалдаж болдог.

57. Ердийн шүүгч урьдчилсан асуулт хэлэлцүүлэхээр оруулахаас татгалзсан нь хүсэлт гаргагчийн давж заалдах шатанд урьдчилсан асуулт тавихыг шаардах эрхэд саад болохгүй. Жишээлбэл, Италид шүүх талуудын санаачилгаар урьдчилсан хүсэлтийг илт хамааралгүй, эсхүл үндэслэлгүй гэж татгалзсан тохиолдолд ижил хүсэлтийг дараа дараагийн шатны шүүх хуралдааны эхэнд дахин гаргаж болно.⁶² Үүнтэй адилаар Туркт, хэрэв шүүх хуралдааны үеэр ердийн шүүх Үндсэн хуулийн шүүхэд урьдчилсан асуулт хэлэлцүүлэхээр оруулахгүй байх шийдвэрийг гаргавал энэ шийдвэрийг хэргийн оролцогчид эцсийн шийдвэрийн хамт давж заалдаж болно.⁶³

58. Иймээс хэрэв ердийн шүүх урьдчилсан хүсэлтийг үндсэн хуулийн шүүхээр хэлэлцүүлэхээр оруулах үүрэгтэй бол талуудын санаачилгаар

ажиллагаанд оролцогч талуудын аль нэгээс хүсэлт хүлээн авахдаа шүүх бүрэлдэхүүн Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн 53(3) дахь хэсэг, Шилжилтийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 2 дугаар зүйлийг дагаж мөрдөх ёстой. Энэ хоёр заалтын дагуу ердийн шүүх бүрэлдэхүүн үндсэн хуулийн шүүхэд гаргах урьдчилсан хүсэлтийн хууль зүйн үндэслэл болон агуулгыг багтаасан шийдвэр гаргана. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч талууд болон улсын яллагч саналаа ирүүлсний дараа ердийн шүүх урьдчилсан хүсэлтийг гаргахгүй байх, эсхүл анхны шийдвэртээ танилцуулсан байдлаар уг хүсэлтийг гаргах, эсхүл хүсэлтэд нэмэлт, өөрчлөлт оруулахаар шийдвэрлэж болно.

⁶¹ Жишээлбэл, Францад урьдчилсан хүсэлтээр хянан шийдвэрлэх дэс дараалалд хэд хэдэн шаардлагыг хангасан байх ёстой: тухайн асуулт нь (i) ноцтой, (ii) шинэ (Үндсэн хуулийн зөвлөл хараахан хариулаагүй байгаа) болон (iii) тодорхой хэрэг маргаанд хэрэглэгдэхээр байх ёстой.

⁶² Section 24 of law no. 87 of 11 March 1953. See also San Marino: Art. 13(5) of the Qualified Law, 25 April 2003, no. 55

⁶³ Туркийн Үндсэн хуулийн 152 дугаар зүйлд (2017 оны 4-р сарын 16-ны өдрийн 6771-р нэмэлт өөрчлөлт) "Хэргийг хянан хэлэлцэж байгаа шүүх тухайн хэрэглэх хууль буюу хуулийн хүчинтэй тогтоолыг үндсэн хууль зөрчсөн гэж үзвэл, эсхүл аль нэг талын гаргасан үндсэн хууль зөрчсөн тухай нэхэмжлэлийн шаардлага ноцтой гэдэгт итгэлтэй байгаа бол үндсэн хуулийн шүүх уг асуудлыг шийдвэрлэх хүртэл хэрэг хянах ажиллагааг хойшлуулдаг. Хэрэв шүүх үндсэн хууль зөрчөөгүй гэж үзвэл ийм нэхэмжлэлийг үндсэн шийдвэрийн хамт давж заалдах эрх бүхий байгууллага шийдвэрлэнэ."

гарсан урьдчилсан хүсэлт нь хувь хүний үндсэн хуулийн хяналтад хандах маш үр дүнтэй арга хэрэгсэл гэж Венецийн Комисс үзэж байна.

2. Омбудсмены байгууллагууд

59. Венецийн Комиссын гишүүн болон ажиглагч улсуудын ихэнх нь омбудсмены (зуучлагч, парламентын комиссар, хүний эрхийг хамгаалагч гэх мэт) тогтолцоотой.⁶⁴ Венецийн Комиссын үзэж байгаагаар хамгийн өргөн тархсан загвар бол “ард түмэн, төр, нутгийн захиргааны хооронд зуучлал хийх үндсэн үүрэгтэй хараат бус албан тушаалтан нь хүний эрхийн зөрчил, захиргааны буруу шийдвэр үйл ажиллагаатай тэмцэж, ийм явдлыг арилгахын тулд лавлагаа, мэдээлэл авах эрхийн дагуу захиргааны үйл ажиллагаанд хяналт тавих, захиргааны байгууллагад хууль, эрх тэгш байдалд өргөн утгаар үндэслэж зөвлөмж гаргах” юм.⁶⁵

60. Омбудсмены хянан шалгах, тайлагнах, зөвлөмж өгөх зэрэг уламжлалт бүрэн эрхээс гадна шүүх болон маргаан шийдвэрлэгчийн өмнө хөндлөнгөөс оролцох, тэр ч байтугай үндсэн эрхийн зөрчил гарсантай холбогдуулан хянан шалгах ажиллагаа эхлүүлэх эрх мэдэлтэй байх ёстой гэдэг нь улам бүр хүлээн зөвшөөрөгдсөөр ирсэн байна.⁶⁶ Тухайлбал, 2011 онд Францын Омбудсмены (*Défenseur des droits*) эрх мэдлийг нэмсэн бөгөөд тэрээр одоо иргэний, захиргааны болон эрүүгийн хэргийн шүүхэд тодорхой хэргүүдэд оролцох эрхтэй болсон.⁶⁷ Гэхдээ Омбудсменд үндсэн хуульд нийцсэн эсэх асуудлаар үндсэн хуулийн зөвлөлд хандах эрх олгогдоогүй тул үндсэн хуульд нийцсэн эсэхийг хянах үүрэг нь хязгаарлагдмал хэвээр байна.

61. Төвлөрсөн бус хяналтын тогтолцоонд шүүх ажиллагаа эхлүүлэх эрх бүхий омбудсмен үндсэн хуулийн шүүх биш харин эрх бүхий ердийн шүүхийн өмнө тус эрхээ эдэлнэ (жишээ нь, Финлянд дахь төрөлжсөн Омбудсмен). Бразил хэдийгээр бүрэн төвлөрсөн бус хяналттай улс биш ч гэсэн Нийтийн өмгөөлөгч нь үндсэн хуулиар олгогдсон эрхийг хамгаалах үүднээс ердийн шүүхийн өмнө хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг үүсгэж болно.

62. Эсрэгээрээ, үндсэн хуулийн хяналтын төвлөрсөн тогтолцоонд омбудсмен нь үндсэн хуулийн шүүхийн өмнө шууд үндсэн хуулийн хяналтын ажиллагааг үүсгэх эрхтэй байдаг (жишээлбэл, Албани, Армени, Австри, Азербайжан, Хорват,

⁶⁴ Venice Commission, CDL-AD(2019)005, Principles on the Protection and Promotion of the Ombudsman Institution (“The Venice Principles”), p. 2.

⁶⁵ Venice Commission, CDL-AD(2007)020, Opinion on the possible reform of the Ombudsman Institution in Kazakhstan, para 12.

⁶⁶ Linda Reif, “Transplantation and Adaptation: The Evolution of the Human Rights Ombudsman” (2011) 31 Boston College Third World Law Journal 269, at pp. 302-307

⁶⁷ Францын Омбудсмены тухай 2011 оны 3 дугаар сарын 29-ний өдрийн 2011-333 тоот органик хуулийн 33 дугаар зүйлийн 1 дэх хэсэг.

Чех, Эстони, Унгар, Латви, Бүгд Найрамдах Молдова, Польш, Португал, Румын, Орос, Серби, Словак, Словени, Өмнөд Африк, Испани, Украин). Эдгээрийн ихэнх улсуудад омбудсменууд тодорхой хэрэг гараагүй байсан ч норматив актуудад абстрактаар хяналт хийлгэх ажиллагаа санаачлах боломжтой. Тухайлбал, 2011 оноос хойш Унгарын омбудсмен нь норматив актыг хийсвэрээр хянах эрх мэдэлтэй болсон.⁶⁸ Зарим улсад омбудсмены шийдвэрлэж байгаа тодорхой хэрэгт норматив акт заавал холбоотой байх ёстой хэвээр байна (жишээ нь, Азербайжан, Перу болон Украин).

63. Омбудсмены зүгээс шүүхэд хандах боломжтой улсуудад хүртэл тодорхой хязгаарлалттай тулгарч болно. Заримдаа гагцхүү омбудсмены байгууллагаар тухайн хэрэгт хүний эрх, үндсэн эрх чөлөөгөө хамгаалуулж буй этгээдийн зөвшөөрлөөр л үндсэн хуулийн гомдол гаргаж болно. Жишээлбэл, Азербайжанд омбудсмен нь зөвхөн хохирогч өргөдөл гаргаснаар үндсэн хуульд нийцээгүй шүүхийн шийдвэрийг хянан шалгах эрхтэй болдог. Эдгээр тохиолдолд омбудсмены эрх нь зарчмын хувьд тухайн хүний эрхээс хэтрэхгүй.⁶⁹ Үүний эсрэгээр Испанийн омбудсмен нь өөрсдийн мэдэж байгаагаар маргаантай актаас болж хохирсон аливаа хувь хүнийг хяналтын ажиллагаанд оролцуулахын тулд тухайн хувь хүний өмнөөс төрийн эрх бүхий байгууллагын бүх актуудын эсрэг *ampora* нэхэмжлэл гаргаж болно.

64. Омбудсменд хувь хүний нэрийн өмнөөс Үндсэн хуулийн шүүхэд хандах боломж олгохын давуу тал нь омбудсмен эрх зүйн мэдлэгээрээ дамжуулан өргөдлийн чанарыг сайжруулахад тустай байж болно (жишээлбэл, Босни Герцеговина, Орос). Тухайн хүн Үндсэн хуулийн шүүхэд өөрөө шууд хандах боломжтой байсан ч ялгаагүй. Түүнчлэн, хувь хүнд омбудсменаар дамжуулан шүүхэд хандах боломжийг олгох нь хүний эрхийн үр дүнтэй хамгаалалтыг сайжруулах магадлалтай. Учир нь “хувь хүн шүүгчээс илүү омбудсментай харилцахад ямагт илүү хялбар байдаг”.⁷⁰

65. Хүний эрхийг хамгаалах хандлагын үүднээс, **“хянан шалгалт явуулсны дараа омбудсмен нь хууль тогтоомж, дүрэм журам, захиргааны ерөнхий актыг үндсэн хуульд нийцэж байгаа эсэх талаар асуудал тавих эрхтэй байх нь зүйтэй. Омбудсмен нь холбогдох маргаан таслах байгууллага болон**

⁶⁸ Art. 24(2) of the Act CLI of 2011 on the Constitutional Court.

⁶⁹ Словенийн Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн 50(2), 52(2). Нэмж дурдахад, омбудсмен тухайн маргаантай актыг хүний эрх, үндсэн эрх чөлөөнд зүй бусаар саад болж байна гэж үзвэл төрийн эрх мэдлийг хэрэгжүүлэхдээ гаргасан хэм хэмжээ, нийтлэг актуудыг үндсэн хуульд нийцсэн эсхүл хууль ёсны эсэхийг хяналтын журмаар хянан шийдвэрлэх ажиллагаа эхлүүлэх боломжтой. (Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн 23(а)).

⁷⁰ Council of Europe, Parliamentary Assembly, Report - Ombudsman institutions in Europe - the need for a set of common standards, Doc. 14953, 20 August 2019, para. 50, available at: <https://pace.coe.int/pdf/2d710f462da53cbe00048d3ed86a193ac9fedd3f3326667a8259ffe25682ae848428feba12/doc.%2014953.pdf>.

шүүхийн өмнө хөндлөнгөөс оролцох эрхтэй байх нь давуутай" гэж Венецийн Комисс зөвлөж байна.⁷¹ Үндсэн хуулийн шүүх нэг бүрчилсэн актын үндсэн хуульд нийцэж байгаа эсэхийг хянан шалгах эрхтэй бол, омбудсменд үндсэн хуулийн шүүхэд нэг бүрчилсэн хэрэг (individua case) үүсгэх эрхийг мөн олгох ёстой.

С. Холимог шийдэл

66. Өмнөх хэсгүүдээс харахад одоогийн сонголтууд маш өргөн бөгөөд өөр олон боломжууд зэрэгцэн оршиж байна. Ихэнх улс үндсэн хуулийн хяналтад шууд болон шууд бус байдлаар хандах холимог тогтолцоотой. Зарим улс, тэр дундаа үндсэн хуулийн хяналтын төвлөрсөн бус тогтолцоотой улс шууд хандах аргыг хэрэглэж байна. Маш цөөн улсад үндсэн хуулийн шүүхэд шууд бусаар хандах аргыг хэрэгжүүлж байна (жишээлбэл, Беларусь, Болгар, Франц).

67. Үндсэн хуулийн хяналтад шууд болон шууд бусаар хандах нь үндсэн хуулийн түвшинд хувь хүний эрхийг дээдлэх байдлыг хангах маш чухал арга хэрэгсэл юм. Эдгээрийн зарим тохиолдолд шууд бусаар хандах механизм нь, хэдий шууд бус ч гэлээ огт хандах боломжгүй нөхцөл байдалд хувь хүнд үндсэн хуулийн шүүхэд хандах боломжийг олгоно. Жишээлбэл, омбудсмен нь үндсэн хуулийн шүүхэд хандах шинэ арга замыг нээж болно. Гэсэн ч шууд бус хандалт шууд хандалтыг орлож чадахгүй. Үнэндээ шууд бус хандалтыг нэмэлт процесс гэж үзвэл зохино. Олон механизмаас сонгох эсхүл зэрэгцээ хувилбар бий болгох эсэх нь тухайн улсын эрх зүйн соёлоос хамаарна. Ерөнхийдөө, **үндсэн хуулийн шүүхэд хувь хүний гомдол, ялангуяа үндсэн хуулийн иж бүрэн гомдол гаргахыг үндсэн хуулийн үр дүнтэй хамгааллын аргын хувьд Венецийн Комисс зөвлөж байна.** Ялангуяа, **омбудсменд гомдол гаргах эрх нь шүүхээр дамжуулан шүүхэд хандах эрхэд нэмэлт болно** гэдгийг Комисс онцолж байна.⁷² Үүнийг Венецийн зарчмуудын оршил хэсэгт Комисс онцлон тэмдэглэснээр **"омбудсменд гомдол гаргах эрх нь шүүхээр дамжуулан [үндсэн хуулийн] шүүхэд хандах эрхээс гадна нэмэлт эрх болно"** гэсэн байдаг.⁷³

68. Үүний зэрэгцээ дээрх аргуудад давуу болон сул тал бий. Шууд бус хандалтын давуу тал нь гомдол гаргаж буй шүүгч, омбудсмен нар ихэвчлэн мэдээлэл сайтай бөгөөд, хүчин төгөлдөр хүсэлт гаргахад шаардлагатай эрх зүйн чадвартайт оршдог. Шүүгч талуудын гаргасан хүсэлтийг Үндсэн хуулийн шүүхэд

⁷¹ Венецийн Комисс, CDL-AD(2019)005, Омбудсмены институтийг хамгаалах, дэмжих зарчим ("Венецийн зарчмууд"), 19-р зарчим. Венецийн комиссын үзэж байгаагаар, омбудсмены бүрэн эрхэд хүний эрх, эрх чөлөөнд нөлөөлөх асуудлыг хөндөж буй хууль тогтоомж, захиргааны ерөнхий актыг абстрактаар хянуулахаар тухайн улсын үндсэн хуулийн шүүхэд хандах боломжийг багтаахыг хүлээн зөвшөөрсөн байна. Омбудсмен үүнийг өөрийн хүсэлтээр эсхүл хувь хүний гомдлын дагуу хийх боломжтой байх хэрэгтэй. (Venice Commission, CDL-AD(2007)020, Opinion on the possible reform of the Ombudsman Institution in Kazakhstan, para. 14).

⁷² *Ibidem*, p. 2.

⁷³ *Ibidem*, p. 2.

шилжүүлэхдээ ч уг хүсэлтийн талаар саналаа хэлэх боломжтой байх ёстой. Энэ нь үндэслэлгүй, урвуулан ашигласан эсхүл удаа дараа давтагдсан хүсэлтийг тодорхойлоход Үндсэн хуулийн шүүхэд нэмэртэй байж болно. Эцэст нь, шууд бус хандалт нь эрх зүйн хамгааллын бүхий л аргыг тултал нь ашиглах шаардлагагүй тул илт үндсэн хууль зөрчсөн нөхцөл байдлыг шаардлагагүйгээр сунжрахаас сэргийлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг.

69. Гэхдээ шууд бус хандалтад сул тал бий. Шууд бус хандалтын үр нөлөө нь эдгээр этгээдийн үндсэн хуультай үл нийцэж болзошгүй норматив актыг тодорхойлох чадавх болон үндсэн хуулийн шүүх, түүнтэй адилтгах байгууллагад өргөдөл гаргах хүсэл эрмэлзлээс ихээхэн хамаарна. Тиймээс, **Венецийн Комисс өөр өөр механизмын давуу болон сул талыг тэнцвэржүүлэхийн тулд шууд бус хандалтыг шууд хандалттай хослуулах нь давуу тал гэж үзэж байна.**

V. ХЯЗГААРЛАЛТ

70. Хувь хүнд үндсэн хуулийн шүүхэд хандах эрхийг өргөн олгохын эсрэг гол үндэслэл нь үндсэн хуулийн шүүхэд хэт ачаалал учруулж болзошгүй байдал юм. Үндсэн хуулийн иж бүрэн гомдлын хувьд энэхүү ачаалал нэмэгдэх эрсдэл өндөр, үндсэн хуулийн шүүхийн хэргийн дийлэнх хэсгийг буюу зарим тохиолдолд ачааллын 90 гаруй хувийг эзэлдэг. Улмаар, талууд зөвхөн ердийн шүүхийн шийдвэрт сэтгэл дундуур байгаагаас болж, үндсэн хуулийн шүүхэд үндсэн хуулийн хүрээнд хамааралгүй олон хэрэг ирж ачаалал ихсэх боломжтой. Хэргийн их ачааллыг шийдэхийн тулд үндсэн хуулийн шүүхэд иж бүрэн гомдол гаргадаг улсууд ихэвчлэн эхлээд хэд хэдэн шалгуур тавьсан байдаг.⁷⁴ Тэрчлэн, зарим үндсэн хуулийн шүүх аль хэргийг бага танхимд хянан хэлэлцэх эсхүл шийдвэрлэх эсэхийг сонгон шүүдэг практиктай.

71. Үндсэн хуулийн шүүхэд хэт ачаалал үүсгэх эрсдэл болон хувь хүний үндсэн хуулийн хяналтад үр дүнтэй хандах хэрэгцээ хоёрыг тэнцвэртэй байлгах хэрэгтэй. Улс орнууд энэ хүндрэлийг олон аргаар шийдэж ирсэн. Зарим улс хувь хүнд гомдол гаргах боломжийг эхнээс нь олгоогүй. Зарим нь процедурын "шүүлтүүр" нэвтрүүлсэн. Түүнчлэн, ижил төстэй хэргийг нэгтгэх, мөн үндсэн хуулийн шүүх шийдвэрлэх хэргээ илүү шүүлтүүртэй сонгох нь шүүхийн ачааллыг хөнгөвчлөхөд тус болж чадна.

72. Хүний эрхийг хамгаалах баталгаа болох үндсэн хуулийн шүүхэд хандах арга замыг хялбар байлгахыг Венецийн Комисс зөвлөж байна. Үндсэн хуулийн шүүхийг хэт ачаалалтай байлгахас сэргийлэх зорилтыг Венецийн Комисс

⁷⁴ Venice Commission, CDL-AD(2018)012, Amicus Curiae Brief for the Constitutional Court of Georgia on the effects of Constitutional Court decisions on final judgments in civil and administrative cases, para. 29.

дэмжиж байгаа ч, үндсэн хуулийн шүүх нь илтэд урвуулан ашигласан өргөдөл биш л бол өргөдлийг хүлээн авахаас татгалзахдаа стандарт хэлбэрээр ч болов үндэслэлтэй шийдвэр гаргаж өгөх ёстой гэж үзэж байна.⁷⁵

А. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэх нөхцөл (“шүүлтүүр”)

73. Ихэнх улс хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэх албан ёсны процедуртай. Үндсэн хуулийн иж бүрэн гомдол гаргахыг зөвшөөрдөг улсад ихэвчлэн үндсэн хуулийн шүүхэд хэт ачаалал өгөх эрсдэлийг харгалзан хэд хэдэн шүүлтүүр ашигладаг.⁷⁶

74. Эдгээр шүүлтүүр нь үндсэн хуулийн шүүхийн ачааллыг хөнгөвчилдөг ч гэсэн үндсэн хуулийн шүүхэд хандах боломжийг хэт бууруулах эрсдэлтэй. Иймд хувь хүний үндсэн хуулийн хяналтад үр дүнтэй хандах хэрэгцээг хэт ачаалал үүсэх эрсдэлтэй сайтар тэнцвэржүүлэх ёстой.

1. Өргөдөл гаргах хугацаа

75. Хүсэлт, өргөдөл гаргах хугацаа янз бүр. Хугацааг хязгаарласнаар тодорхой хугацааны дараа аливаа актын хүчинтэй байдалд халдах боломжгүй болдог тул ийнхүү хугацаа тогтоох нь хууль зүйн тодорхой байдлын зарчмыг (*legal certainty*) бүрдүүлдэг.

76. Энэхүү судалгааны тайланд хамрагдсан ихэнх улсад өргөдөл гаргагчид сүүлийн шатны шүүхийн эцсийн шийдвэр хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш хоёр сарын хугацаа олгодог. Үндсэн хуулийн иж бүрэн гомдол гаргадаг улсуудад (жишээ нь Австри, Хорват, Герман, Серби, Испани⁷⁷) 20 хоногоос 1,5 сар хүртэл арай бага хугацаа тогтоосон байдаг. Үүний эсрэгээр, гурван сараас нэг жил хүртэлх⁷⁸ урт хугацаа тогтоох нь норматив үндсэн хуулийн гомдлын механизмтай улсын (жишээ нь, Польш, Литва, Латви, Орос, Киргизстан, Украин) шинж юм. Эдгээр хугацаа хэт урт байх ёсгүй ч хувь хүн өөрөө гомдол хүсэлтээ бэлтгэх, эсхүл тухайн хүнийг төлөөлөх үүрэг бүхий хуульчтай болох боломжтой

⁷⁵ Venice Commission, CDL-AD(2017)011, Opinion on the Draft Constitutional Law on the Constitutional Court of Armenia, para. 61.

⁷⁶ Venice Commission, CDL-AD(2018)012, Amicus Curiae Brief for the Constitutional Court of Georgia on the effects of Constitutional Court decisions on final judgments in civil and administrative cases, para. 29.

⁷⁷ Испанид Үндсэн хуулийн шүүхийн тухай Органик хуулийн 42-р зүйлд зааснаар өргөдөл гаргагчид Испанийн парламент, түүний аль нэг байгууллага, Автономит нийгэмлэгүүдийн хууль тогтоох чуулган, тэдгээрийн байгууллагаас гаргасан, хуулийн хүчин чадалгүй шийдвэр, хууль тогтоомжийн эсрэг гомдол гаргах хугацаа гурван сар байдаг. Илүү түгээмэл тохиолддог бусад бүх тохиолдлуудад уг хугацаа нь 20 хоногоос нэг сар байна (Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн 43, 44 дүгээр зүйл).

⁷⁸ Дотоодын эрх зүйн бүхий л хамгаалалтын арга хэмжээг авч дууссан буюу шүүхийн эцсийн шийдвэр гарснаас хойш нэг жилийн дотор гомдол гаргах ёстой (1994 оны 7-р сарын 21-ний өдрийн Холбооны Үндсэн хуулийн 97 дугаар зүйл, "ОХУ-ын Үндсэн хуулийн шүүхийн тухай").

хугацаа байх хэрэгтэй (зарим улс орнуудад хувь хүн гомдол гаргахад хууль ёсны төлөөлөлтэй байхыг үүрэг болгосон байдаг). Нэг бүрчилсэн актын хувьд өргөдөл гаргагч хүндэтгэн үзэх шалтгааны улмаас хугацаандаа өргөдөл гаргах боломжгүй тохиолдолд шүүх хугацааг сунгах боломжтой байвал зохино гэж Венецийн Комисс зөвлөж байна.⁷⁹ Тэрчлэн Венецийн зарчмын 19 дүгээрт “Омбудсменд албан ёсоор хүсэлт гаргасан тохиолдолд хуульд заасны дагуу шүүхэд хандах хугацааг түдгэлзүүлж болно” гэж заасан.⁸⁰

2. Хууль ёсны төлөөлүүлэх үүрэг

78. Хууль ёсны төлөөлөгчтэй байх нь өргөдөл гаргагчид туслалцаа үзүүлэх, түүний гаргах гомдлын чанарыг дээшлүүлэх зорилготой.⁸¹ Гэхдээ хууль ёсны төлөөлөгчтэй байх нь санхүүгийн томоохон үр дагавартай. Иймд, ялангуяа заавал хууль ёсны төлөөлөгчтэй байх бол санхүүгийн туслалцаа эсхүл үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа авахгүй байх нь шүүхэд үр дүнтэй хандах боломжийг үгүйсгэж болзошгүй.⁸² Венецийн комисс, **үндсэн хуулийн шүүхэд хандах боломжийг хангахын тулд өргөдөл гаргагчийн материаллаг байдлаас хамааран шаардлагатай тохиолдолд үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа үзүүлэх ёстой** гэж үзэж байна.

79. Тухайлбал, Андорра, Австри, Азербайжан, Чили, Чех, Итали, БНСУ,⁸³ Люксембург, Монако, Польш, Португал, Сан-Марино, Словак, Испани зэрэг улсад хууль ёсны төлөөлөгч заавал байхыг шаарддаг. Швейцарт хувь хүн өөрийгөө төлөөлөх “илт боломжгүй” тохиолдолд л хууль ёсны төлөөлөгчтэй байхыг шаарддаг. ХБНГУ-ын Холбооны Үндсэн хуулийн шүүхийн өмнө зөвхөн амаар мэдүүлэг өгөх үед хууль ёсны төлөөлөгчтэй байхыг шаарддаг. Үүний эсрэгээр, тухайлбал, Албани, Армени, Хорват, Гүрж, Унгар, Латви, Лихтенштайн, Литва,

⁷⁹ Жишээлбэл, Герман, Холбооны Үндсэн хуулийн шүүхийн тухай хууль, 93(2); Словени, Үндсэн хуулийн шүүхийн тухай хууль, 52(3).

⁸⁰ Venice Commission, CDL-AD(2019)005, Public Principles on the Protection and Promotion of the Ombudsman Institution (“The Venice Principles”), Principle 19.

⁸¹ Venice Commission, CDL-AD(2002)016, Opinion on the Draft Law on the Constitutional Court and Corresponding Amendments of the Constitution of the Republic of Moldova, para. 57.

⁸² Venice Commission, CDL-JU(2008)012, Report on “European Standards and the Right to Legal Defense in Civil Matters”, p. 3.

⁸³ Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн 25(3)-г зааснаар “Аливаа хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч тал буюу хувь хүн нь өмгөөлөгчийг төлөөлөгчөөр сонгоогүй тохиолдолд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах буюу оролцохыг хориглоно. Гэхдээ хэргийн оролцогч нь өмгөөлөгч бол энэхүү зохицуулалт хамаарахгүй.” Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн 70(1)-д хууль зүйн туслалцаа үнэ төлбөргүй үзүүлэхээр заасан: “Үндсэн хуулийн асуудлаар гомдол гаргах гэж байгаа этгээд өмгөөлөгчөөр төлөөлүүлэх санхүүгийн боломжгүй бол үндсэн хуулийн шүүхэд хандаж шүүхээс өмгөөлөгч томилуулна. Энэ тохиолдолд 69 дүгээр зүйлд заасан гомдлын дагуу шийдвэрлүүлэх хүсэлт гаргах хугацаа нь уг хүсэлт гаргасан өдрөөс эхлэн үргэлжилнэ.”

Венецийн комисс

Румын, Орос, Словени, Өмнөд Африк,⁸⁴ Швейцар, Украинд төлөөлүүлэх үүрэг байхгүй.

3. Шүүхийн хураамж

80. Үндсэн хуулийн шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны шүүхийн хураамж нь энэхүү тайланд хэлэлцэж буй улс болгоны хувьд өөр өөр. АНУ-д Дээд шүүхэд доод шатны шүүхийн шийдвэрийг хянах шийдвэр гаргуулах хүсэлт гаргахад 300 долларын хураамж авдаг⁸⁵ бол Швейцарт хамгийн багадаа 200 швейцар франк, ихдээ 5000 швейцар франк,⁸⁶ Австрид хураамж нь одоогийн байдлаар 240 евро байна. ОХУ-д энэхүү хураамж нь нэг удаагийн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцдэг бол Арменид хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тав дахин нэмэгдүүлсэн хэмжээтэй тэнцэж байна. Израилд Дээд шүүхэд өргөдөл гаргахад ойролцоогоор 400 долларын хураамжтай байдаг боловч өргөдөл гаргагч нь онцгой нөхцөлд, хураамжаас чөлөөлөгдөх эсхүл үнийн дүнг бууруулах хүсэлт гаргах эрхтэй.

81. Венецийн Комиссын зүгээс **хэрвээ хэрэг үүсгэхэд хураамж төлөх ёстой тохиолдолд хураамжийн хэмжээ нь харьцангуй бага байх ёстой бөгөөд тэр ч байтугай нэхэмжлэл нь илт үндэслэлгүй биш л бол шүүх нэхэмжлэл гаргах санхүүгийн боломжгүй хүмүүсийн хураамжид өөрөөр хандах хэрэгтэйг зөвлөж байна.**⁸⁷ **Хураамжийн үндсэн зорилго нь илт урвуулан ашигласан өргөдөл, хүсэлтийг таслан зогсооход чиглэгдэх ёстой.**⁸⁸

⁸⁴ Өмнөд Африкт, Үндсэн хуулийн шүүхийн дүрмийн 4(11)(а)-д шүүхийн хэрэг бүртгэгч хэрэв аль нэг оролцогч талыг төлөөлөх этгээдгүй гэж үзвэл тэр шүүх уг оролцогчид туслах эрхтэй бөгөөд туслах хүсэлтэй этгээд эсхүл байгууллага руу хандуулна гэж заасан байдаг. Эрүүгийн хэргийн хувьд Өмнөд Африкийн Үндсэн хуулийн 35(2)(b) нь баривчлагдсан болон саатуулагдсан этгээдийн өөрсдийн сонгосон хуульчтай зөвлөлдөх эрхийг хүлээн зөвшөөрдөг бөгөөд 1977 оны 51-р Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд хэрэв шударга ёс ихээхэн зөрчигдвөл яллагдагчид улсын зардлаар төлөөлөгч гаргаж өгнө гэж зохицуулсан. Үндсэн хуулийн 28(1)(h)-д иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож буй хүүхдийн хувьд шударга ёс ихээхэн зөрчигдвөл төрөөс хуульч гаргаж өгөх бөгөөд хуульчийн зардлыг төр даана. Өмнөд Африкийн Эрх Зүйн Туслалцааны хөтөлбөр нь тодорхой нөхцөл байдалд төрөөс санхүүждэг хуульчаар хангах ба үүнийг 2014 оны 39-р акт болох Өмнөд Африк Хууль Зүйн туслалцааны хуулиар зохицуулдаг.

⁸⁵ АНУ-ын Дээд шүүхийн дүрмийн 38-р дүрэм.

⁸⁶ Холбооны шүүх нь хураамж ногдуулахгүй байж болно (Холбооны шүүхийн тухай хуулийн 66(1)). Холбоо, кантон, коммун, нийтийн эрх зүйн чиг үүрэг хүлээсэн байгууллага эсхүл хувь хүн гомдол гаргагч байсан ч мөн Холбооны Дээд шүүхэд гаргасан маргаан нь санхүүгийн ашиг сонирхолгүй бөгөөд холбогдох төрийн байгууллагын албан ёсны үйл ажиллагаатай холбоотой байвал мөн хураамж ногдуулахгүй байж болно. (Дээд шүүхийн тухай хуулийн 66(4)).

⁸⁷ Venice Commission, CDL-AD (2008)029, Opinion on the Draft Laws amending and supplementing (1) the Law on Constitutional Proceedings and (2) the Law on the Constitutional Court of Kyrgyzstan, para. 45.

⁸⁸ Venice Commission, CDL-AD(2008)029, Opinion on the draft laws amending and supplementing (1) the Law on constitutional proceedings of Kyrgyzstan and (2) the Law on the Constitutional Court of

4. Бичгэн хэлбэр

82. Үндсэн хуулийн шүүхэд өргөдлийг бичгээр гаргах ёстой бөгөөд заримдаа маш хатуу хэлбэрийн шаардлагыг хангах ёстой болдог. Жишээлбэл, АНУ-д өргөдлийн хуудасны урт, тэр ч байтугай баримт бичгийн хавтасны өнгийг Дээд шүүхийн дүрмээр тодорхойлдог.

83. Эдгээр дүрэм нь ил тод байдал болон эргээд өргөдөл гаргагчтай холбогдох боломжтой байх зорилгыг агуулдаг. Гэхдээ, **өргөдөл гаргагчид зохих боломжит хугацаанд мэдүүлгээ засах эсхүл бүрдүүлэх боломж олгох шаардлагатай**. Энэ нь хэлбэрийн шаардлага маш хатуу тохиолдолд онцгой чухал юм. Хууль ёсны төлөөлөл заавал шаарддаггүй газруудад бүр илүү чухал (жишээлбэл, Хорват,⁸⁹ Эстони,⁹⁰ Хойд Македон, Словени⁹¹). Ерөнхийдөө, ингэснээр хэлбэрийн шаардлага хангаагүй гэх үндэслэлээр хянахаас татгалзах эрсдэлийг бууруулдаг.

5. Илт үндэслэлгүй, хөнгөмсгөөр хандсан, урвуулан ашигласан, давтан гаргасан өргөдөл

84. Талууд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эрхээ шударгаар (*bona fide*) хэрэгжүүлэх үүрэгтэй.⁹² Өргөдөл гаргагч нь үндсэн хуулийн шүүхэд хандах эрхээ урвуулан ашигласан тохиолдолд үндсэн хуулийн хяналтын үр нөлөөг гажуудуулдаг. Хүний эрхийг хамгаалахад хувь хүний гомдол гаргах процедур маш чухал боловч энэ процедурыг урвуулан ашиглавал үндсэн хуулийн дэг журамд халтай. **Венецийн комисс, үндсэн хуулийн шүүхүүд илт үндэслэлгүй, хөнгөмсгөөр хандсан, урвуулан ашигласан, давтан гаргасан гомдлыг хүлээн авахаас татгалзах арга хэрэгсэлтэй байх хэрэгтэй гэж үзэж байна.**⁹³

85. Энэхүү тайланд хамрагдсан улс орнууд урвуулан ашигласан өргөдөлтэй тэмцэх янз бүрийн арга замтай байдаг. Жишээлбэл, ОХУ-д өргөдөл гаргагч нь үндсэн хуулийн шүүхээс аль хэдийн шийдсэн асуудлаар дахин өргөдөл гаргасан бол уг шийдвэрийн хуулбарыг өргөдөл гаргагчид дахин илгээж, энэ асуудлаар тэдэнд хандах боломжгүй тухай мэдэгдэнэ. Цаашид ижил асуудлаар тухайн хувь хүний гаргасан дараагийн гомдолд хариулахгүй байна.⁹⁴ Бусад улс орнууд

Kyrgyzstan, para. 45; Venice Commission, CDL-AD(2014)017, Opinion on the Draft Constitutional Law on the Constitutional Court of Tajikistan, para. 46.

⁸⁹ Бүгд Найрамдах Хорват Улсын Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн 19(2) үзнэ үү.

⁹⁰ Үндсэн хуулийн шүүхэд маргаан хянан шийдвэрлэх хуулийн 20-р зүйл.

⁹¹ Энэ нь үндсэн хуулийн гомдол гаргахад л үйлчилнэ. Үндсэн хуулийн шүүхийн 55(1) хэсгийг үзнэ үү.

⁹² Тухайлбал, Армены Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн 48(5) хэсэг; Казахстаны Үндсэн хуулийн зөвлөлийн тухай хуулийн 21-р зүйл.

⁹³ Venice Commission, CDL-AD(2002)005, Opinion on the Draft Law on the Constitutional Court of the Republic of Azerbaijan, para. 8.

⁹⁴ ОХУ-ын Үндсэн хуулийн шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмын 9.4 дэх хэсэг.

Венецийн комисс

урвуулан ашигласан өргөдөл гаргагчдыг торгохыг шүүхэд зөвшөөрдөг (жишээ нь, Герман⁹⁵).

6. Эрх зүйн хамгаалалтын бүх арга хэрэгслийг хэрэглэж дуусгах

86. Ихэнхдээ хувь хүн гагцхүү эрх зүйн бүх хамгаалалтын арга хэрэгслийг хэрэглэж дууссаны дараа л үндсэн хуулийн иж бүрэн буюу норматив гомдол гаргаж болдог (жишээ нь, Албани, Андорра, Армени, Азербайжан, Бразил, Хорват, Чех, Герман, Унгар, БНСУ, Латви, Лихтенштайн, Мальта, Монтенегро, Хойд Македон, Польш, Португал, Словак, Словени, Испани,⁹⁶ Швейцар, Турк). Иймд Үндсэн хуулийн шүүхийн бүрэн эрх нь субсидиар зарчмаар хязгаарлагдаж байна. Өөрөөр хэлбэл, маргаан бүхий актыг бүх шатны ердийн шүүхээр шийдвэрлэсэн эсхүл ердийн шүүхэд давж заалдах боломжгүй тохиолдолд л шийдвэрлэж болно.⁹⁷ Дотоодын эрх зүйн тодорхой агуулгын хүрээнд эрх зүйн хамгаалалт өөр өөр утгатай байж болно.

87. Үндсэн хуулийн асуудлаар гомдол гаргахад эрх зүйн бүхий л хамгаалалтын аргыг хэрэглэх урьдчилсан нөхцөл зөвхөн хяналтын төвлөрсөн тогтолцоотой улсад бий. Төвлөрсөн бус хяналтын тогтолцоотой улсад хувь хүн шүүхийн аль ч шатанд нэг бүрчилсэн эсхүл норматив актыг үндсэн хуульд нийцээгүй гэх үндэслэлээр гомдол гаргаж болно.

88. Эрх зүйн бүх хамгаалалтыг хэрэглэсэн байх нь хувь хүнд нөхөж баршгүй хохирол учруулж болзошгүй тохиолдолд заавал бүх эрх зүйн бүх хамгаалалт ашигласан байхыг шаардахгүй (жишээ нь, Австри, Азербайжан, Хорват, Чех, Герман, Латви, Монтенегро, Словак, Словени, Швейцар гэх мэт). **Энэхүү дүрмийг дагаж мөрдөх нь тухайн хувь хүнд нөхөж баршгүй хохирол учруулж болзошгүй тохиолдолд бүх эрх зүйн хамгаалалт хэрэглэсэн байхыг шаардахгүй** гэж Венецийн Комисс үзэж байна.⁹⁸

⁹⁵ Жишээлбэл, ХБНГУ-ын Холбооны Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн 34(2) -т заасны дагуу Үндсэн хуулийн асуудлаарх гомдол, эсхүл сонгуулийн хяналт шалгалтын ажиллагаатай холбоотой гомдол нь хуулийг урвуулан ашигласан, болон хэрэв түр арга хэмжээ авхуулах тухай хүсэлтийг урвуулан ашигласан бол шүүх 2600 еврогийн торгууль ногдуулдаг.

⁹⁶Испанийн парламент, түүний аль нэг байгууллага, эсхүл Автономит нийгэмлэгүүдийн хууль тогтоох ассамблей, тэдгээрийн байгууллагаас гаргасан, хуулийн хүчин чадалгүй шийдвэр, тогтоомж нь Үндсэн хуулиар хамгаалсан эрх, эрх чөлөөг зөрчсөн бол тэдгээрийн эсрэг Үндсэн хуулийн шүүхэд шууд хандаж болно (Үндсэн хуулийн шүүхийн тухай органик хуулийн 42-р зүйл).

⁹⁷ Venice Commission, CDL-AD(2018)012, Amicus curiae brief for the Constitutional Court of Georgia on the effects of Constitutional Court decisions on final judgments in civil and administrative cases, para. 26.

⁹⁸ Venice Commission, CDL-AD(2012)009, Opinion on Act CL I of 2011 on the Constitutional Court of Hungary, para. 54(4); Venice Commission, CDL-AD(2008)03, Opinion on the Draft Law on the Constitutional Court of Montenegro, para. 60.

7. Шууд болон гэнэтийн хор уршиг

89. Ихэнх улсад үндсэн эрх нь зөрчигдсөн өргөдөл гаргагч үндсэн хуулийн асуудлаар гомдол гаргахын тулд хохирсон байх ёстой байдаг. Үндсэн хуулийн хяналтыг тодорхой хэрэгт холбогдуулан зөвшөөрдөг улсад ийм шаардлага бий.

90. Ихэнх улс өргөдөл гаргагч нь өөрт учирсан хохирол нь хангалттай тодорхой бөгөөд үндсэн хуультай үл нийцсэн актаас шалтгаалсан гэдгийг нотлохыг шаарддаг. Жишээлбэл, АНУ-д өргөдөл гаргагчийн хуулиар хамгаалагдсан ашиг сонирхолд тодорхой, тусгайлсан бөгөөд бодит буюу угарцаагүй хохирол учирсан байхыг шаарддаг. Түүнчлэн, хохирол болон шүүхэд үүсгэсэн ажиллагааны хооронд шалтгаант холбоо байх ёстой.⁹⁹ Тэр байтугай, зарим улсын үндэсний хууль тогтоомжид хохирол хангалттай учирсан чухал байхыг шаарддаг (жишээ нь, Словени¹⁰⁰).

91. Гэхдээ зарим улс хохирогчоос өөр этгээдэд хохирогчийн өмнөөс үндсэн хуулийн гомдол гаргахыг зөвшөөрдөг. Тухайлбал, эрх зүйн чадамжгүй хүний өмнөөс хууль ёсны төлөөлөгчид (тухайлбал, гэр бүл, хамаатан, багш, мөн төрийн байгууллага¹⁰¹) үйлдэл хийж болно. Өмнөд Африкийн зохицуулалтаар хохирогчийн нэрийн өмнөөс хэн ч үйлдэл хийж болох эрх олгосон. Зарим улсад хэрэв тухайн хувь хүн аливаа актаас болж шууд болон тэр дороо хохироогүй бол тэд норматив актыг абстрактаар хянах ажиллагааг үүсгэж болно (*actio popularis*-дээрхийг харна уу).

8. Хохирол барагдуулах боломж

92. Үндсэн хуулийн хяналтын ажиллагаагаар өргөдөл гаргагчийн нөхцөл байдлыг мэдэгдэхүйц хэмжээгээр өөрчлөхгүй бол өргөдлөөс татгалзаж болно (жишээлбэл, Франц,¹⁰² Герман¹⁰³ эсхүл Өмнөд Африк¹⁰⁴). Тухайлбал АНУ-д, өргөдөл гаргагчид учирсан хохирлыг барагдуулах шүүхийн нааштай шийдвэр гарч байж хохирлоо барагдуулах боломжтой болно.¹⁰⁵

93. Урьдчилсан хяналтын ажиллагааны явцад энэ үнэлгээг хийхэд заримдаа хүндрэлтэй байдаг. Иймд **үндсэн хуулийн шүүхийн шийдвэр нь хохирол**

⁹⁹ *Lujan v. Defenders of Wildlife*, 504 U.S. 555 (1992)

¹⁰⁰ Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн 55(a) хэсэгт хүний эрх, үндсэн эрх чөлөө зөрчигдсөн нь гомдол гаргагчийн хувьд ноцтой үр дагаваргүй бол үндсэн хуулийн гомдлыг хүлээн авахгүй гэж заасан.

¹⁰¹ Жишээлбэл, Монтенегрогийн Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн 59-р зүйл, Өмнөд Африкийн Үндсэн хуулийн 38-р зүйлийг үзнэ үү.

¹⁰² Өргөдлөөс татгалзсан тохиолдолд уг шийдвэрийг давж заалдах боломжгүй.

¹⁰³ Хэрэв өргөдөл амжилттай байсан ч өргөдөл гаргагчийн нөхцөл байдлыг өөрчлөхгүй бол хэргийг хэрэгсэхгүй болгож болно. Гэхдээ, ерөнхийдөө хохирол барагдуулах боломжтой байлгах шаардлагыг (*Rechtsschutzbedürfnis* гэж нэрлэдэг) хангасан гэж үздэг.

¹⁰⁴ *S v Shaik and Others*, CCT 86/06, 02 October 2007, ZACC 19, in CODICES.

¹⁰⁵ *Lujan v. Defenders of Wildlife*, 504 U.S. 555 (1992)

барагдуулахад үр нөлөөгүй гэдэг нь илэрхий тохиолдолд хохирол барагдуулах боломжгүй байдал нь зөвхөн өргөдөл хянахаас татгалзахад хүргэх ёстой.

9. Урьдчилсан хүсэлтийн шүүлтүүр

94. Үндсэн хуулийн шүүхэд ердийн шүүх урьдчилсан хүсэлтийг гаргадаг. Дээр хэлэлцсэнчлэн, ердийн шүүх нь үндсэн хуулийн шүүхэд урьдчилсан хүсэлт гаргах шүүлтүүр болж болно. Хүлээн авах боломжтой асуулт эсэх талаарх тусгай зохицуулалт бий.

95. Үндсэн хуулийн шүүх нь үндсэн хуулийн шүүхийн харьяалал биш эсхүл процессын алдаа гарсан гэсэн үндэслэлээр урьдчилсан хүсэлтээс татгалзаж болно (жишээ нь: Андорра, Азербайжан, Беларусь, Чех, Гүрж, Бүгд Найрамдах Молдова). Бусад улсад үндсэн хуулийн шүүх нь асуултаа дахин боловсруулах боломжийг олгохын тулд хүсэлтийг ердийн шүүхэд буцаадаг (жишээлбэл, Албани, Чили, Литва, Хойд Македон). Үүний эсрэгээр, Германд үндсэн хуулийн шүүх алдаа дутагдалтай хүсэлтийг нэмэлт, өөрчлөлт оруулахаар ердийн шүүхэд буцаах эрхгүй. Хэрэв тухайн хэргийг шийдвэрлэх нь үндсэн хуулийн шүүхийн хариултаас хамаарахгүй бол үндсэн хуулийн шүүх урьдчилсан асуулт хүлээн авахаас татгалздаг (жишээлбэл, Герман, Итали, Польш, Сан Марино гэх мэт).

96. **Тухайн хэрэгт хэрэглэх ёстой эрх зүйн зохицуулалт үндсэн хуульд нийцсэн эсэхээс шүүхийн шийдвэрийн үр дүн хамаарч байгаа тохиолдолд урьдчилсан асуултын ажиллагааг үүсгэх эрхтэй ердийн шүүхийг хүчин төгөлдөр асуулт боловсруулна гэсэн хүлээлт байж болох тул урьдчилсан хүсэлтэд тавих эдгээр шүүлтүүрийг хүлээн зөвшөөрөх боломжтой гэж Венецийн Комисс үзэж байна.**

10. Ижил төрлийн хэргийг нэгтгэх

97. Зарим улсад ижил асуулттай холбоотой нэхэмжлэлийг нэг журмаар хянан шийдвэрлэж болдог (жишээ нь, Армен, Австри, Чили, Чех, Латви,¹⁰⁶ Литва, Хойд Македон, Орос, Словак, Словени, Өмнөд Африк,¹⁰⁷ Украин, Америкийн Нэгдсэн Улс). Израилд ижил төстэй нэхэмжлэл гаргасан этгээдүүд өөрсдийнх нь өргөдлийг нэгтгэхийг шүүхээс хүсэж болно.

98. **Хэрэв ижил төстэй хэрэг их байгаа бол шүүх нэг буюу хэд хэдэн парадигматик хэргийг шийдвэрлэх боломжтой байх ёстой ба, хүлээн**

¹⁰⁶ Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн 22(6) хэсэгт: “Хэргийг шуурхай, цогцоор нь шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор хоёр буюу түүнээс дээш хэргийг нэг хэрэгт нэгтгэх, түүнчлэн нэг хэргийг хоёр буюу түүнээс дээш хэрэгт хуваахыг зөвшөөрнө.”

¹⁰⁷ Constitutional Court of South Africa, Decision CCT 24/08 and CCT 52/08, 21 January 2009, in CODICES.

зөвшөөрөх боломжгүй бөгөөд эрх зүйн үндэслэл аль алинтай холбоотой ижил төстэй нэхэмжлэлийн журмыг хялбарчлах хэрэгтэй.

В. Үндсэн хуулийн шүүхийн хэрэг сонгох байдал

99. Гомдлын тоог хязгаарлах процедурын хэлбэрийн дүрэм журмаас гадна үндсэн хуулийн шүүхийн хянан хэлэлцэх хэргээ сонгох эрх хэмжээ янз бүр. Нэг хандлага нь ямар хэрэг хянахаа өөрөө бүрэн шийдэх эрх мэдэлтэй АНУ-ын Дээд шүүх байна. Хувь хүн АНУ-ын Дээд шүүхэд давж заалдах эрхгүй. Үүний оронд *writ of certiorari* (дээд шүүхээс доод шатны шүүхийн шийдсэн хэргийн материалыг татаж хянах зөвшөөрөл) хүсэх ёстой байдаг. Шүүх үндсэн хуулийн дэг журмыг хамгаалах эсхүл жишгийн эрх зүйг хөгжүүлэхэд хамааралтай гэж үзсэн хэргийг сонгоно.¹⁰⁸ Эдгээр *writ of certiorari*-г Аргентин зэрэг бусад улсад мөн ашигладаг.¹⁰⁹

100. Эсрэгээрээ үндсэн хуулийн шүүхэд хэргийг хэрэгсэхгүй болгох харьцангуй бага эрх мэдэл олгосон улсууд бий. Гэхдээ Герман,¹¹⁰ Унгар,¹¹¹ Словени,¹¹² Испани¹¹³ улсууд үндсэн хуультай нийцсэн эсэх талаар хангалттай ерөнхий ач холбогдол бүхий асуудал үүсгэхгүй гомдлыг хэрэгсэхгүй болгох боломжийг үндсэн хуулийн шүүхэд олгодог. Испанийн Үндсэн хуулийн шүүх энэ заалтыг өргөн хүрээнд тайлбарлаж, улмаар хэргийг хэрэгсэхгүй болгох эрхээ өргөжүүлсэн. Энэ тал дээр Германы практикийг дурдууштай. Үндсэн хуулийн

¹⁰⁸ АНУ-ын Дээд шүүхийн 10-р дүрэм: “*Writ of certiorari*-г хянах нь эрх биш, харин шүүхийн бүрэн эрхийн асуудал юм. Зөвхөн хүндэтгэн үзэх шалтгааны улмаас *writ of certiorari*-г хүлээн авна.”

¹⁰⁹ Иргэний болон арилжааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 280 дугаар зүйл.

¹¹⁰ Холбооны Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн 93(а)-д “(1) Үндсэн хуулийн гомдлыг шийдвэрлэхээр хүлээн авна. (2) Гомдлыг дараах тохиолдолд хүлээн авна а) Үндсэн хуулийн ерөнхий ач холбогдолтой бол, б) § 90(1)-д дурдсан эрхийг хэрэгжүүлэхэд тохиромжтой бол; хэрэв шүүх гомдлыг шийдвэрлэхээс татгалзсан тохиолдолд гомдол гаргагчид ноцтой хохирол учрах бол гомдлыг мөн хүлээн авч болно.”

¹¹¹ 2011 оны Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн 29-р зүйлийн дагуу: “Үндсэн хуультай зөрчилдсөн нь шүүхийн шийдвэрт ноцтой нөлөөлсөн, эсхүл тухайн хэрэг нь үндсэн хуулийн эрх зүйн зарчмын ач холбогдол бүхий асуудал үүсгэсэн тохиолдолд үндсэн хуулийн шүүх нь үндсэн хуулийн маргааныг хүлээн авна” гэж заасан байдаг.

¹¹² Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн 55(б)(2): “Дараах тохиолдолд үндсэн хуулийн гомдлыг хянан хэлэлцэнэ:

- гомдол гаргагчид ноцтой үр дагавар учруулсан, хүний эрх эсхүл үндсэн эрх чөлөөний зөрчил гарсан бол;

- хэрэв тухайн тодорхой хэргийн ач холбогдлоос давсан үндсэн хуулийн чухал асуудалтай холбоотой бол.”

¹¹³ Үндсэн хуулийн шүүхийн тухай органик хуулийн 50(1) хэсэгт зааснаар “Дараах шаардлагыг гагцхүү хангасан бол Хэсгийн бүрэлдэхүүн нь санал нэгтгэйгээр үндэслэл заагаагүй тогтоол (*providencia*) -р бүхэлд нь эсхүл хэсэгчлэн давж заалдах гомдлыг хүлээн авахыг зөвшөөрнө. Үүнд: ... б) давж заалдаж буй хэрэг нь үндсэн хуулийг тайлбарлах, хэрэглэхэд хамааралтай эсэх, эсхүл түүний үр дүнтэй байдал болон үндсэн эрхийн агуулга буюу хамрах хүрээг тодорхойлох зорилгоор үндсэн хуулийн онцгой ач холбогдолтой (*especial transcendencia constitucional*) учраас Үндсэн хуулийн шүүхийн зөвшөөрсөн шийдвэрийг нотолж байвал.”

гомдол гэж анх харахад мэдэгдээгүй өргөдлийг шууд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бүртгэлд бус, "ерөнхий бүртгэл"-д бүртгэнэ. Дараа нь өргөдөл гаргагчид уг өргөдлийг Үндсэн хуулийн шүүхэд цаашид хянан шийдвэрлэх талаар хүсэлт гаргах боломжийн талаар албан бус захидлаар мэдэгдэнэ. Өргөдөл гаргагч тус шүүхээр шийдүүлэх байр суурьтай бол түүний хүсэлтийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бүртгэлд бүртгэнэ, үгүй бол ерөнхий бүртгэлд хэвээр үлдэнэ.¹¹⁴ Үүний үр дүнд гомдлыг хэрэгсэхгүй болгохгүйгээр, мөн уг процедурын шатанд шүүгчийн оролцоогүйгээр олон хүсэлтийг шийдвэрлэх боломжтой юм. Өмнөд Африкт, Үндсэн хуулийн шүүх нь үндсэн хуулийн асуудал хөндөж байгаа эсхүл шүүхээр хэлэлцвэл зохих нийтийн ач холбогдол бүхий бусад маргаантай хуулийн заалтыг агуулсан бол шууд хандаж гаргасан хүсэлт эсхүл давж заалдах гомдлыг хэлэлцэж болно.¹¹⁵ Үндсэн хуулийн шүүх тухайн хэргийг хүлээж авах эсэхийг хэрэг амжилттай шийдэгдэх магадлал, тухайн асуудал дахь нийтийн ашиг сонирхол болон давж заалдах шатны дээд шүүх тухайн асуудлаар үзэл бодлоо илэрхийлэх боломжтой байсан эсэх зэрэг хэд хэдэн дэд асуулт тавигдана. Эдгээр зарим улсад үндсэн хуулийн шүүх ямар хэргийг хянахаа өөрийн үзэмжээр шийдэх эрхийг илүү олгох эсэх талаар хэлэлцүүлэг үргэлжилж байна (жишээ нь Словени гэх мэт).

101. *Writs of certiorari*-ийн давуу тал нь үндсэн хуулийн шүүх өөрөө хэргийн ачааллаа хянах боломжтой бөгөөд хэт ачаалал үүсэх эрсдэлтэй ховор тулгардаг. *Writs of certiorari*-ийн илэрхий сул тал нь хувь хүний эрхийг хамгаалах эрх зүйн хамгаалалтын үр нөлөөг бууруулдаг явдал юм. Гэхдээ, *certiorari* эсхүл түүнтэй адилтгах механизмгүй тохиолдолд зохицуулах аргагүй ачаалал нь үндсэн хуулийн шүүхийг хэргийн ачааллаа хязгаарлах өөр механизмыг бий болгоход хүргэж болзошгүй (жишээлбэл, хэрэг хүлээж авах шаардлагыг маш өргөн хүрээнд зохицуулах). Ийм механизмыг ашиглах нь ихэвчлэн хаалттай явагддаг бөгөөд шүүх үүнийг үгүйсгэдэг. Иймээс дааж давахын аргагүй ачаалалтай болох үед үндсэн хуулийн шүүхийн нарийн шинжилгээ хийлгэвэл зохих хэргүүдийг хүний эрхийг хамгаалах зарчмыг баримтлан сонгож болох юм.

С. Танхимын шүүх хуралдаан

102. Янз бүрийн хуралдаан, шүүх бүрэлдэхүүн, танхимын ажлын хуваарилалтын тогтолцоо нь үндсэн хуулийн шүүхийн ачааллыг бууруулахад нэмэртэй байж

¹¹⁴ Merkblatt über die Verfassungsbeschwerde zum Bundesverfassungsgericht, available at: http://www.bundesverfassungsgericht.de/DE/Homepage/_zielgruppeneinstieg/Merkblatt/Merkblatt_no_de.html.

¹¹⁵ Үндсэн хуулийн 167(3)-т үндсэн хуулийн шүүх зөвхөн үндсэн хуулийн асуудал болон үндсэн хуулийн асуудлаар гарсан шийдвэртэй холбоотой хэргийг шийдвэрлэж болно гэж заасан. Тухайн асуудал үндсэн хуулийн асуудал мөн эсэхийг шүүх өөрөө эцэслэн шийдвэрлэдэг.

болно.¹¹⁶ Цөөн шүүгчтэй бүрэлдэхүүн нь хэргийг хүлээж авах эсэх тухай шийдвэрлэж, харин хэргийн агуулгын ач холбогдол нэмэгдэхтэй хамт шүүх бүрэлдэхүүний тоо мөн нэмэгдэж болно. **Хэргийг танхимуудад хуваарилах эсхүл бүрэлдэхүүнд хуваарилахдаа нэг талыг баримтлуулахаас зайлсхийх тодорхой дүрэм журамтай байх шаардлагатай** гэж Венецийн комисс үзэж байна. **Иймд хэргийг автоматаар хуваарилах нь танхим эсхүл шүүгчийн мэргэшлийг тооцож чадах учир дээрх шаардлагад хүрэх хамгийн сайн арга юм.**¹¹⁷

103. Хувь хүн үндсэн хуулийн шүүхэд хандах эрхтэй улсад ихэнхдээ цөөн шүүгчтэй бүрэлдэхүүн хэргийг хянах эсэх асуудлыг шийддэг. Хэрэв өргөдөл амжилттай шийдэгдэх магадлал бага (жишээ нь, Австри, Герман, Словени гэх мэт) эсхүл хэрэг хүлээж авах албан ёсны шаардлага хангагдаагүй (жишээ нь, Чили) бол шүүгчдийн бүрэлдэхүүн хянахаас татгалзана. Жишээ нь, Израилд гурван шүүгчээс бүрдсэн шүүх бүрэлдэхүүн өргөдлийг шууд хараад үндэслэлгүй гэж үзвэл түүнийг буцааж болно.¹¹⁸ Ингэснээр хэрэг хүлээж авах ажиллагааны хэлбэрийн шаардлага бага тул үндсэн хуулийн шүүхийн ачааллыг шууд бууруулахад хүргэдэг. ХБНГУ-д хувь хүний гомдлыг Холбооны Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн § 93 а-д заасны дагуу гурван шүүгчийн бүрэлдэхүүнтэй танхим (эсхүл Сенатын аль нэг нь) хүлээн авна. Хэрэв тухайн хэрэг илт үндэслэлтэй бөгөөд хэргийг тодорхойлсон үндсэн хуулийн асуудал зарчмын хувьд дээд шатны Сенатын аль нэг танхимаар шийдвэрлэсэн бол бага танхим нь § 93с(1)-ийн дагуу хэргийг шийдвэрлэх эрхтэй.

104. Энэхүү тайланд тусгагдсан үндсэн хуулийн шүүхийн шүүгчдийн бүрэлдэхүүний шүүгчдийн тоо эрс ялгаатай байна. Гурваас арван нэгэн шүүгчтэй бүрэлдэхүүн ч байж болно. Дийлэнх улсад шүүгчдийн бүрэлдэхүүн зургаа хүртэлх шүүгчээс бүрддэг (жишээ нь, Австри, Босни Герцеговина, Чех, Хорват, Эстони, Гүрж, Унгар, Люксембург, Мальта, Монако, Монтенегро,¹¹⁹ Норвег, Польш, Словак, Испани, болон Швейцар). Зарим улсад үндсэн хуулийн шүүх бүх шийдвэрийг

¹¹⁶ Энэ тайланд зөвхөн хувь хүний үндсэн хуулийн хяналтад хандах эрхтэй холбоотой асуудлыг шийдвэрлэдэг этгээдийг (жишээ нь, нэгдсэн хуралдаан, хурал, танхим) хамруулсан.

¹¹⁷ Venice Commission, CDL-AD(2011)040, Opinion on the law on the establishment and rules of procedure of the Constitutional Court of Turkey, para. 39.

¹¹⁸ Дээд шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмын 5-р зүйл.

¹¹⁹ Монтенегро улсын Үндсэн хуулийн 151 дүгээр зүйл. Venice Commission, CDL-AD(2014)033, Opinion on the draft Law on the Constitutional Court of Montenegro, paras. 39-40.

нэгдсэн хуралдаанаар гаргадаг (жишээлбэл, Албани,¹²⁰ Армен, Чили, Кипр,¹²¹ Грек, Латви, Лихтенштайн, Хойд Македон, Румын, Словени¹²²). Бусад улсад шүүх бүрэлдэхүүний тоо хэргийн ач холбогдлоос хамаарна. Жишээлбэл, Израйлд Дээд шүүхийн дарга эсхүл дэд ерөнхийлөгч аман мэтгэлцээний өмнө шүүгчдийн бүрэлдэхүүнийг тэгш бус тоогоор нэмэх шаардлагатай гэж үзээгүй тохиолдолд Дээд шүүх ихэвчлэн гурван шүүгчийн бүрэлдэхүүнтэй байдаг. Тэрчлэн, хэрвээ тухайн өргөдөл чухал эсхүл прецедент болохоор асуудал хөндөж байна гэж үзвэл шүүх бүрэлдэхүүн өөрийн бүрэлдэхүүний шүүгчдийн тоог нэмэх шийдвэр гаргах эрхтэй. Португалд үндсэн хуулийн шүүх хуралдаан хийгээгүй тохиолдолд танхим нь нэг, гурав эсхүл таван шүүгчээс бүрддэг.

105. Шүүхийн нэгдсэн хуралдааныг зөвхөн шинэ эсхүл чухал асуудлыг шийдвэрлэх үед хэрэг шийдвэрлэх цөөн тооны шүүгчдийн бүрэлдэхүүнийг өөрсдийн эрх хэмжээгээр бүрдүүлэх нь шүүхийн ачааллыг хөнгөвчлөх сайн арга байж болно гэж Венецийн Комисс үзэж байна.¹²³ Үндсэн хуулийн шүүх байгуулж байгаа хуулиар хэрэв танхимуудын шийдвэр зөрчилдвөл нэгдсэн хуралдаанаар шийдвэр гаргах боломжийг бүрдүүлэх хэрэгтэй.¹²⁴ Ингэснээр нэгдсэн хуралдааны шийдвэр нь үндсэн хуулийн шүүхийн нэгдмэл байдлыг хадгална. Гэхдээ үндсэн хуулийн томоохон ач холбогдолтой асуудалтай холбоотой хэргийг танхимаас нэгдсэн хуралдаанд шилжүүлэх боломжтой

¹²⁰ Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн 31-р зүйлд зааснаар: “(1) Өргөдлийг тухайн хэрэгт харьяалах шүүгчийг оролцуулан Үндсэн хуулийн шүүхийн 3 /гурав/ шүүгчийн бүрэлдэхүүнтэй урьдчилсан байдлаар хэлэлцэнэ. [...] (3) Өргөдлийг хууль ёсны этгээд гаргасан бөгөөд Үндсэн хуулийн шүүхийн бүрэн эрхэд хамаарах тохиолдолд шүүх бүрэлдэхүүн түүнийг шүүх хуралдаанд танилцуулахаар шийдвэрлэнэ. Өргөдөл нь Үндсэн хуулийн шүүхийн бүрэн эрхэд хамаарахгүй бол шүүх хуралдаанаас татгалзсан шийдвэр гаргана. Аливаа тохиолдолд шүүгчдийн аль нэг нь эсрэг саналтай байвал нийт шүүгчдийн урьдчилсан хуралдаанд өргөдлийг танилцуулж, олонхын саналаар шүүх хуралдаанаас өргөдлийг хүлээн авах, эсхүл татгалзах шийдвэр гаргана.”

¹²¹ Бүгд Найрамдах Кипр Улсын Ерөнхийлөгч хууль батламжлахаас өмнө тухайн хуулийг үндсэн хуульд нийцэж байгаа эсэхийг шалгах зорилгоор Үндсэн хуулийн шүүхэд хандсан тохиолдолд Үндсэн хуулийн шүүх нэгдсэн хуралдаан хийнэ. Үүний нэгэн адил үндсэн хуультай холбоотой чухал хэргүүдийг Улсын дээд шүүхийн бүх гишүүд хэлэлцдэг. Бусад тохиолдолд (жишээ нь, давж заалдах хэрэгт) дээд шүүх гурав эсхүл таван шүүгчийн бүрэлдэхүүнтэй байна.

¹²² Гурван шүүгчээс бүрдсэн шүүх бүрэлдэхүүн үндсэн хуулийн гомдлыг агуулгаар нь авч хэлэлцэх эсэхийг шийднэ (Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн 55(в)).

¹²³ Venice Commission, CDL-AD(2011)010, Opinion on the draft amendments to the Constitution of Montenegro, as well as on the draft amendments to the law on courts, the law on the state prosecutor's office and the law on the judicial council of Montenegro, para. 25; Venice Commission, CDLAD(2004)024, Opinion on the draft constitutional amendments with regard to the Constitutional Court of Turkey, para. 14; Venice Commission, CDL-AD(2018)012, Amicus curiae brief for the constitutional court of Georgia on the effects of constitutional court decisions on final judgments in civil and administrative case, para. 29.

¹²⁴ Venice Commission, CDL-AD(2004)024, Opinion on the draft constitutional amendments with regard to the Constitutional Court of Turkey, para. 13.

байхыг Венецийн комисс зөвлөж байна. Харин нэгдсэн хуралдаан танхимаас ирүүлсэн хүсэлтээс татгалзах боломжтой байвал зохино.¹²⁵

D. Хүлээж авахаас татгалзсан шийдвэрийг давж заалдах нь

106. Хүлээж авахаас татгалзсан шийдвэрт давж заалдах гомдол гаргах нь гомдол хүлээж авах шалгуурт нэгдсэн хандлага тогтооход хэрэгтэй байж болно. Гэхдээ давж заалдах гомдол гаргах нь үндсэн хуулийн шүүхийн ачааллыг нэмэгдүүлж болзошгүйг Венецийн комисс ойлгож байна.

107. Давж заалдахтай холбоотойгоор үндсэн хуулийн шүүхийн ачаалал нэмэгдэхээс сэргийлэх нэг арга нь тухайн өргөдлийг зөвхөн шүүх бүрэлдэхүүн санал нэгтгэйгээр хүлээж авахгүй гэж шийдсэн тохиолдолд л татгалзах бөгөөд хэрэв шүүгчид санал нийлэхгүй бол хэргийг танхимд шилжүүлэх шаардлагыг хангах явдал юм.¹²⁶ Өргөдөл болон давж заалдах гомдлын тоо нь гагцхүү үндсэн хуулийн шүүхийн үйл ажиллагааг саатуулахаар хэмжээнд хүрэхээр их байгаа тохиолдолд л улс орнууд хэрэг хүлээн авахаас татгалзсан шийдвэрийг давж заалдах боломжийг хязгаарлавал зохино гэж Венецийн комисс үзэж байна.

VI. ҮНДСЭН ХУУЛИЙН ШҮҮХЭД ХАНДАХ ТУХАЙ

108. Хувь хүний хандалтаар үүссэн үндсэн хуулийн хяналтын ажиллагаа нь үндсэн хуульд заасан хувь хүний эрхэд тусгайлан буюу голлон чиглэгддэг. Эдгээр эрхийг хамгаалахын тулд үндсэн хуулийн шүүхийн тухай олон хуулиудад тодорхой процедурын хамгаалалтыг тусгасан байдаг. Үндсэн хуулийн шүүх зарим тохиолдолд үндсэн хуулийн заалтыг илүү сайн хэрэгжүүлэхийн тулд хувь хүний хэрэг маргааны хүрээнээс давуулж шийдвэр гаргаж хянах хүрээгээ өргөтгөхөөр шийдэж болно. Хэрэв өргөдлөөсөө татгалзсан, маргаантай акт хүчин төгөлдөр бус болсон, эсхүл шийдвэр гаргах хугацаа дууссан тохиолдолд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг зогсоож болно.

A. Материаллаг эрх

109. Хувь хүний үндсэн хуулийн шүүхэд хандах эрхийн асуудал хөндөгдөж байгаа үед үндсэн хуулийн хяналт нь үндсэн эрхэд тусгайлан төвлөрөх буюу наад зах нь энэ асуудалд голлон төвлөрдөг. Энэхүү тайланд авч үзсэн бүх үндсэн хуульд хэд хэдэн үндсэн эрхийг агуулсан буюу үндсэн хуулийн эсхүл дор хаяж хуулиас илүү статустай үндсэн эрхийг эш татсан байна. 1791 оны Францын

¹²⁵ Venice Commission, CDL-AD(2017)001, Opinion on Questions Relating to the Appointment of Judges of the Constitutional Court of Slovak Republic, para. 42.

¹²⁶ Venice Commission, CDL-AD(2014)020, Opinion on the Draft Constitutional Law on Introduction Amendments and Additions to the Constitutional Law on the Constitutional Chamber of the Supreme Court of Kyrgyz Republic, paras. 15-16.

Үндсэн хуульд заасанчлан, хувь хүн шүүхэд хандах боломжтой байхын тулд хүний эрхийг үндсэн хуульд текстийн нэг хэсгээр эсхүл хавсралт хэлбэрээр заавал тусгасан байх ёстой.

110. Гэхдээ үндсэн хуульд заасан бүх эрх бүхий л хэрэгт хянах стандарт болохгүй. Зарим эрхүүд нь програмчлагдсан шинжтэй байдаг бөгөөд програмчлагдсан хэм хэмжээ эсхүл улсын зорилтыг зөрчсөн зөрчлийн эсрэг хувь хүмүүс шүүхэд хандах боломжгүй гэсэн үг юм. Уламжлалт байдлаар шүүхэд хандах боломжгүй гэж ихэнхдээ тооцогдож ирсэн эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн хувьд ийм явдал тулгарч байсан. Гэхдээ шүүх эдгээр эрхийн дэвшингүй ойлголтыг үнэлэх арга замыг улам бүр олсоор байна.¹²⁷ Тухайлбал, Өмнөд Африкийн Үндсэн хуулийн шүүх Төр дэвшилтэт үйл ажиллагаатай байх үүргээ биелүүлж буй эсэхийг үнэлэхдээ Засгийн газрын авч хэрэгжүүлсэн арга хэмжээ *зохих ёсны* байгаа эсэхийг харгалзана.¹²⁸ Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийг шүүхээр улам бүр баталгаажуулж буй сүүлийн үеийн хандлагын дагуу, Украин, Литвад шинээр нэвтрүүлсэн хувь хүний гомдол гаргах механизм нь хувь хүнд үндсэн хуульд заасан бүх эрх, түүний дотор нийгэм, эдийн засгийн эрхийн хувьд үндсэн хуулийн хяналтыг үүсгэх боломжийг олгож байна.

111. Хамгаалагдсан эрхийг заавал үндсэн хуульд тусгах¹²⁹, эсхүл шүүхээр баталгаажуулахаар зохицуулагдсан байх заавал шаардлагагүй ч эдгээр нь хууль зүйн ухааны бүтээлч ажиллагааны үр дүн байж болно. Аливаа заалтын үндсэн ач холбогдлыг хууль зүйн ухаанаар дамжуулан “танин нээх” боломжтой. Үүнд Францын Үндсэн хуулийн зөвлөлийн арга барилыг онцгойлон дурдуштай. Тус зөвлөл 1789 оны Хүний болон Иргэний эрхийн тунхаглал, 1946 оны Үндсэн хуулийн оршил зэрэг өмнө нь тунхаглалын төдий байсан бичвэрүүдэд үндсэн хуулийн үнэ цэнийг тусгах байдлаар хамгаалагдсан эрхийн хүрээг өргөжүүлсэн.

112. Олон улсын хүний эрхийн гэрээ хэлэлцээр¹³⁰, ялангуяа Европын Зөвлөлийн гишүүн улсын хувьд Европын хүний эрхийн конвенц нь энэхүү тайланд багтсан

¹²⁷ International Commission of Jurists (ICJ), *Courts and the Legal Enforcement of Economic, Social and Cultural Rights. Comparative Experiences of Justiciability*, 2008, Human Rights and Rule of Law Series No. 2, available at: <https://www.refworld.org/docid/4a7840562.html>; Langford, M. (ed.), *Social Rights Jurisprudence: Emerging Trends in International and Comparative Law*, Cambridge University Press, 2008.

¹²⁸ Constitutional Court of South Africa, *Mazibuko and Others v City of Johannesburg and Others*, CCT 39/09, 08 October 2009, ZACC 28, in CODICES.

¹²⁹ Хэд хэдэн улсад хүний эрхийн жагсаалт нь хаалттай бус, харин нээлттэй байдаг. Тухайлбал, ОХУ-ын Үндсэн хуулийн 55 дугаар зүйлд зааснаар Үндсэн хуульд заасан үндсэн эрх, эрх чөлөөний жагсаалтыг бусад нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн хүний болон иргэний эрх, эрх чөлөөг үгүйсгэсэн гэж тайлбарлаж болохгүй.

¹³⁰ Португалийн Үндсэн хуулийн 16(2)-т: "Үндсэн хууль болон үндсэн эрхийн талаарх хууль тогтоомжийн заалтыг Хүний эрхийн түгээмэл тунхаглалын дагуу тайлбарлана" гэж заасан. Тиймээс үндсэн эрхтэй холбоотой асуудлыг тайлбарлах стандартыг Европын хүний эрхийн конвенц бус Хүний эрхийн түгээмэл тунхаглалаар тогтооно. Харин ялгаатай нь Хүний эрхийн

улсуудад өөр өөр эрх зүйн статустай байна. Тухайлбал, Австрид Европын хүний эрхийн конвенц үндсэн хуулийн статустай. Сан Мариногийн хувьд ч мөн адил. Франц, Итали,¹³¹ Лихтенштайн, Хойд Македон¹³², Словени зэрэг улсад Европын конвенц нь үндсэн хуулийн дараа орох ч хуулийн дээгүүр хэрэглэгдэх зэрэглэлтэй. ХБНГУ-д Европын конвенц болон түүний протоколууд нь Холбооны улсын хуулийн (*Gesetzesrang*) статустай байдаг. Гэхдээ Европын конвенц болон Европын хүний эрхийн шүүхийн жишгийн эрх зүй нь үндсэн хуулиар олгогдсон эрх, зарчмуудын агуулгыг тодорхойлох бөгөөд тэдгээрийг даган биелүүлэх нь хууль дээдлэх ёсны нэг хэсэг гэж үздэг.¹³³

113. Үүний эсрэгээр, Нидерландад үндсэн хуульд нийцсэн эсэхийг хянах боломжгүй парламентын актуудыг (бусад хууль тогтоомжийн актуудаас ялгаатай) олон улсын гэрээ, түүний дотор Европын хүний эрхийн конвенцын хүрээнд хянаж болно. Тиймээс олон улсын хүний эрхийн гэрээ хэлэлцээрийг эш татах нь хувь хүний хувьд үндсэн эрхэд нөлөөлөх хууль тогтоомжийг хянуулах цорын ганц арга зам юм.

114. Латин Америкийн ихэнх үндсэн хуулиуд олон улсын хууль тогтоомж, хүний эрхийн тухай гэрээ хэлэлцээр, тухайлбал Америкийн хүний эрхийн конвенцод нээлттэй ба шүүх нь заримдаа олон улсын гэрээг үндсэн хуулиасаа ч дээгүүр байна гэж үзэхэд хүрдэг (жишээлбэл, Коломбо¹³⁴). Босни Герцеговинад Европын хүний эрхийн конвенц нь “бүх хуулиас илүү давамгайлах”¹³⁵ бөгөөд энэ нь Үндсэн

түгээмэл тунхаглал нь олон улсын гэрээ биш юм. Португалийн хувьд онол болон эрх зүйн философийн аль аль нь үндсэн эрхийг олон улсын хүний эрхийн олон төрлийн баримт бичгийн дагуу тайлбарлах ёстой гэж ойлгодог бөгөөд сүүлийн хэсэгт зааснаар дүрмүүдэд давуу эрх олгож үндсэн эрхийг дээд зэргээр хамгаалах боломжийг бүрдүүлж байна.

¹³¹ nos. 348/2007 and 349/2007 of the Italian Constitutional Court, after the 2001 amendment to Art. 117 of the Italian Constitution.

¹³² Македон улсын Үндсэн хуулийн 118 дугаар зүйлд: “Үндсэн хуульд заасны дагуу соёрхон баталсан олон улсын гэрээ нь дотоодын эрх зүйн дэг журмын нэг хэсэг бөгөөд хуулиар өөрчлөх боломжгүй” гэж заасан байдаг. Spirovski I, “Constitutional Validity of Human Rights Treaties in the Republic of Macedonia: The Norms and the Courts”, World Conference on Constitutional Justice in Cape Town, 2009.

¹³³ BVerfGE 111, 307, 14 October 2004, 2 BvR 1481/01.

¹³⁴ Колумбын Үндсэн хуулийн 93 дугаар зүйлд: “Онц байдлын үед хүний эрхийг хүлээн зөвшөөрч, хязгаарлахыг хориглосон Конгрессын соёрхон баталсан олон улсын гэрээ, конвенцууд дотоодын дэг журмаас илүү хүчин чадалтай байна. Энэхүү дүрэмд тусгагдсан эрх, үүргийг Колумбийн соёрхон баталсан хүний эрхийн тухай олон улсын гэрээний дагуу тайлбарлана.”

¹³⁵ Үндсэн хуулийн 2.2.

Венецийн комисс

хуулиас дээгүүр байна гэсэн утгатай.¹³⁶ Одоогоор Боснийн Үндсэн хуулийн шүүхээс энэ асуудлын талаар эцсийн шийдвэр гаргаагүй байна.¹³⁷

115. Зарим улсуудад (жишээлбэл, Бельги, Бразил, Герман, Унгар,¹³⁸ Лихтенштайн, Хойд Македон, Перу, Польш, Словени, Өмнөд Африк) үндсэн хуулийн шүүх хувь хүний хүсэлтийн дагуу эс үйлдлээс (*omission*) үүссэн зөрчлийг хөндөж¹³⁹ эсхүл хуулийн хийдлийг үндсэн хуулийн тайлбараар нөхөж болно.¹⁴⁰

В. Процедурин баталгаа

116. Хувь хүн үндсэн хуулийн шүүхэд үр дүнтэй хандах, тэдний материаллаг эрхийг баталгаажуулах явдлыг хангахын тулд үндсэн хуулийн шүүхийн тухай олон хуульд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зарим баталгааг тусгадаг. Хамгийн түгээмэл нь мэтгэлцэх, шүүхийн нээлттэй ажиллагаа, аман процессын ажиллагаа юм.

1. Мэтгэлцэх систем

117. Үндсэн хуулийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь мэтгэлцээний эсхүл инквизицийн хэлбэртэй байж болно. Үндсэн хуулийн шүүхийн тухай олон хуульд шүүхийн өмнө хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа мэтгэлцээний журмаар явагдана гэж заасан байдаг (жишээлбэл, Андорра, Австри, Азербайжан, Чили, Чех, Франц, Итали,¹⁴¹ Гүрж, Литва, Люксембург, Польш, Орос, Сан Марино, Өмнөд Африк, Украин, АНУ).

¹³⁶ Marko, J., "Five Years of Constitutional Jurisprudence in Bosnia and Herzegovina: A First Balance", *European Diversity and Autonomy Papers*, Vol. 7/2004, 2004, p.11, available at:http://www.eurac.edu/documents/edap/2004_edap07.pdf.

¹³⁷ Venice Commission, CDL-AD(2008)027, *Amicus curiae* brief in the cases of ECtHR, Sejdić and Finci v. Bosnia and Herzegovina (Applications no. 27996/06 and 34836/06).

¹³⁸ 2011 оны Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн 46 дугаар хэсгийг үзнэ үү: "Үндсэн хуулийн шүүх бүрэн эрхийнхээ хүрээнд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хууль санаачлагчийн эс үйлдэл нь үндсэн хууль зөрчсөн гэж үзвэл уг эс үйлдлийг үйлдсэн байгууллагад хугацаа тогтоож үүргээ гүйцэтгэхийг даалгана."

¹³⁹ Үндсэн хуулийн шүүх нь парламент хууль тогтоомжийг хэр хэмжээгээр хэрэгжүүлээгүйг хянадаг тул парламенттай зөрчилдөхөд хүргэж болзошгүй юм. Тиймээс, Португалийн хувьд үндсэн хуулийн шүүх эс үйлдэлтэй холбоотой асуудлаар абстракт хяналт хийх эрхтэй байсан ч эс үйлдэлтэй холбоотой хувь хүний гомдлыг шийдвэрлэдэггүй (Португалийн Үндсэн хуулийн 283-р зүйлийг үзнэ үү). *General Report of the XIVth Conference of European Constitutional Courts*, available at: <https://www.venice.coe.int/files/Bulletin/SpecBull-legislativeomission-e.pdf>.

¹⁴⁰ Үндсэн хуулийн шүүх нь хууль тогтоох байгууллагын үндсэн хууль зөрчсөн эс үйлдэлтэй холбоотой асуудлыг шийдэж, тайлбар хийх замаар хийдлийг засах боломж Лихтенштайн зэрэг улсад байдаг.

¹⁴¹ Италийн Үндсэн хуулийн шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд явцад анхны оролдогч талууд Үндсэн хуулийн шүүхийн ажиллагаанд оролдож болно. Төрийг хууль хамгаалах үүрэг бүхий ерөнхий өмгөөлөгч төлөөлнө.

118. Үндсэн хуулийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд мэтгэлцэх арга ашиглахын давуу тал нь шүүх өөр өөр үзэл бодлыг сонсож, эсрэг талын үндэслэлийг харгалзан үзэх боломжтой болдог. Гэхдээ үндсэн хуулийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь энэхүү давуу талаа гаргах хэмжээнд хангалттай мэтгэлцээн байнга хийдэггүй гэдгийг тэмдэглэх нь зүйтэй. Венецийн комиссын ажигласнаар төрийн байгууллагууд улс төрийн шалтгаанаар батлагдсан актыг үндсэн хуульд нийцэж байгаа гэсэн байр суурийг хамгаалахад бодит ашиг сонирхолгүй байж болзошгүй тул тэр бүр тохиромжтой мэтгэлцэгч тал байж чаддаггүй. Иймээс зарим үндсэн хуулийн хяналтын тогтолцоонд маргаантай заалтыг үндсэн хуульд нийцсэн, эсхүл нийцээгүй гэх үндэслэлийг тогтооход үндсэн хуулийн шүүхэд инквизицийн аргыг хэрэглэдэг.¹⁴² Гэсэн ч инквизицийн ажиллагааны явцад ч маргааны анхны талууд, түүнчлэн ашиг сонирхлын бүлгийн төлөөлөгчид, шинжээчид, гүйцэтгэх болон хууль тогтоох байгууллагын төлөөлөгчдөд эсрэг байр сууриа илэрхийлэх боломжийг олгож болно. Өөрөөр хэлбэл үнэн мөнийг тогтоохын тулд талуудын гаргасан тайлбараас гадна үндсэн хуулийн шүүх өөрийн санаачилгаар хянаж, шалгах ажиллагаа явуулж болно.¹⁴³

119. Өргөдөл гаргагч¹⁴⁴ буюу инквизицийн ажиллагааг санаачлагчид¹⁴⁵ үндсэн хуулийн шүүхэд тайлбар хийх боломж олгох нь чухал гэж Венецийн комисс үзэж байна. Герман,¹⁴⁶ Испанийн хуульд үндсэн хуулийн гомдол шүүхийн шийдвэрийн эсрэг чиглэсэн байвал тухайн шийдвэр гарсан талд тайлбар хийх боломж болгох ёстой гэсэн зохицуулалтыг Венецийн комисс дэмжиж байна.¹⁴⁷ Харин шүүхийн шийдвэрт шүүхийн байр суурь тусгагдсан байдаг тул хэрэв шийдвэрийг нь хянаж байгаа бол шүүхийн тайлбарыг сонсох шаардлагагүй. Гэхдээ шүүхийг урьдчилсан шатны ажиллагааны талуудтай заримдаа адилтгадаг. (жишээ нь, Австри, Польш, Словак, Словени).

¹⁴² Venice Commission, CDL-AD(2014)017, Opinion on the Draft Constitutional Law on the Constitutional Court, of Tajikistan, para. 35.

¹⁴³ Venice Commission, CDL-AD(2002)005, Opinion on the draft Law on the Constitutional Court of Azerbaijan.

¹⁴⁴ Venice Commission, CDL(1997)018rev, Opinion on the Law on the Constitutional Court of Ukraine, para. 4.

¹⁴⁵ Venice Commission, CDL-STD(1993)002, "Models of constitutional jurisdiction", Science and Technique of Democracy, no. 2, p. 14.

¹⁴⁶ Холбооны Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн 94(3) хэсэгт: "Үндсэн хууль зөрчсөн тухай гомдол нь шүүхийн шийдвэрийн эсрэг чиглэгдсэн бол Холбооны Үндсэн хуулийн шүүх нь шийдвэр өөрийнх нь талд гарсан оролцогчид тайлбар хийх боломж олгоно."

¹⁴⁷ Venice Commission, CDL-AD(2008)030, Opinion on the Draft Law on the Constitutional Court of the Republic of Montenegro, para. 42. Moreover, in Albania, Andorra, Austria, Belarus, Belgium, Cyprus, Czech Republic, Germany, Italy, Latvia, Romania and North Macedonia, the parties in the ordinary proceeding can become parties in the review proceeding.

120. Мэтгэлцэх ажиллагааг заавал аман байдлаар хийх албагүй. Үндсэн хуулийн гомдлыг хянан шийдвэрлэх ажиллагаа ихэвчлэн бичгээр явагддаг бөгөөд тал тус бүр тайлбараа бичгээр гаргадаг.¹⁴⁸

2. Нээлттэй байх зарчим

121. Нийтийн болон талуудын хууль ёсны ашиг сонирхол нь нээлттэй байх зарчмаас илүү бол үндсэн хуулийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг ихэвчлэн нээлттэй хийдэг (жишээлбэл, Албани, Армени, Австри, Азербайжан, Беларусь, Бельги, Босни-Герцеговина, Чили, Хорват, Кипр, Чех, Дани, Франц, Гүрж, Герман, Унгар, Израил, Итали, Латви, Лихтенштайн, Литва, Косово, Хойд Македон, Бүгд Найрамдах Молдова, Польш, Румын, Орос, Сан-Марино, Серб, Словак, Словени, Өмнөд Африк, Швейцар, Турк).

122. Нээлттэй байх шаардлага нь шүүх байгууллага дур зоргоороо авирлахаас хувь хүнийг хамгаалахын тулд олон нийтийн хяналтыг бий болгохыг зорьж буй хэрэг юм. Хүний эрхийг хамгаалах байр суурины үүднээс **Үндсэн хуулийн шүүхийн өмнө аливаа аман процессын ажиллагаа нээлттэй байх ёстой бөгөөд зөвхөн цөөн тооны тодорхой хэрэгт л хязгаарлалттай байна.**

3. Аман процессын ажиллагаа

123. Энэхүү тайланд хамрагдсан улсуудад хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг бүхэлд нь бичгээр, эсхүл хэсэгчлэн бичгээр болон аман хэлбэрээр явуулдаг. Жишээлбэл, Португалд зөвхөн бичгээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулдаг.¹⁴⁹ Олон улс оронд үндсэн хуулийн шүүх хэсэгчлэн аман процессын ажиллагаа явуулах эсэхийг шийдэж болдог. Тухайлбал, Өмнөд Африкт Үндсэн хуулийн шүүх зөвхөн талуудын тангараг өргөсөн мэдүүлэг эсхүл зөвхөн бичгээр гаргасан тайлбарт үндэслэн өргөдлийг шийдвэрлэж болох бөгөөд нэмэлт аман тайлбар шаардлагатай бол зааварчилгааг өгнө. Практикт үндсэн хуулийн шүүх аман процессын ажиллагаанаас татгалздаг.

124. Нөгөөтээгүүр зарим улсад хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг бичгээр болон аман хэлбэрээр явуулдаг (жишээ нь, Албани, Австри, Азербайжан, Франц, Израил, Итали, Латви, Лихтенштайн, Нидерланд, Хойд Македон, Словени, Өмнөд Африк, Украин, АНУ). Үндсэн хуулийн төвлөрсөн бус хяналттай улсад хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ердийн журам үйлчилдэг тул ихэвчлэн аман хэлбэрээр процессын ажиллагааг явуулдаг (жишээ нь, Дани, АНУ) Бүгд Найрамдах Чех Улс,

¹⁴⁸ Venice Commission, CDL-AD(2004)035, Opinion on the Draft Federal Constitutional Law “On Modifications and Amendments to the Federal Constitutional Law on the Constitutional Court of the Russian Federation”, para. 10.

¹⁴⁹ Португалид аливаа байгууллагыг фашист үзэл суртлыг тайлбарлаж байна гэж Үндсэн хуулийн шүүхээс тогтоохыг хүссэн үед энэ дүрэм үйлчлэхгүй. Хэрэв тухайн байгууллага татан буугдсан бол шүүх хуралдаан явуулах ёстой.

Герман,¹⁵⁰ Унгар, Словени,¹⁵¹ Швед, Швейцарт үндсэн хуулийн шүүхийн өмнө хянан шийдвэрлэх ажиллагааг аман хэлбэрээр явуулж болдог ч ихэнхдээ бичгээр явуулдаг.

125. Аман хуралдааны давуу тал нь талуудыг шууд оролцуулж, шүүгчтэй шууд харилцах, үзэл бодлоо илүү шууд илэрхийлэх боломжтой болдог явдал юм. Түүгээр ч барахгүй, бичгэн ажиллагаанд мөрддөг хэлбэрийн хатуу дүрмийг дагаж мөрдөх шаардлагагүйгээр хүн өөрийн байр сууриа амаар илэрхийлэх нь заримдаа илүү хялбар байдаг. Үүний үр дүнд шүүгчид бодит байдал, талууд болон тэдний хууль зүйн зөрүүтэй саналын талаарх ойлголтыг тэр дор нь илүү авах тул шийдвэр гаргах чанарыг сайжруулж чадна. Аман хуралдаан нь мөн ил тод байх ардчиллын үндсэн үнэт зүйлийг илэрхийлдэг. Энэ нь олон нийтийн хяналтаар дамжуулан шүүгчдэд ардчилсан хяналт тавих нэг хэлбэр болдог. Ийнхүү аман хуралдаан хийснээр шүүхийг хараат бус, бие даасан байна гэсэн иргэдийн итгэлийг бэхжүүлнэ.¹⁵² Нөгөөтээгүүр, хэрэг хянан шийдвэрлэх аман ажиллагааны явцад талуудад өөрсдийн байр сууриа үр дүнтэй илэрхийлэх боломж олгох нь чухал тул маш их хугацаа зардаг.

126. Хэрэв хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үр дүн (хэрэг хянан шийдвэрлэх хугацаа, зардал) зэрэг нийтийн эсхүл талуудын ашиг сонирхлыг хамгаалах шаардлагатай бол үндсэн хуулийн шүүх хэрэг хянан шийдвэрлэх аман процессын ажиллагааг түдгэлзүүлэх буюу хязгаарлаж болохыг өргөнөөр хүлээн зөвшөөрч байгааг Венецийн комисс тэмдэглэж байна.¹⁵³ Төвлөрсөн хяналтын тогтолцоотой улсад үндсэн хуулийн шүүх нь хувь хүний гомдлоор шүүхийг хэт ачаалалд оруулахаас зайлсхийх үүднээс аман хуралдаан явуулах эсэхээ шийдэх боломжтой байх ёстой.¹⁵⁴

¹⁵⁰ Jaeger, R. and Broß, S., “Die Beziehungen zwischen den Verfassungsgerichtshöfen und den übrigen einzelstaatlichen Rechtsprechungsorganen, einschließlich der diesbezüglichen Interferenz des Handelns der europäischen Rechtsprechungsorgane”, Report for the XIIth Conference of European Constitutional Courts, p. 22

¹⁵¹ Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн 57 дугаар зүйлд “Үндсэн хуулийн гомдлыг хүлээн авсан тохиолдолд ерөнхий журмын дагуу Үндсэн хуулийн шүүх хаалттай хуралдаанаар хянан хэлэлцэнэ, эсхүл нийтэд нээлттэй хуралдаан явуулж болно” гэж заасан байдаг.

¹⁵² Venice Commission, CDL-AD(2004)035, Opinion on the Draft Federal Constitutional Law ‘on modifications and amendments to the Federal Constitutional Law on the Constitutional Court of the Russian Federation’, para. 4.

¹⁵³ Ibidem, para. 10.

¹⁵⁴ Venice Commission, CDL-AD(2008)029, Opinion on the Draft Laws amending and supplementing (1) the Law on Constitutional Proceedings and (2) the Law on the Constitutional Court of Kyrgyzstan, para. 44; see also Venice Commission, CDL-AD(2014)017, Opinion on the Draft Constitutional Law on the Constitutional Court of Tajikistan, para. 36.

С. Хяналтын хамрах хүрээ

127. Энэ судалгаанд хамрагдаж буй ихэнх системд үндсэн хуулийн шүүх хэрхэн хяналт явуулахаа тодорхой хэмжээгээр өөрийн үзэмжээр шийдэх боломжтой. Үндсэн хуулийн шүүх өргөдөл (бүхэлд нь буюу хэсэгчлэн) хүлээн авснаар хяналтын хамрах хүрээг хумих боломжгүй. Үндсэн хуулийн шүүх аливаа хэм хэмжээ үндсэн хуульд нийцэж байгаа эсэхийг шалгахын тулд эхлээд түүний агуулгыг тогтоох ёстой. Үүнийг тогтоосны дараа хүсэлт дэх тодорхой бичсэн нөхцөлөөс гадна хяналтын хамрах хүрээг тэлэх эсхүл үндсэн хуулийн гомдолд дурдсанаас гадна хянах стандарт болгон хэрэглэсэн хэм хэмжээний хүрээг өргөтгөж болно. Хувь хүний гомдлууд нь үндсэн хуулийн дэг журмын дутагдлыг ерөнхийд нь олж мэдэх чухал хэрэгсэл болдог. Иймд Үндсэн хуулийн шүүхэд хяналтын хамрах хүрээг өргөтгөх боломжийг олгох нь үндсэн хуулийн хамгаалалтыг хувь хүний хэргээр хязгаарлахгүй байх боломжийг олгоно.¹⁵⁵

1. Хянаж буй хэм хэмжээг тайлбарлах нь

128. Үндсэн хуулийн шүүх тайлбарлаж буй хэм хэмжээгээ тайлбарлах олон төрлийн арга хэрэглэж болно. Хамгийн түгээмэл арга нь үндсэн хуульд нийцсэн гэх таамаглал юм ("*reserve d'interprétation*" эсхүл "*verfassungskonforme Auslegung*" гэж бас нэрлэдэг)¹⁵⁶. Энэ аргын дагуу үндсэн хуулийн шүүх норматив актын зүйл заалтыг үндсэн хуульд нийцээгүй гэх үндэслэлтэй тайлбар олж чадаагүй бол уг актыг үндсэн хуульд нийцсэн гэж үзэж, үндсэн хуульд нийсэн гэсэн тайлбар гаргана. Ингэснээр тухайн хэм хэмжээ үндсэн хуультай илт нийцээгүй л биш бол уг хэм хэмжээг хүчингүй болгохоос шүүх зайлсхийх замаар шүүгчид өөрийн хяналтыг хязгаарлаж байна гэж ойлгогддог. Үүний эсрэгээр Италийн Үндсэн хуулийн шүүх өөр хандлагатай ба "*diritto vivente*" (амьд хууль) гэсэн ойлголтыг

¹⁵⁵ Хэрэв тодорхой хэргийг хянан шалгах тохиолдолд Европын улсуудын үндсэн хуулийн шүүхүүд хуулийг шалгахдаа абстракт хяналтын аргыг баримталдаг гэж Войцех Садурски үзжээ. Жишээлбэл, АНУ-ын Дээд шүүхээс ялгаатай нь Европын хяналтын аргууд нь эрх зүйн дэг журмыг цэгцлэх тухай Келсений санаан дээр суурилдаг. Тиймээс Садурскийн үзэж буйгаар, үндсэн хуулийн шүүхүүд хувь хүний тухайн хэргийг үндсээр нь шалгаж шийддэггүй байна. (Sadurski W. (ed.) *Constitutional Justice East and West: Democratic Legitimacy and Constitutional Courts in Post-Communist Europe in a Comparative Perspective*, Kluwer Law International, 2003, pp. 453 and Sadurski, W. (ed.) *Rights before Courts: A Study of Constitutional Courts in Postcommunist States of Central and Eastern Europe* (2nd ed.) Springer Netherlands, Dordrecht, 2014, pp. 470).

¹⁵⁶ Тухайлбал, Арменийн Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн 69(10) -д "Энэхүү зүйлд дурдсан өргөдөл гаргагчийн хэрэгт хэрэглэсэн эрх зүйн хэм хэмжээний зүйл заалт Үндсэн хуультай харшилсан бөгөөд хүчингүй болсон бол шинээр илэрсэн нөхцөл байдалд үндэслэн хуульд заасан журмаар тухайн өргөдөл гаргагчтай холбоотой гарсан шүүхийн эцсийн шийдвэрийг хянах бөгөөд уг зүйл заалтыг Үндсэн хуульд нийцсэн гэдгийг хүлээн зөвшөөрсөн тайлбар гаргах тохиолдолд Үндсэн хуулийн шүүх тухайн өргөдөл гаргагчийн хувьд өөр тайлбарт уг зүйл заалтыг хэрэглэсэн гэж давхар үзнэ. 69(11) дэх хэсэгт зааснаар, энэ зүйлийн 10 дахь хэсэг нь Үндсэн хуулийн шүүхэд гомдлоо бүртгүүлсэн өдрийн байдлаар тухайн ижил асуудлаар Үндсэн хуулийн шүүхэд давж заалдах эрхтэй ч ийнхүү давж заалдаагүй хүмүүст ч нэг адил үйлчилнэ.

бий болгосон. Үндсэн хуулийн шүүгч маргаантай хуулийн заалтыг ердийн шүүхийн “ихэвчлэн” тайлбарладаг аргаар тайлбарлаж, үндсэн хуульд нийцүүлэн тайлбарлах боломжтой байсан ч нийтлэг тайлбарт үндэслэн, үндсэн хууль зөрчсөн гэж шийдвэрлэх тохиолдол гардаг.¹⁵⁷

129. Урьдчилсан хүсэлтийн хувьд үндсэн хуулийн шүүх хүсэлт гаргасан шүүхийн тайлбарыг хойшлуулж эсхүл өөрийн тайлбараа гаргадаг. Үндсэн хуулийн шүүхийн урьдчилсан хүсэлтийн дагуу хянах ажиллагаа нь холбогдох хүсэлт гаргасан шүүхийн уг хэлэлцэж буй журмын тайлбараар хязгаарлагдана гэсэн тууштай байр суурьтай Португалийг эс тооцвол энэ тайланд авч үзсэн үндсэн хуулийн шүүхүүдийн аль нь ч зөвхөн хүсэлт гаргасан шүүхийн ашигласан тайлбараар хязгаарлагддаггүй. Австри, Бельги, Испанийн үндсэн хуулийн шүүх зарчмын хувьд үндсэн хуульд нийцсэн өөр тайлбар байхгүй бол уг хүсэлтэд тусгагдсан тайлбарыг хэрэглэнэ. ХБНГУ-ын Холбооны Үндсэн хуулийн шүүх нь, хэрэв үндэслэлгүйгээс гадна үндсэн эрхийн агуулга, хүрээг үндсээрээ алдаатай байр суурь дээр үндэслэсэн шийдвэрт илт алдаа байхгүй л бол ердийн шүүхийн шийдвэрийг дагах үүрэгтэй.¹⁵⁸ Тэрчлэн Германы Үндсэн хуулийн шүүх холбооны болон мужийн дээд шүүхээс холбогдох хэм хэмжээг хэрхэн тайлбарлаж байгаа болон тайлбарын шалтгааны талаар мэдээлэл ирүүлэхийг хүсэх эрхтэй.¹⁵⁹

2. Хянаж буй хэм хэмжээний хамрах хүрээг өргөтгөх нь

130. Үндсэн хуулийн шүүх норматив актыг хянуулах тухай хүсэлттэй холбогдуулан маргаан бүхий заалт төдийгүй, тодорхой нөхцөлд хууль эсхүл актыг бүхэлд нь үндсэн хуульд нийцсэн эсэх, мөн маргаан бүхий норматив акттай холбоотой бусад холбогдох актыг үндсэн хуульд нийцсэн эсэхийг хянаж болно (жишээлбэл, Хорват, Эстони,¹⁶⁰ Герман,¹⁶¹ Унгар, Итали,¹⁶² Лихтенштайн,

¹⁵⁷ Тиймээс, үндсэн хуультай байнга нийцэхгүй байна гэж тайлбарлагдаж ирсэн хуулийг хүчингүй болгож, парламент үндсэн хуулийн дагуу тайлбарлагдах шинэ хууль батлах үүрэгтэй.

¹⁵⁸ BVerfG, 1 BvR 1804/03 of 07 December 2004, para. 50.

¹⁵⁹ Холбооны Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн 82 дугаар зүйл. 82(4) дэх хэсгийн нэг дэх өгүүлбэрийн дагуу энэ нь зөвхөн холбооны дээд шүүхээс гадна *Lander*-ын дээд шүүхүүдэд хамаарна.

¹⁶⁰ Жишээ нь Дээд шүүхийн шийдвэр. №3-4-1-7-08, дараах цахим хуудаснаас:

<https://www.riigikohus.ee/en/constitutional-judgment-3-4-1-7-08>

¹⁶¹ Шүүхүүнийг Холбооны Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 2 дахь өгүүлбэрт үндэслэн хууль тогтоомжийг абстрактаар хянахад хэрэглэж болно.

¹⁶² Италид Үндсэн хуулийн шүүх "тайлбарласан шийдвэр" гэж нэрлэсэн өргөн хүрээний шийдвэр гаргадаг бөгөөд эрх зүйн хэм хэмжээ, актыг үндсэн хуультай нийцээгүй гэж маргасан нэхэмжлэлийг доод шатны шүүгчийн баталсан хуулийн буруу тайлбарт үндэслэн татгалзаж байсан. Тэгэхээр үндсэн хууль эрх зүйн зүйл заалтыг өөрөөр тайлбарласан нь үндсэн хуульд нийцсэн гэж үзжээ (үүнийг "*sentenze interpretative di rigetto*" гэдэг). Тайлбарласан шийдвэрийг зөвхөн доод шатны шүүгчийн хувьд заавал биелүүлэх ёстой бөгөөд бусад шүүх, шүүгчдэд хамаарахгүй. Үндсэн хуулийн шүүхээс тогтоосон тайлбарыг дагахыг хүсэхгүй байгаа шүүгчид үндсэн хуультай нийцээгүй гэж Үндсэн хуулийн шүүхээс

Венецийн комисс

Литва,¹⁶³ Хойд Македон, Бүгд Найрамдах Молдова, Румын, Серби, Словени,¹⁶⁴ Өмнөд Африк, Испани болон Украин). Туркт Үндсэн хуулийн шүүх зөвхөн маргаантай хэм хэмжээг хүчингүй болгосноор өөр хэм хэмжээг эсхүл түүний хэсгийг утгагүй эсхүл хэрэглэх боломжгүй болсон онцгой тохиолдолд л хянаж буй хэм хэмжээний хүрээг өргөжүүлдэг.¹⁶⁵

131. Үндсэн хуулийн шүүх хянаж буй хэм хэмжээний хүрээг өргөтгөснөөр үндсэн хуулийн хяналтын хоёр чиг үүргийг нэгтгэдэг: Үндсэн хуулийн шүүх нь хувь хүний эрхийг хамгаалахаас гадна уг хувь хүний гомдолд үндэслэн үндсэн хуультай нийцээгүй заалтыг хасах замаар үндсэн хуулийн дэг журмыг тодорхой болгоход чиглэсэн илүү ерөнхий хяналт явуулна. Тухайлбал, ОХУ-ын Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн 87 дугаар зүйлд зааснаар тодорхой зүйл заалтыг Үндсэн хуультай нийцээгүй гэж үзвэл түүнд үндэслэсэн эсхүл уг зүйл заалтыг агуулсан, түүнийг дахин хэрэглэсэн бусад бүх актуудыг үндсэн хуульд нийцээгүй гэдгээр бүгдийг нь хүчингүй болгоход хүргэнэ.¹⁶⁶

3. Гомдлын хамрах хүрээг өргөтгөх

132. Үндсэн хуулийн шүүх шийдвэр гаргахдаа маргаантай заалтыг тогтоох ёстой. Шууд хандах хувь хүмүүс ихэвчлэн өргөдөл гаргах нарийн үндэслэлээ

аль хэдийн тогтоосон тайлбарыг хэрэглэхгүй байж болно. Шүүх тухайн хэм хэмжээг өөрөөр тайлбарласан тайлбараа Үндсэн хуулийн шүүхэд шинэ урьдчилсан хүсэлтэй гаргаж өгөх ёстой. Энэ тохиолдолд Үндсэн хуулийн шүүх доод шатны шүүгчийн санал болгосон шинэ тайлбарыг хүчин төгөлдөр, үндсэн хуульд нийцэж байгаа эсэхийг шийдэж, хэрэв тийм бол "*sentenze interpretative di accoglimento*" (Үндсэн хуульд нийцүүлж буй өөр тайлбарыг зөвшөөрч буй тайлбарласан шийдвэр) гаргах ёстой. Үндсэн хуулийн шүүх доод шатны шүүгчийн санал болгосон тайлбарыг хүлээж авахгүй татгалзах бол Үндсэн хуультай нийцсэн хууль тогтоомж хэрхэн гаргах (мөн үндсэн хуультай харшилж болзошгүй тайлбарыг гаргахгүй байх) талаар чиглэл, зөвлөгөөг хууль тогтоогчид өгөхийн тулд парламентад хандаж анхааруулга өгнө. Үндсэн хуулийн шүүх доод шатны шүүгчийн зөв бөгөөд тухайн хуулийн зүйл заалт үндсэн хууль зөрчсөн гэж үзвэл уг заалт хүчингүй болно. Үндсэн хуулийн шүүх уг хүчингүй болгож үүсгэсэн хийдлийг "бөглөх" (*sentenze additive*) буюу тодорхой тохиолдолд доод шатны шүүгч тухайлсан хэрэгт хэрэглэх ёстой ерөнхий зарчмыг гаргаж өгнө (*sentenze additive di principio*).

¹⁶³ Шүүх "Тухайн хуулийн зүйл заалтыг үндсэн хуультай нийцэж буй эсэхээр өргөдөл гаргагч маргаагүй байсан ч маргаантай хуулиар зохицуулагдсан нийгмийн харилцаагаар үндсэн хуультай зөрчилдсөн гэж Үндсэн хуулийн шүүх үзвэл үүнийг дурдах ёстой" гэж үзсэн. (2001 оны 11 дүгээр сарын 9, 2002 оны 1 дүгээр сарын 14, 2002 оны 6 дугаар сарын 19, 2007 оны 6 дугаар сарын 27, 2009 оны 3 дугаар сарын 3, 2009 оны 9 дүгээр сарын 2-ны өдрийн шийдвэрүүд.)

¹⁶⁴ Үндсэн хуулийн шүүхийн 59(2) дахь хэсэг.

¹⁶⁵ Үндсэн хуулийн шүүх байгуулах болон түүний дэгийн тухай хуулийн 43(4).

¹⁶⁶ ОХУ-ын Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн 87-р зүйлд: "Холбооны хууль, ОХУ-ын Ерөнхийлөгчийн акт, ОХУ-ын Засгийн газрын акт, хэлэлцээр эсхүл тэдгээрийн зүйл заалт ОХУ-ын Үндсэн хуульд харшилж байна гэж хүлээн зөвшөөрсөн нь үндсэн хуультай нийцээгүй гэж тооцсон зүйл заалтыг агуулсан, дахин хэрэглэсэн, бүхэлдээ эсхүл хэсэгчлэн үндсэн хуульд нийцээгүй гэж үзсэн акт, хэлэлцээрт үндэслэсэн бусад акт, хэлэлцээрийн зүйл заалтыг хүчингүй болгох үндэслэл болно.

заахад хүндрэлтэй. Ихэнх үндсэн хуулийн шүүхүүд эдгээр алдааг үл харгалзан олон өргөдөл хүлээн авдаг тул гомдолд дурдсанаас өөр үндсэн хуулийн үндэслэлээр шийдвэр гарган гомдлын хамрах хүрээг өргөтгөж болно (жишээлбэл, Албани, Австри, Болгар, Чех, Эстони¹⁶⁷, Португал, Словени, Испани).

133. Зөвхөн зарим улс л үндсэн хуулийн шүүхийн өргөдөл хянах хүрээг хүсэлтээр хязгаарладаг (жишээлбэл, Андорра,¹⁶⁸ Бельги,¹⁶⁹ Гүрж,¹⁷⁰ Люксембург, Монтенегро,¹⁷¹ Польш¹⁷², Швейцар¹⁷³). Энэ нь үндсэн хуулийн шүүх зөвхөн өргөдөлд дурдсан үндсэн хуулийн заалт, зарчмыг үндэслэн өргөдөлд дурдсан актыг хүчингүй болгоно гэсэн үг. Өргөдөлд ямар акт маргаантай байгаа үндэслэл эсхүл асуудалтай актыг тодорхой заагаагүй бол амжилттай шийдвэрлэх магадлал бага байх тул хүндрэл учруулж болзошгүй.

134. Өргөдлийн хүрээг өргөсгөснөөр шууд хандалтыг хялбаршуулж болно. Учир нь хувь хүмүүс өргөдөл гаргахдаа ямар үндэслэлээр гаргаж буйгаа заахад ихэнхдээ хүндрэлтэй байдаг. Өргөдөл гаргагч нь үндсэн хуулийн заалтыг яг таг нэрлэх үүрэг хүлээдэггүй. Үндсэн хуульд нийцээгүй хэм хэмжээг тухайн гомдлоос олж харах төдий байвал зохино. Энэхүү шаардлага нь энгийн хүмүүсийн гаргасан өргөдлөөс илүү хууль зүйн туслалцаа авч гаргасан гомдолд илүү чанга байж болно. **Үндсэн хуулийн шүүхэд гомдлын хүрээг өргөтгөх боломж олгох нь уг шүүхэд хэт ачаалал өгөлгүйгээр хувь хүний эрхийг илүү сайн хамгаалах боломжийг олгодог** гэж Венецийн комисс үзэж байна.

D. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг зогсоох

135. Эцсийн шийдвэр гарахаас өмнө хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг дараах гурван тохиолдолд зогсоож болно: i) өргөдлийг буцаасан бол; ii) маргаантай акт хүчин төгөлдөр байхаа больсон бол; эсхүл iii) шийдвэр гаргах хугацаа өнгөрсөн бол.

¹⁶⁷E.g., Constitutional Court judgment, 3-4-1-11-08, 2008.02.25, дараах цахим хуудаснаас харах боломжтой: <https://www.riigikohus.ee/en/constitutional-judgment-3-4-1-1-08>.

¹⁶⁸ Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн 7-р зүйл: “3. Хянан шийдвэрлэхээр хүлээн авсан хэрэг маргааныг тодорхойлсон шийдвэр талуудын нэхэмжлэлийн шаардлагад гаргасан тайлбараас өөр зүйлийг тусгаж болохгүй.”

¹⁶⁹ С.А. n° 12/86, 25.03.1986, 3.В.1.

¹⁷⁰ Үндсэн хуулийн шүүхийн тухай органик хуулийн 26-р зүйл: “Нэхэмжлэгч буюу өргөн мэдүүлэгч нь зөвхөн хуулийн тодорхой заалт эсхүл норматив актыг Үндсэн хууль зөрчсөн эсэхийг хэлэлцэхийг шаардсан тохиолдолд Үндсэн хуулийн шүүх нь хуулийг бүхэлд нь болон өөр норматив актыг үндсэн хуульд нийцэж байгаа эсэхийг хэлэлцэхгүй.”

¹⁷¹ Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн 75-р зүйл: Үндсэн хуулийн шүүх гомдолд дурдсан үндсэн хуулиар баталгаажсан хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн эсэх асуудлыг хянан шийдвэрлэнэ.

¹⁷² Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн 66-рр зүйлд: “Шүүх бүрэлдэхүүн шийдвэр гаргахдаа өргөдлийн хүрээ, гомдол, эрх зүйн асуудлаар хязгаарлагдана.”

¹⁷³ Холбооны Шүүхийн тухай хуулийн 107-р зүйл: “*Le Tribunal fédéral ne peut aller au-delà des conclusions des parties*”.

1. Өргөдлийг буцаасан тохиолдолд хяналтыг зогсоох

136. Хэрэв өргөдлийг буцаавал үндсэн хуулийн шүүх хэргийг үргэлжлүүлэх эрхтэй эсэх нь тухайн хэрэг норматив эсхүл нэг бүрчилсэн актын үндсэн хуульд нийцсэн эсэхийг хөндөж байгаагаас ихээхэн хамаарна. Нэг бүрчилсэн актын хувьд өргөдөл гаргагч өргөдлөө буцаах нь хэргийг зогсооход хангалттай. Гэхдээ Словакийн Үндсэн хуулийн шүүх иж бүрэн үндсэн хуулийн гомдлыг буцаан татахыг зөвшөөрөхөөс татгалзах эрхтэй. Португалид нэгэнт өргөдөл гаргасны дараа өргөдөл гаргагч түүнийг буцаах эрхгүй болно гэж үздэг.

137. Норматив актыг хянах тохиолдолд хэрэв өргөдлийг буцаасан бол үндсэн хуулийн шүүх хяналтын ажиллагааг заавал зогсоох шаардлагагүй. Энэ нь үндсэн хуулийн иж бүрэн гомдлын хувьд ч норматив актыг хянахад мөн адил. Үндсэн хуулийн шүүх өргөдөл гаргагч өргөдлөө татсан ч гэсэн нэг бүрчилсэн шийдвэр эсхүл актын үндэслэл болсон норматив актыг хянах ажиллагааг үүсгэх эрхтэй бол норматив актыг хянах ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах боломжтой байж болно. Зарим үндсэн хуулийн шүүхийн тухай хуульд хэрэв норматив актын хувьд өргөдөл буцаагдсан тохиолдолд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг зогсоохыг шаарддаг (жишээлбэл, Андорра, Австри,¹⁷⁴ Польш, Унгар, Орос, Серби, Швейцар, Украин).

138. **Хэрэв өргөдөл буцаагдсан ч агуулга нь нийтийн ашиг сонирхлын төлөө байвал шүүх хэргийг үргэлжлүүлэн хянах боломжтой байх ёстой** гэж Венецийн Комисс үзэж байна.¹⁷⁵ Хэдийгээр өргөдөл гаргагч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны нэг тал биш болсон ч ийнхүү хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг үргэлжлүүлэх чадвартай байх нь үндсэн хуулийн шүүхийн хараат бус байдал, үндсэн хуулийг сахиулах чиг үүргээ хэрэгжүүлж буйг илэрхийлнэ.

2. Маргаантай акт хүчин төгөлдөр бус болж зогсох

139. Хэлэлцэж буй акт хүчин төгөлдөр биш болсон үед үндсэн хуулийн шүүх хяналтын ажиллагааг үргэлжлүүлэх эсэх талаар нэгдсэн хандлага байхгүй. Зарим улсад шүүх хяналтын ажиллагааг нэн даруй зогсоодог (жишээлбэл, Андорра,

¹⁷⁴ Гэхдээ, Холбооны Үндсэн хуулийн хуулийн 139(2), 140(2) дахь хэсэгт заасны дагуу Үндсэн хуулийн шүүхээс өөр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явагдаж байхад өөрөө санаачилж эхлүүлсэн хянах ажиллагааг, хэдийгээр тухайн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны талуудын хүсэлт хангагдсан байлаа ч үргэлжлүүлнэ.

¹⁷⁵ Venice Commission, CDL-AD(2011)050, Opinion on draft amendments and additions to the law on the Constitutional Court of Serbia, paragraph 41; Venice Commission, CDL-AD(2014)017, Opinion on the Draft Constitutional Law on the Constitutional Court of Tajikistan, para. 54.

Австри, Чех,¹⁷⁶ Беларусь, Франц, Хойд Македон,¹⁷⁷ Португал, Словак,¹⁷⁸ Швейцар, Украин). Бусад улсад аливаа акт хүчингүй болсон тохиолдолд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг үргэлжлүүлэх эсэх шийдвэр бүхэлдээ шүүхийн мэдэлд байх (жишээ нь, Лихтенштэйн, Серби) буюу зөвхөн тодорхой нөхцөл байдлаар хязгаарлагдаж болно. Тухайлбал, Польш, ОХУ-д хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх шаардлагатай үед хяналтын ажиллагааг үргэлжлүүлэхийг зөвшөөрдөг. Литвад үндсэн хуулийн шүүх маргаантай хууль эсхүл бусад эрх зүйн акт хүчин төгөлдөр хэвээр байгаа эсэхээс үл хамааран аливаа хувь хүний гомдол, урьдчилсан хүсэлтийг хянан шийдвэрлэх үүрэгтэй.¹⁷⁹ Италид, хэрэв хянагдаж буй хууль хэлэлцэж буй хугацаанд өөрчлөгдөж, эсхүл өөр хуулиар солигдсон тохиолдолд уг хэргийг анх хянан шийдвэрлэж байсан ердийн шүүгчид буцаах бөгөөд солигдсон шинэ хуулийг үндсэн хуульд нийцсэн эсэх асуудлыг дахин гаргах эсэхийг шийднэ.

140. Урьдчилсан хүсэлт, хувь хүний гомдол эсхүл урьдчилсан хүсэлтийн хувьд хүний эрхийн зөрчил хэвээр байгаа тохиолдолд зөвхөн хяналтын ажиллагааг зогсоох нь хүний эрхийг хамгаалахад хангалтгүй гэж Венецийн Комисс үзэж байна.

3. Шийдвэр гаргах хугацаа

141. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа хэт удаашрахаас сэргийлэхийн тулд зарим улс шийдвэр гаргахдаа хугацаа тогтоосон байдаг. Тухайлбал, Бельгид үндсэн хуулийн шүүх хэргийг бүртгэснээс хойш зургаан сарын дотор шийдвэрлэх ёстой. Энэ хугацааг дээд тал нь нэг жил хүртэл сунгаж болно.¹⁸⁰ Гэхдээ “нарийн хугацааны дарааллаар хурал хийх, шийдвэр гаргах аливаа үүрэг хүлээлгэх нь Европын стандартад нийцэхгүй байх эрсдэлтэй. Үндсэн хуулийн шүүх

¹⁷⁶ Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн 67 дугаар зүйл.

¹⁷⁷ Хойд Македонийн Үндсэн хуулийн шүүхийн практикт хэлэлцэж буй акт хүчингүй болсон тохиолдолд хяналтыг дуусгавар болгодог. Харин Үндсэн хуулийн шүүхийн дэгийн 47 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-д Үндсэн хуулийн шүүх хэс хяналтыг үргэлжлүүлэх боломжтой гэж заасан байдаг. Үүнд: “Хэрэв хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хууль, бусад зохицуулалт, нийтлэг акт хүчин төгөлдөр бус болж, тэдгээрийн үндсэн хуульд нийцэж байгаа болон, хууль ёсны эсэхэд дүгнэлт хийх үндэслэлгүй бол Үндсэн хуулийн шүүх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг зогсооно” гэж заасан. (available at: http://ustavensud.mk/?page_id=5211&lang=en).

¹⁷⁸ Словакийн Үндсэн хуулийн шүүх өмнөх практикаасаа ялгаатайгаар эрх зүйн дэг журмын хүчин төгөлдөр хэсэг байгаа болсон норматив актыг ердийн шүүх хянуулах боломжийг анх удаа хүлээн зөвшөөрсөн ч тодорхой хэрэгт л үйлчилж байна. Италид Үндсэн хуулийн шүүх хэрэв маргаантай хууль *ratione temporis* хэвээр байвал дараагийн хуулиар хүчингүй болсон байсан ч тухайн маргаантай хуулийг хянаана.

¹⁷⁹ Хувь хүний гомдолтой холбоотой 2019 оны 11 сарын 25-ны өдрийн тогтоол, Урьдчилсан хүсэлттэй холбоотой Үндсэн хуулийн шүүхийн 2009 оны 03 сарын 27-ны өдрийн шийдвэр, шүүхийн үндэслэлийн 1 дэх хэсэг, 8 дахь заалт.

¹⁸⁰ Venice Commission, CDL-AD(2016)001, Opinion on Amendments to the Act of 25 June 2015 on the Constitutional Tribunal of Poland, para. 66.

Венецийн комисс

бүрэлдэхүүн зарим төрлийн хэрэг маргааныг бусад хэргээс эрт үргэлжлүүлж, хянаж, дуусгах боломж байх ёстой” гэж Венецийн Комисс үзэж байна.¹⁸¹

142. Шийдвэр гаргах хугацаа тогтоосон тохиолдолд үндсэн хуулийн шүүхэд хэргийг бүрэн шалгах хангалттай хугацаа олгох зорилгоор шийдвэр гаргах хугацаа хэт богино байж болохгүй. Мөн хүний эрхийг үндсэн хуулийн шүүхээр үр дүнтэйгээр хамгаалахын тулд хэт урт байж болохгүй. Үндсэн хуулийн шүүхийн үр дүнтэй ажиллагааны зүгээс хэргийн нарийн төвөгтэй байдал, түүнийг шийдвэрлэхэд шаардагдах хугацааг урьдчилан таамаглах боломжгүй. **Иймд үндсэн хуулийн шүүх зохих боломжит хугацаанд шийдвэр гаргах үүргээ биелүүлэхийн сацуу онцгой тохиолдолд дээрх хугацааг сунгах боломжтой байх ёстой.**¹⁸²

VII. ШИЙДВЭРҮҮД

143. Үндсэн хуулийн шүүхийн эцсийн шийдвэрийн үр нөлөө янз бүр. Үндсэн хуулийн шүүх эцсийн шийдвэр гаргахаас гадна төрөл бүрийн түр арга хэмжээ (*interim measures*) авах боломжтой. Шийдвэр нь *inter partes* эсхүл *erga omnes* (*ratione personae* нөлөө) гэдгээс хамаарч өөр өөр тооны хүмүүст нөлөөлж болох бөгөөд цаг хугацааны өөр өөр үед хүчин төгөлдөр үйлчлэх (*ratione temporis* нөлөө) эсхүл өөр өөр төрлийн асуудлыг (*ratione materiae* нөлөө) шийдэж болно. Шийдвэрийн нөлөөлөх хүрээ болон шийдвэрийг буцаан хэрэглэх боломж нь тухайн хувь хүнд тулгарсан гомдлыг үр дүнтэй арилгаж болох эсэхийг тодорхойлно. Зарчмын хувьд үндсэн хуулийн шүүхийн гаргасан үндсэн хуульд нийцсэн эсэх талаарх шийдвэр нь эцсийнх байна.

A. Түр арга хэмжээ

144. Ерөнхийдөө үндсэн хуулийн шүүх олон төрлийн түр арга хэмжээ авах шийдвэр гаргаж болно. Хувь хүнд цаашид нөхөж баршгүй хохирол учруулахаас зайлсхийхийн тулд шүүх маргаантай байгаа норматив акт эсхүл нэг бүрчилсэн актын үйлчлэлийг түдгэлзүүлж, эсхүл баталгаажуулах арга хэмжээ авч болно.

¹⁸¹ Ibidem, para. 65. See also Venice Commission, CDL-AD(2016)034, Opinion on the Draft Law on the Constitutional Court of Ukraine, para. 48.

¹⁸² Тухайлбал, Арменийн Үндсэн хуулийн шүүхийн тухай хуульд зааснаар Үндсэн хуулийн шүүх давж заалдах хүсэлтийг бүртгэснээс хойш 6 сараас дээшгүй хугацааны дотор хэргийг шийдэж, үндэслэлтэй шийдвэр гаргана. Үндсэн хуулийн шүүх хэргийг хянан шалгах хугацааг гурван сараас дээшгүй хугацаагаар сунгаж болно. Чилид шүүх бүрэлдэхүний гаргах бараг бүх шийдвэрт хугацааны хязгаарлалт байдаг. Хуулийн төсөл батлагдахаас өмнө тус төслийн зүйл заалттай холбоотойгоор Ерөнхийлөгч, аль нэг Танхим эсхүл танхимын гишүүдийн дөрөвний нэгтэй тэнцэх гишүүдээс гаргасан асуултыг 10 хоногийн дотор шийдвэрлэх ёстой. Энэ хугацааг хэргийг хүлээн авахаар шийдвэрлэсэн шийдвэр гарсан цагаас эхлэн тооцно. Хүндэтгэн үзэх шалтгаанаар дахин 10 хоног сунгах боломжтой. Бусад өргөдлийн хувьд Органик хуульд өөр өөр хугацааны хязгаарлалт заасан байдаг. Энэ бүгдэд шүүх 30 хоногийн дотор шийдвэр гаргах ёстой бөгөөд хүндэтгэн үзэх шалтгаанаар 15 хоногоор сунгаж болно.

Түүнчлэн, урьдчилсан хянан шийдвэрлэх ажиллагаа үүссэн бол ердийн ажиллагааг түдгэлзүүлж болно.

1. Баталгаажуулах болон түдгэлзүүлэх арга хэмжээ

145. Өргөдөл гаргагчид дахин хохирол учруулахгүйн тулд шүүх маргаан бүхий норматив эсхүл нэг бүрчилсэн актын хэрэгжилтийг түдгэлзүүлэх, эсхүл шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах арга хэмжээ (injunction) авах шийдвэр гаргаж болно. Үндсэн хуулийн шүүхийн процессын ажиллагаанд авдаг шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах арга хэмжээгээр ихэвчлэн төрийн байгууллагыг өргөдөл гаргагчид хохирол цаашид учруулахгүйн тулд эерэг нөлөөлөл бүхий арга хэмжээ авахыг даалгадаг (жишээлбэл, Герман, Мальта, Лихтенштайн, Өмнөд Африк, Швейцар).

146. Маргаантай норматив эсхүл нэг бүрчилсэн актын хэрэгжилтийг түдгэлзүүлэх нь хувь хүнд нөхөж баршгүй хохирол учруулахаас хамгаалах зарчмын хүрээг зайлшгүй өргөтгөж буй явдал юм. Олон улс орны үндсэн хуулийн шүүхэд түдгэлзүүлэх эрх мэдэл бий (жишээ нь, Австри, Албани, Армени, Австри, Бельги, Чили, Хорват, Чех, Эстони, Гүрж, Герман, Латви, Лихтенштайн, Хойд Македон, Монтенегро, Польш, Серб, Словак, Словени, Испани, Швейцар, Турк, АНУ). Үүнийг шүүх өөрийн санаачилгаар (*ex officio*) эсхүл өргөдөл гаргагчийн хүсэлтээр хийж болдог. Харин ОХУ-д Үндсэн хуулийн шүүх нь маргаантай актын хэрэгжилтийг түдгэлзүүлэх тухай холбогдох байгууллагуудад зөвхөн санал болгож л болдог. Гэхдээ зарим улс эрх зүйн аюулгүй байдлын үүднээс түдгэлзэх гэж буй актын хэрэгжилтийг зөвшөөрдөггүй (жишээлбэл, Алжир, Андорра, Азербайжан, Беларусь, Болгар, Кипр, Франц, Люксембург, Бүгд Найрамдах Молдова Улс, Португал, Швед, болон Украин).

147. Үндсэн хуулийн төвлөрсөн бус хяналтын тогтолцоотой улсын хувьд маргаантай норматив эсхүл нэг бүрчилсэн актын хэрэгжилтийг түдгэлзүүлэх нь түгээмэл бус (жишээ нь, Дани). Литвийн хувьд Үндсэн хуулийн шүүх ердийн шүүхээс урьдчилсан асуулт ирэхэд бус, харин Ерөнхийлөгч эсхүл парламентаас маргаантай актыг үндсэн хуульд нийцэж буй эсэхийг шалгуулахаар гаргасан ¹⁸³ хүсэлт хүлээн авснаар тухайн актыг түдгэлзүүлэх ёстой. Италид төр эсхүл бүс нутаг нь хууль, бүс нутгийн норматив актыг үндсэн хуульд нийцсэн эсэхийг хянуулахаар урьдчилсан хүсэлт гаргасан тохиолдолд үндсэн хуулийн шүүх нь тухайн хуулийн хэрэгжилтээс болж иргэдийн эрхэд эсхүл эрх зүйн дэглэмд

¹⁸³ Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн 26 дугаар зүйл. Үндсэн хуулийн шүүх парламент эсхүл ерөнхийлөгчийн өргөдлийг хүлээн авах шийдвэрийг гаргасны дараа маргаантай актыг түдгэлзүүлэх ёстой (Бүгд Найрамдах Литва Улсын Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн 26-р зүйлийг үзнэ үү).

Венецийн комисс

хохирол учруулж болзошгүй бол уг хуулийн хэрэгжилтийг түдгэлзүүлэхээр үндэслэлтэй шийдвэр гаргаж болно.¹⁸⁴

148. Маргаан бүхий нэг бүрчилсэн эсхүл норматив актын хэрэгжилт нь нөхөж баршгүй хохирол учруулж болзошгүй бол тухайн актын хэрэгжилтийг түдгэлзүүлэх эрх үндсэн хуулийн шүүхэд олгохыг Венецийн Комисс дэмжиж байна.¹⁸⁵ Түдгэлзүүлэх нөхцөл нь хэтэрхий хатуу байж болохгүй.¹⁸⁶ Гэхдээ норматив актын хувьд түүнийг хэрэгжүүлэхгүй байх нь засаж залруулах боломжгүй зөрчил, шинэ хохирол учруулахад хүргэх эсэх байдлыг анхаарч үзэх ёстой.

2. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлэх

149. Ихэнх улс оронд ердийн шүүхээс үндсэн хуулийн шүүхэд урьдчилсан хүсэлт тавьсан тохиолдолд ердийн шүүх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаагаа түдгэлзүүлдэг (жишээ нь, Албани, Андорра, Армен, Австри, Бельги, Чили, Хорват, Франц, Герман, Гүрж, Грек, Унгар, Итали, Латви, Лихтенштайн, Литва, Люксембург, Хойд Македон, Сан Марино, Словени, Швейцар, Турк¹⁸⁷, Украин). Эдгээрээс зарим улс нь үндсэн хуулийн шүүхийн шийдвэр үл нөлөөлөх асуудлаар, эсхүл маргааны асуудлыг эцэслэн шийдэхгүй ч үндсэн хуулийн шүүхийн шийдвэр гартал хойшлуулж болохгүй асуудлаар ердийн шүүх шийдвэр гаргахыг зөвшөөрдөг (жишээ нь, Австри¹⁸⁸).

150. Бусад улс оронд, хэрэв ердийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг үргэлжлүүлэхийн тулд үндсэн хуультай холбоотой асуудлыг зайлшгүй шийдвэрлэх шаардлагатай л биш бол ердийн хэрэг хянан шийдвэрлэх

¹⁸⁴ 2003 онд нэмэлт өөрчлөлт оруулсан 1953 оны 3-р сарын 11-ний өдрийн 87-р хуулийн 35-р хэсэг.

¹⁸⁵ Venice Commission, CDL-AD(2004)024, Opinion on the draft constitutional amendments with regard to the Constitutional Court of Turkey, para. 47.

¹⁸⁶ Venice Commission, CDL-AD(2007)039, Comments on the Draft Law on the Constitutional Court of the Republic of Serbia, para. 23.

¹⁸⁷ Турк улсын Үндсэн хуулийн 152 дугаар зүйлд "Хэргийг хянан хэлэлцэж байгаа шүүх нь хууль эсхүл хуулийн хүчин чадалтай тогтоолыг үндсэн хуультай зөрчилдсөн, эсхүл аль нэг талын гаргасан үндсэн хуулийн асуудлаарх нэхэмжлэлийг ноцтой гэж үзвэл Үндсэн хуулийн шүүхээс уг асуудлыг шийдвэрлэтэл хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хойшлуулна. Хэрэв шүүх үндсэн хуулийн асуудлаарх нэхэмжлэлийг ноцтой гэж үзээгүй бол уг нэхэмжлэлийг үндсэн шүүхийн шийдвэртэй хамт давж заалдах шатны эрх бүхий этгээд хянан шийдвэрлэнэ. Үндсэн хуулийн шүүх маргааныг хүлээн авснаас хойш таван сарын дотор уг асуудлыг шийдвэрлэж, нийтэд мэдээлнэ. Энэ хугацаанд шийдвэр гарахгүй бол шүүх хэргийг хүчин төгөлдөр үйлчилж буй хуулийн заалтын дагуу хянан шийдвэрлэнэ. Харин шүүх шийдвэр гарахаас өмнө Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрийг хүлээн авсан тохиолдолд шүүх уг шийдвэрийг дагаж мөрдөх үүрэгтэй."

¹⁸⁸ Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн 62.3-р зүйл: "(3) Шүүх (бие даасан захиргааны зөвлөл, Холбооны төрийн худалдан авах алба) хууль эсхүл түүний зарим хэсгийг хүчингүй болгох хүсэлт гаргасан бол гагцхүү Үндсэн хуулийн шүүхийн шийдвэр үл нөлөөлөх эсхүл Үндсэн хуулийн шүүхийн шийдвэр гарч үйлчлэх хүртэл хойшлуулж болохгүй буюу эцэслэн шийдвэрлэхгүй байх ажиллагааг явуулах эсхүл шийдвэр гаргах боломжтой."

ажиллагааг тасалдуулдаггүй. Жишээлбэл, Словени улсад үндсэн хуультай холбоотой асуудал нь ердийн хуультай холбоотой бол ердийн шүүх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлэх үүрэгтэй. Гэхдээ хэрэв тухайн акт нь гүйцэтгэх хэм хэмжээний зохицуулалт бол ердийн шүүх *exceptio illegalis* гэгдэх зарчмыг хэрэглэж, үндсэн хуультай нийцээгүй зүйл заалтыг хэрэглэлгүйгээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг үргэлжлүүлдэг. Үүний нэгэн адил Хорватад хэрэв ердийн шүүх хэрэглэх гэж байгаа хуулийн талаар эргэлзэж байвал хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлэх ёстой; хэрэв захиргааны хэм хэмжээний талаар эргэлзээ байгаа бол шүүх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлэхгүйгээр уг хэм хэмжээний үндэслэл болсон хуулийг шууд хэрэглэж, тухайн захиргааны хэм хэмжээг үндсэн хуулийн шүүхэд хянуулахаар хандана. Андорра улсад хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа үргэлжилдэг ч шийдвэр гаргах боломж хязгаарлагдмал: Үндсэн хуулийн шүүхийн шийдвэр нь ердийн шүүхийн шийдвэрт нөлөөлөхгүй гэдгийг заавал тогтоох ёстой.

151. Испанид ердийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлдэггүй. Харин ердийн шүүх гагцхүү хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дууссаны дараа болон шүүхийн шийдвэр гаргахаар зөвлөлдөхөөс өмнө асуулт тавьж болно. Иймд хэдийгээр тухайн зүйл заалтын үндсэн хуульд нийцсэн эсэхэд эргэлзээ байгаагаас үл хамаарч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа үргэлжилсэн байсан ч ердийн шүүхийн шийдвэр нь үндсэн хуулийн шүүхийн шийдвэрээс хамаарна. Энэ арга нь хугацаа хэмнэж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны нийт хугацааг багасгахад тусалдаг.

152. **Ердийн шүүгч аль нэг хуулийг үндсэн хуульд нийцээгүй гэж үзсэн бол тухайн хуулийг хэрэглэх албагүй бөгөөд мөн ижил хэрэг дээр үндсэн хуулийн шүүх уг хуулийг үндсэн хуульд нийцэж байгаа эсэхийг шийдэх ёстой.**¹⁸⁹ Үндсэн хуулийн шүүхэд урьдчилсан асуулт тавьсан үед ердийн шүүх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг нэн даруй буюу ердийн шүүхийн шийдвэр гарахаас өмнө түдгэлзүүлэх ёстой гэж Венецийн Комисс үзэж байна. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлэхийг *ipso jure* эсхүл ердийн шүүхийн шийдвэрээр тодорхойлно.

В. Эцсийн шийдвэрүүд

153. Үндсэн хуулийн шүүхийн эцсийн шийдвэр олон янзын үр нөлөөтэй. Шийдвэрийн нөлөө нь *inter partes* эсхүл *erga omnes* (*ratione personae* нөлөөлөл) эсэхээс хамаарч янз бүрийн тооны хүмүүст нөлөөлж болно. Өөр өөр хугацаанд үйлчлэх (*ratione temporis* нөлөөлөл) эсхүл өөр өөр төрлийн шийдвэрүүд (*ratione materiae* нөлөөлөл) байж болно. Шийдвэрийн нөлөөллийн хүрээ, шийдвэрийг

¹⁸⁹ Venice Commission, CDL-AD(2011)040, Opinion on the law on the establishment and rules of procedure of the Constitutional Court of Turkey, para. 57.

Венецийн комисс

буцаан хэрэглэх боломж нь тухайн хувь хүний гомдлыг үр дүнтэй арилгаж чадах эсэхийг тодорхойлдог.

1. *Ratione personae* нөлөө

154. Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрийн нөлөө нь *inter partes* эсхүл *erga omnes* байж болно. *Erga omnes* нөлөө бүхий шийдвэр хүн бүрд хамаатай. Үүний эсрэгээр, *inter partes* нөлөөлөлтэй шийдвэр нь тодорхой эрх зүйн маргааны талуудад л үйлчилдэг. Норматив актыг эсэргүүцсэн гомдлын үр дүнд гарсан шийдвэр нь ерөнхийдөө *erga omnes* нөлөөтэй байдаг бол нэг бүрчилсэн актын эсрэг гаргасан гомдлын шийдвэр нь *inter partes* нөлөөтэй. Гэхдээ нэг бүрчилсэн актын хувьд гаргасан шийдвэрийн эрх зүйн үндэслэл нь бусад хэрэгт нөлөөлж болно.

155. Ихэнх улсад хэрэв эрх зүйн хэм хэмжээг үндсэн хуульд нийцсэн эсэх асуудал хөндөгдвөл үндсэн хуулийн шүүх түүнийг эрх зүйн дэг журмаас хасах эрхтэй. Гэвч зарим улсад шүүхийн эрх мэдэл илүү хязгаарлагдмал байдаг бөгөөд шийдвэр нь зөвхөн хэргийн оролцогчдод л мөрдөгддөг (*inter partes* нөлөөлөл). Тухайлбал, Мальтад үндсэн хуулийн шүүх шийдвэрээ хууль тогтоогчид өргөн барьдаг ба хууль тогтоогчид шүүхийн шийдвэрийн дагуу хууль тогтоомжийг өөрчлөх, эсхүл хэвээр нь үлдээх эсэхийг шийдэх эрхтэй.¹⁹⁰ Үндсэн хуулийн төвлөрсөн бус хяналттай улсуудад маргаантай норматив акт нь албан ёсоор "бүртгэлд" үлддэг ч хэрэглэгдэх боломжгүй болно. Хэрэв төрийн байгууллага уг хуулийг хэрэгжүүлэх гэж оролдох эсхүл түүний үндсэнд ямар нэг үйлдэл үйлдсэн бол тухайн үйлдэлд өртсөн этгээд энэ талаар гомдол гаргаж болох бөгөөд шүүх тухайн хүний талд шийднэ. Практикт төрийн байгууллагууд бараг уг хууль огт байгаагүй мэт ажилладаг (жишээлбэл, Дани, Финланд, Исланд, Мальта, Норвег, Швед, АНУ).

156. Үндсэн хуулийн төвлөрсөн бус хяналттай болон нийтлэг эрх зүйн тогтолцоотой улсад прецедентийн онол (*stare decisis*) шүүхийн шийдвэрийн уялдаа холбоог ихээхэн хангаж иргэнлэг эрх зүйн систем дэх *erga omnes* нөлөөлөлтэй дөхнө. Доод шатны шүүх заримдаа дээд шатны шүүхийн шийдвэрийн үндэслэлийг (*ratio decidendi*) хэрэглэхээс татгалзаж болох ч өөрийн шинэ шийдвэрээ зөвтгөхийн тулд одоогийн хэрэг яагаад урьд өмнө шийдэгдсэн хэргүүдээс ялгаатай болохыг тайлбарлах ёстой (жишээлбэл, Канад, Кипр,¹⁹¹

¹⁹⁰ Venice Commission, CDL-AD(2018)028, Malta - Opinion on Constitutional arrangements and separation of powers and the independence of the judiciary and law enforcement para. 76; Art. 242 Code of Organization and Civil Procedure

¹⁹¹ Улсын дээд шүүхээс давж заалдах журмаар эсхүл өөрийн харьяаллын журмаар хэрэг хянан шийдвэрлэх явцад шийдсэн хэргийн *ratio decidendi* нь доод шатны шүүхүүдэд мөрдөгдөнө.

Мексик, Перу,¹⁹² Өмнөд Африк, АНУ). *Stare decisis* зарчмыг үл харгалзан нийтлэг эрх зүйн тогтолцоотой улсын дээд шүүх гомдлыг хянан хэлэлцсэн шүүгчдийн олонхын санал, зохих үндэслэлээр өөрсдийн шийдвэрийг хүчингүй болгож болно. Төвлөрсөн хяналтын тогтолцоотой зарим улсад¹⁹³ үндсэн хуулийн шүүх нь өөрийн тогтоосон прецедентыг дагаж мөрддөг боловч гишүүдийн олонхын саналаар үндэслэлтэй шийдвэр гаргах замаар тэдгээрийг хүчингүй болгож болно (жишээлбэл, Андорра¹⁹⁴).

157. Парламентын хөндлөнгийн оролцоогүйгээр үндсэн хуультай зөрчилдөж буй хуулийн заалтуудыг тодорхойлж, тэдгээр заалтыг хүчингүй болгох нь үндсэн хуулийн шүүхийн үндсэн үүрэг гэж Венецийн комисс үзэж байна. Хэрэв шүүх хууль эсхүл түүний аливаа хэсгийг үндсэн хуультай нийцээгүй гэж шийдвэл үндсэн хуулийн шүүхийн шийдвэр нийтлэгдсэн өдрөөс эхлэн хүчингүй болсонд тооцвол зохино.¹⁹⁵ Иймд норматив актыг хүчингүй

¹⁹² Үндсэн хуулийн шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн VI зүйлд: “Шүүгч хууль, эсхүл хуулийн хүчин чадалтай аливаа хэм хэмжээг үндсэн хуулийн шүүхээс гаргасан тогтоолд заасан тайлбарт нийцүүлэн үндсэн хуулийн зарчмын дагуу тайлбарлаж, хэрэглэнэ.” (*Los Jueces interpretan y aplican las leyes o toda norma con rango de ley los reglamentos según los preceptos y principios constitucionales, conforme a la interpretación de los mismos que resulte de las resoluciones dictadas por el Tribunal.*) VII зүйлд: “*Res judicata* эрх хэмжээ бүхий Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрт норматив үр нөлөөний хүрээг тодорхойлж заасан бол прецедент болно. Хэрэв Үндсэн хуулийн шүүх прецедент болгохгүй гэж шийдвэл шүүхийн шийдвэрийн үндэслэл болсон факт болон эрх зүйн үндэслэл болон прецедент болгохгүй байх шалтгаанаа дурдах ёстой.”

¹⁹³ Төвлөрсөн хяналтын системтэй Литвад *stare decisis* зарчимтай холбоотойгоор тодорхой онцлог зүйлс бий. Үндсэн хуулийн шүүхийн кейс эрх зүйн дагуу, тус шүүх прецедент болон өөрийн боловсруулсан, тэдгээр прецедентыг нотлох үндсэн хуулийн үзэл баримтлалыг дагаж мөрдөнө. Үндсэн хуулийн шүүхийн прецедентыг хэрэглэхгүйгээр шинэ прецедент гаргаж болох ч зөвхөн бодитоор зайлшгүй хэрэгтэй үндсэн хуулийн хувьд үндэслэл шалтгаантай байвал зохино. Үндсэн хуульд баталгаажсан үнэт зүйлсийг илүү хамгаалах шаардлага, хууль ёсны ашиг сонирхол, хүний жам ёсны болон үүсмэл эрхийг хэрэгжүүлэх боломжийг нэмэгдүүлэх шаардлагыг бий болгож буй нөхцөл байдлаар гагцхүү тодорхойлж болно. (Үндсэн хуулийн шүүхийн 2007 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн тогтоол).

¹⁹⁴ Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн 3 дугаар зүйлд: “1. Үндсэн хуулийн шүүх зөвхөн Үндсэн хууль болон энэ хуульд захирагдана. Үндсэн хуулийн шүүхийн тогтоосон прецедентууд нь шүүх дараа дараагийн үндсэн хуулийн тайлбарт заавал дагаж мөрдөх үүрэгтэй боловч шүүгчдийн үнэмлэхүй олонхын саналаар гаргасан үндэслэлтэй шийдвэрээр өөрчлөлт оруулж болно.

2. Өмнө дурдсан заалтыг тодруулах зорилгоор, прецедент гэдэг нь хамгийн багадаа хоёр ижил хэргийг нэг үзэл баримтлалд үндэслэсэн, нэг шийдвэрээр шийдвэрлэсэн тохиолдлыг ойлгоно.”

¹⁹⁵ Venice Commission, CDL-AD(2018)012, Amicus Curiae Brief for the Constitutional Court of Georgia on the effects of Constitutional Court decisions on final judgments in civil and administrative cases, para. 41; Venice Commission, CDL-AD(2009)014, Opinion on the Law on the High Constitutional Court of the Palestinian National Authority, para. 27.

болгосон үндсэн хуулийн шүүхийн шийдвэр нь *erga omnes* нөлөөлөлтэй байх хэрэгтэй гэж Комисс үзэж байна.¹⁹⁶

a. *Нэг бүрчилсэн актыг хүчингүй болгох нь*

158. Нэг бүрчилсэн актын эсрэг гаргасан үндсэн хуулийн иж бүрэн гомдлыг шийдвэрлэсэн шийдвэр нь ихэвчлэн зөвхөн *inter partes* нөлөөлөлтэй байдаг. Энэхүү шийдвэр нь зөвхөн өргөдөл гаргагч болон иргэн эсхүл арилжааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны гуравдагч талуудад болон тухайн актыг гаргасан захиргааны байгууллагад заавал мөрдөгдөнө. Хэргийн шалтгааны тодорхой нөхцөл байдал өөрчлөгдөөгүй л бол ирээдүйд тодорхой асуудлыг хөндөж болох төрийн байгууллагуудад мөн заавал мөрдөгдөж болно (жишээ нь, Австри гэх мэт). Зарим улсад нэг бүрчилсэн актын талаарх шийдвэр нь хэдийгээр *erga omnes* хэмжээний нөлөөлөлгүй байсан ч зөвхөн хэргийн оролцогчид бус илүү өргөн хүрээнд нөлөөтэй байж болно. Жишээлбэл, Монтенегрод нэг бүрчилсэн актаас болж хэд хэдэн хүний эрх зөрчигдсэн ч үндсэн хуулийн шүүхэд зөвхөн нэг гомдол гаргаж, шүүх уг актын талаар шийдвэр гаргасан бол шийдвэр нь зөвхөн гомдол гаргасан хүнд бус эрх нь зөрчигдсэн хүн бүрд үйлчилнэ.¹⁹⁷

159. Хэдийгээр нэг бүрчилсэн актын эсрэг гаргасан гомдлын дагуу гаргасан шийдвэр нь ихэвчлэн *inter partes* нөлөөтэй байдаг ч шийдвэрийн хууль зүйн үндэслэл нь бусад хэрэгт ч мөн нөлөөлж болно. Жишээлбэл, Германд Холбооны Үндсэн хуулийн шүүхийн хууль ёсны үндэслэл (цэвэр *obiter dicta* биш) нь төрийн бүх байгууллага, тэр дундаа шүүхүүдэд заавал мөрдөгдөнө. Хүлээн авахаас татгалзагдсан өргөдөлтэй холбоотой *Inter partes* үр дагавартай шийдвэр нь практикт өргөн хүрээнд нөлөө үзүүлж болно. Учир нь ирээдүйн өргөдөл гаргагчид (ялангуяа ердийн шүүх) үндсэн хуулийн шүүхийн шийдвэрийг дагах бөгөөд тухайн өргөдөл амжилттай шийдэгдэх эсэх талаар урьдчилж таамаглах боломжтой болно.¹⁹⁸

160. Үндсэн хуулийн шүүх нэг бүрчилсэн актыг хүчингүй болгохдоо дөрвөн төрлийн шийдвэр гаргаж болно: (a) хэргийн агуулгыг хянан шийдвэрлэх; (b) нэг бүрчилсэн актыг хүчингүй болгох; (c) хэргийг дахин нээхээр шийдвэрлэх, эсхүл (d) ердийн шүүхэд уг хэргээр дахиж хандах эрхийг тухайн иргэнд үлдээх.

¹⁹⁶ Venice Commission, CDL-AD(2018)028, Opinion on constitutional arrangements and separation of powers and the independence of the judiciary and law enforcement, para. 145.

¹⁹⁷ Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн 74 дүгээр зүйлийн дагуу “Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрээр эрх, үүрэг нь хөндөгдөж болзошгүй бусад этгээдэд үндсэн хуулийн гомдлыг илгээх бөгөөд тэдгээр этгээд Үндсэн хуулийн шүүхээс тогтоосон хугацаанд үндсэн хуулийн гомдолд хариу илгээх эрхтэй.”

¹⁹⁸ Jaeger, R and Broß, S., “Die Beziehungen zwischen den Verfassungsgerichtshöfen und den übrigen einzelstaatlichen Rechtsprechungsorganen, einschließlich der diesbezüglichen Interferenz des Handelns der europäischen Rechtsprechungsorgane”, Report for the XIIth Conference of European Constitutional Courts, p. 26.

161. Үндсэн хуулийн шүүх ихэвчлэн тухайн нэг бүрчилсэн актыг хүчингүй болгох ба/эсхүл хэргийг дахин хэлэлцэхийг захирамжлах, эсхүл уг хувь хүнд хэргээ ердийн шүүхэд дахин үүсгүүлэх боломж олгох гэсэн шийдвэр л гаргадаг. Хэрэв үндсэн хуулийн шүүх шүүхийн эцсийн шийдвэрийг хүчингүй болговол ихэвчлэн уг хэргийг дахин хэлэлцэхийг захирамжилдаг (жишээлбэл, Андорра, Босни Герцеговина, Хорват, Чех, Герман, Унгар, Лихтенштайн, Португал, Орос, Словак, Словени, Швейцар). Хэрэв үндсэн хуулийн шүүх үндсэн хууль зөрчсөн шийдвэрийг хүчингүй болгохгүйгээр хэргийг дахин хэлэлцэхийн тулд зөвхөн дээд шатны шүүх рүү шилжүүлдэг бол (жишээ нь, Азербайжан) дээд шатны шүүх үндсэн хуулийн шүүхээс гаргасан захирамжийг дагаж мөрдөх эсэх ярвигтай асуулттай тулгарна. Жишээлбэл, Сербийн хувьд үндсэн хуулийн шүүх нь захиргааны болон хууль тогтоох байгууллагад үндсэн хууль зөрчиж болзошгүй нөхцөл байдлыг засах хугацаа өгөхийн тулд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлэх нь тухайн байгууллагын уг захирамжийг биелүүлэх хүсэл зоригоос ихээхэн хамаарна. Үндсэн хуулийн шүүх ямар ч арга хэмжээ авалгүйгээр дахин шүүх хуралдаанд оролцох хүсэлтээ гарга гэж хувь хүнд өргөдөл гаргах явцыг даатгах нь бүр ч хүндрэлтэй нөхцөл байдал үүсгэнэ.

162. Зарим улсад үндсэн хуулийн шүүх хэргийг үндсээр нь хянан шийдвэрлэж болно (жишээлбэл, Армен, Бразил, Канад, Кипр,¹⁹⁹ Эстони, Исланд, Ирланд, Япон, Хойд Македон, Словени,²⁰⁰ Швейцар, Өмнөд Африк, Испани болон Америкийн Нэгдсэн Улс). Гэсэн хэдий ч тэдгээр улсад үндсэн хуулийн шүүх хэргийг шийдвэрлүүлэхээр анхан шатны шүүх рүү буцаах эрхтэй байдаг. Эдгээр ихэнх улсад ихэвчлэн ийм байна.²⁰¹

163. Зарим үндсэн хуулийн шүүх нь холбогдох байгууллагууд үндсэн хуулийн дагуу хэрхэн ажиллах, шийдвэр зөв хэрэгжүүлэх талаар чиглэмж өгч болох ч (жишээлбэл, Чех,²⁰² Герман, Мальта, Словак,²⁰³ Словени, Испани,²⁰⁴ Украин²⁰⁵) ихэнх улсад эерэг үйлдэл хийх тухай зөвлөх, тушаах эрх байхгүй. Энэ нь үндсэн хуулийн шүүхийн шийдвэрийг үр дүнгүй болгож болзошгүй юм. Иймд **үндсэн**

¹⁹⁹ Захиргааны эрх мэдлээ хэрэгжүүлэхдээ Улсын дээд шүүх захиргааны шийдвэрийг баталгаажуулах эсхүл хүчингүйд тооцож болно. Түүний бүрэн эрхэд захиргааны байгууллагын шийдвэрт нэмэлт өөрчлөлт оруулах эрх байхгүй. Шүүх нь захиргааны шийдвэрийн үндэслэлийг дахин хянаж, өөрийн шийдвэрээр солих эрхгүй. Ийм үйлдэл нь Үндсэн хуулиар хамгаалагдсан эрх мэдлийн хатуу хуваарилалтыг зөрчих болно. Захиргааны салбарын шийдвэр гаргах эрх нь төрийн гүйцэтгэх засаглалд бүхэлдээ хамаарна. Шүүхийн хяналт нь захиргааны байгууллагын акт, эс үйлдэл нь хууль ёсны эсэхийг нягтлан шалгах зорилготой болохоос тэдгээрийн зөв эсэхийг шүүхийн үүднээс үнэлэхгүй.

²⁰⁰ Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн 60 дугаар зүйл.

²⁰¹ Venice Commission, CDL-INF(2001)009, Report on “Decisions of constitutional courts and equivalent bodies and their execution”, p. 17.

²⁰² Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн 82 дугаар зүйл.

²⁰³ Словакийн Үндсэн хуулийн 127(2).

²⁰⁴ Үндсэн хуулийн шүүхийн тухай органик хуулийн 55(1)(с).

²⁰⁵ Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн 70 дугаар зүйл.

хуулийн шүүх хэргийг ердийн шүүхэд буцаах үед тухайн хэрэг хянан шийдвэрлэх хуулийн холбогдох заалтууд нь ердийн шүүхийг уг хэрэг шилжүүлсэн захирамжийг дагаж мөрдөхийг үүрэг болгох ёстой гэж Венецийн комисс үзэж байна.²⁰⁶

164. Түүнчлэн, ердийн шүүх болон захиргааны байгууллага үндсэн хуулийн шүүхийн тайлбарыг дагаж мөрдөхгүй бол үндсэн хуулийн хяналт үр дүнгүй болно.²⁰⁷ **Иймээс Венецийн Комисс төрийн бусад бүх байгууллага болон ердийн шүүхийг үндсэн хуулийн шүүхийн гаргасан шийдвэрийг заавал дагаж мөрдүүлэх тусгай хууль, эсхүл бүр үндсэн хуулийн зохицуулалттай байхыг дэмжиж байна. Энэ нь ялангуяа Үндсэн хуулийн шүүх үндсэн хуульд нийцээгүй хуулийн заалтын талаар үндсэн хуулийн тайлбар гаргасан тохиолдолд чухал юм.**

165. Хэргийг иргэний эсхүл эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх журмаар дахин хэлэлцэх нь нөгөө тал ялж болох үр дүнд хүргэж болно. Энэ нь уг талын шударгаар олж авсан эрхэд нөлөөлөх нь тодорхой. Тухайн шүүхийн шийдвэрийн үндэслэл болсон хууль нь үндсэн хууль зөрчсөн гэдэг нь өмнө нь тухайн хэрэгт ялсан талын эсрэг ашиглагдах ёсгүй гэж Венецийн комисс үзэж байна. Энэ нь ямар ч тохиолдолд тухайн хэргийг дахин хэлэлцэж болохгүй гэсэн үг биш, харин хэргийг дахин хэлэлцэх эсэх, хэрхэн хэргийг нээж болох нь холбогдох тогтолцооноос хамаарна. Анхны шийдвэрээс үүссэн эрхийг тодорхой хэрэгт харгалзах нь зүйтэй. Хуулийг хүчингүй болгох нь олон хэрэгт нөлөөлж болзошгүй.²⁰⁸

166. Үндсэн хуулийн шүүх нэг бүрчилсэн актын эсрэг гаргасан иж бүрэн гомдлыг хянаж байхдаа зөвхөн тухайн актыг хүчингүй болгох л эрхтэй байж болно. Өөрөөр хэлбэл, тухайн нэг бүрчилсэн актын үндэслэл болсон норматив акт үндсэн хууль зөрчсөн, буюу иж бүрэн гомдолд хөндсөн зөрчил нь үндсэн хуульд нийцээгүй норматив актыг зөв хэрэглээнээс үүдсэн байсан ч уг актыг хүчингүй болгохыг хориглож болзошгүй. Ийнхүү норматив акт хүчинтэй хэвээр үлдэж, бусад хүмүүсийн үндсэн эрх зөрчигдсөөр байхад хүргэдэг.²⁰⁹ Жишээлбэл,

²⁰⁶ Venice Commission, CDL-AD(2018)012, Amicus curiae brief for the constitutional court of Georgia on the effects of constitutional court decisions on final judgments in civil and administrative case, para. 38.

²⁰⁷ Samuel, X., "Les réserves d'interprétation émises par le Conseil constitutionnel", available at: http://www.conseil-constitutionnel.fr/conseil-constitutionnel/root/bank_mm/pdf/Conseil/reserves.pdf.

²⁰⁸ Venice Commission, CDL-AD(2018)012, Amicus curiae brief for the Constitutional Court of Georgia on the effects of Constitutional Court decisions on final judgments in civil and administrative cases, para. 22.

²⁰⁹ Норматив үндсэн хуулийн гомдлын хүрээнд буюу эсрэг тохиолдолд үндсэн хуулийн шүүх тухайн хэм хэмжээний үндсэн дээр гаргасан нэг бүрчилж зохицуулсан актыг үндсэн хуульд нийцэж байгаа эсэхийг шийдвэрлэх боломжгүй байдаг.

Швейцарт өргөдөл гаргагч нь холбооны хууль тогтоомжийн эсрэг бус харин зөвхөн кантоны (*cantonal*) хууль тогтоомжийн эсрэг л нормативын хяналтын ажиллагаа үүсгэх хүсэлт гаргаж болно.

167. Гэсэн хэдий ч тус тайланд авч үзсэн улс орнуудын дунд ийм хандлага ховор. Эстони, Лихтенштайн, Литвын үндсэн хуулийн шүүх норматив актыг ижил журмаар хүчингүй болгох ёстой байдаг. ХБНГУ-д Холбооны Үндсэн хуулийн шүүх норматив актыг хүчингүй болгож болох боловч заавал тэгэх шаардлагагүй. Австрид²¹⁰ үндсэн хуулийн шүүх үндсэн хуулийн абстракт хяналт хийх зорилгоор хоёр дахь шүүх ажиллагааг үүсгэх үүрэгтэй. Австрид өргөдөл гаргагчийн ашиг сонирхолд харшлахгүй тохиолдолд л хуулийн заалтыг бүхэлд нь хүчингүйд тооцож болно гэдгийг анхаарах нь чухал. Хорват, Хойд Македон,²¹¹ Словени зэрэг улсад үндсэн хуулийн абстракт хяналт хийхээр тусдаа шүүх ажиллагаа хийх боломжтой. Испанид нэг бүрчилсэн акттай холбоотой гомдлыг ихэвчлэн цөөхөн шүүгчтэй бүрэлдэхүүнээр хэлэлцүүлдэг. Гэвч, энэхүү цөөхөн шүүгчийн бүрэлдэхүүнтэй танхим нь уг нэг бүрчилсэн актын үндэслэл болсон норматив актыг үндсэн хууль зөрчсөн байж болзошгүй гэж үзвэл уг хэргийг нэгдсэн хуралдаанд шилжүүлэх ба абстракт болон конкрет хяналтыг нэг ажиллагаагаар явуулах болно.²¹²

b. Норматив актыг хүчингүй болгох нь

168. Үндсэн хуулийн шүүх норматив актыг үндсэн хууль зөрчсөн гэж үзвэл хоёр сонголттой. Нэгдүгээрт, *erga omnes* бүхий актыг хүчингүй болгох үүрэгтэй. Дараа нь энэхүү норматив актыг эрх зүйн дэг журмаас хасаж, цаашид хэрэглэх боломжгүй болгоно. Эсхүл тухайн актыг Үндсэн хууль зөрчсөн хэмээн тогтоож, улмаар тухайн тодорхой тохиолдолд хэрэглэх боломжгүй болгох ч эрх зүйн дэг журмаас хасахаас татгалзаж (эсхүл хасах эрх мэдэлгүй) болно.

169. Энэхүү тайланд судалсан ихэнх улсуудад норматив үндсэн хуулийн гомдол, эсхүл норматив актыг эсэргүүцэж гаргасан иж бүрэн гомдол нь *erga omnes* нөлөөтэй байдаг (жишээлбэл, Алжир, Армени, Австри, Азербайжан, Босни болон Герцеговина, Чех, Эстони,²¹³ Герман, Унгар, Латви, Лихтенштайн, Хойд Македон, Польш, Словени, Орос, Өмнөд Африк, Испани). Энэ нь үндсэн хуулийн шүүх норматив актыг хүчингүй болгоно гэсэн үг. Ийнхүү уг норматив актыг эрх

²¹⁰ Австрид Үндсэн хуулийн шүүх үх өөрийн санаачилгаар норматив актыг хянан хэлэлцэх шинэ ажиллагаа нээж, үндсэн хуулийн гомдлын дагуу хэрэг хянан хэлэлцэх ажиллагааг түдгэлзэнэ. Шийдвэр гарсны дараа абстракт хяналтын журмаар дахин тодорхой хэргийг авч үздэг.

²¹¹ Үндсэн хуулийн шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмын 56 болон 14-ийг үзнэ үү.

²¹² Үндсэн хуулийн шүүхийн тухай органик хуулийн 55(2).

²¹³ Хэрэв дээд шүүхээс шийдвэр гаргасан ганц тохиолдол. Хэрэв ердийн шүүхүүд тухайн хэм хэмжээг үндсэн хууль зөрчсөн гэж үзвэл шийдвэр нь зөвхөн *inter partes* нөлөөлтэй байна. Гэхдээ ийм тохиолдолд *dega omnes* нөлөөтэй ээд шүүхийн автоматаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явагддаг.

Венецийн комисс

зүйн дэг журмаас хасаж, цаашид хэрэглэх боломжгүй болгоно. Өмнөд Африкт ердийн шүүх норматив актыг үндсэн хууль зөрчсөн гэж үзэж болох ч ийм мэдэгдлийг хүчин төгөлдөр болохоос өмнө үндсэн хуулийн шүүх баталгаажуулсан байх ёстой. Үүний үр дүнд үндсэн хуулийн төвлөрсөн бус болон төвлөрсөн хяналт хослоход хүрнэ.

170. Цөөн хэдэн улсад үндсэн хуулийн шүүх норматив актыг зөвхөн тодорхой тохиолдолд хэрэглэх боломжгүй гэж үзэх хязгаарлалттай байдаг (жишээлбэл, Аргентин, Дани, Финланд, Япон, Норвег, Швед). Ийм тохиолдолд шүүхийн эрх зүйн нэгдмэл, албан ёсны тогтсон практик байхгүй. Иймд тогтворгүй шийдвэрүүдийн улмаас хууль зүйн тодорхойгүй байдал үүсэхээс сэргийлж шүүхийн тогтолцооны уялдаа холбоог хангасан хатуу албан бус хэм хэмжээ байх ёстой.

171. Норматив актыг урьдчилсан хүсэлтийн дагуу хянасан тохиолдолд, үндсэн хуулийн шүүхийн шийдвэр нь талуудад заавал биелүүлэх шинжтэй гардаг бөгөөд ердийн шүүх үндсэн хуулийн шүүхийн шийдвэрийг тодорхой хэрэгт заавал хэрэглэх үүрэгтэй.²¹⁴ Олон улсад урьдчилсан асуултын дагуу үндсэн хуулийн шүүхийн гаргасан шийдвэр нь үндсэн хууль зөрчсөн гэсэн дүгнэлтээс давж, *erga omnes* нөлөө бүхий маргаантай норматив актыг хүчингүй болгодог (жишээлбэл, Албани, Андорра, Болгар, Чех, Грек, Итали, Литва, Хойд Македон, Румын, Сан Марино, Өмнөд Африк²¹⁵).

172. Туркт хүсэлт гаргасан ердийн шүүх үндсэн хуулийн шүүхийн шийдвэрийг таван сар л хүлээх ёстой. Эс бол хүсэлт гаргасан шүүх маргаантай хуулийг хэрэглэн хэргийг үргэлжлүүлэх ёстой. Гэсэн хэдий ч, хүсэлт гаргасан шүүх үндсэн хуулийн шүүхийн шийдвэрийг эцсийн шийдвэрээ гаргахаас өмнө хүлээн авсан бол заавал түүнийг дагаж мөрдөх үүрэгтэй.²¹⁶ Португалийн хувьд үндсэн хуулийн шүүхийн шийдвэр нь зөвхөн гаргасан хүсэлтээр хязгаарлагдах ч гэсэн хувь хүний хэргүүдэд тухайн хуулийн заалтыг үндсэн хууль зөрчиж байна гэсэн гурван шийдвэр гаргасан бол үндсэн хуулийн шүүх тухайн заалтад абстракт хяналт хийхээр хянан шалгах ажиллагаа эхлүүлж болно. Үндсэн хуулийн шүүх тухайн заалтыг үндсэн хуульд нийцээгүй гэж үзсэн бол уг шийдвэр нь *erga omnes*

²¹⁴ Тухайлбал дараахыг харна уу: Үндсэн хуулийн шүүхийн Андоррагийн хуулийн 57 зүйл: “2. Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрийг хэрэг маргааныг шилжүүлсэн шүүх дагаж мөрдөнө.”

²¹⁵ Өмнөд Африкт хэрэв норматив акт (хууль) нь Үндсэн хуульд нийцээгүй гэж шүүх тогтоовол тэр хэмжээгээр хүчингүйд тооцогдох ба энэхүү хүчингүй болсон тухай мэдэгдлийг Үндсэн хуулийн шүүх баталгаажуулсны дараа норматив акт (хууль) нь үйлчлэлгүй болно.

²¹⁶ Туркийн Үндсэн хуулийн 152(3).

нөлөөтэй байна.²¹⁷ Үүний нэгэн адил Бразил, Мексикт²¹⁸ дээд шүүх эсхүл үндсэн хуулийн шүүх нэг ижил ерөнхий акттай холбоотой таван шийдвэр гаргасны дараа уг актыг үндсэн хууль зөрчсөн гэж үзэж болно.

с. *Акт нь үндсэн хуульд нийцэж буйг баталгаажуулсан шийдвэр*

173. Үндсэн хуулийн шүүх норматив болон нэг бүрчилсэн актыг хүчингүй болгохоос татгалзаж, үндсэн хуульд нийцэж байгаа гэж үзсэн шийдвэрийн үр дагавар нь *inter partes* эсхүл *erga omnes* нөлөөтэй байдаг. Үндсэн хуулийн шүүх тухайн хэргийн оролцогчдын аль нэг нь адил хуулийн талаар гаргасан хүсэлтийг хүлээн авахгүй тул үндсэн хуульд нийцэж байгаа эсэхийг баталгаажуулсан шийдвэр нь *inter partes* болно (жишээ нь, Румын, Испани, Швейцар). Ингэснээр өөр өөр өргөдөл гаргагчид үндсэн хуулийн шүүхэд хандаж болох тул нэг ижил талууд нэг л хэргээрээ дахин хандахаас сэргийлнэ.²¹⁹

174. Хоёрдугаарт, аливаа актыг үндсэн хуультай нийцэж буйг баталгаажуулсан шийдвэр нь *erga omnes* нөлөөтэй байж болно (жишээлбэл, Андорра, Армен, Австри, Бельги, Чили, Франц, Герман, Литва, Бүгд Найрамдах Молдова, Перу). Энэ нь уг асуудлаар дахиж хэн ч гомдол гаргаж болохгүй гэсэн үг юм. Жишээлбэл, Перугийн ердийн шүүгч нь аль хэдийн Үндсэн хуулийн шүүхээс үндсэн хуульд нийцэж байгаа нь нотлогдсон хэм хэмжээний хувьд түүний үндсэн хууль зөрчсөн эсэх талаар дахин авч үзэхгүй. **Зарим улсад хуулийг үндсэн хуульд нийцсэн гэж**

²¹⁷ Португалд, тухайн хэм хэмжээг үндсэн хууль зөрчсөн гэх урьдчилсан хүсэлтийн дагуу Үндсэн хуулийн шүүхээс гурван шийдвэр гаргасан байх нь бие даасан хяналтыг эхлүүлэх урьдчилсан нөхцөл болох ба энэ нь абстракт хэлбэрийн хяналт байна. Шинээр хийх хяналт бие даасан хяналтын хувьд Үндсэн хуулийн шүүхийн Хэсгүүдээс таван шүүгчээс бүрдсэн бүрэлдэхүүний өмнөх шийдвэртэй санал үл нийлсэн шинэ шийдвэр гарах боломжтой. 2009 оны 5 дугаар сарын 5-ны 221/2009 шийдвэрийг харна уу. Үндсэн хуулийн шүүх дэх Улсын прокурорын газрын төлөөлөгчөөс Улсын эрүүл мэндийн газарт хамаарах үйлчилгээ, байгууламжид эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх төлбөрийн тухай хуулийн зохицуулалтыг үндсэн хууль зөрчсөн гэж нийтээр дагаж мөрдөх шийдвэр гаргуулахаар Үндсэн хуулийн шүүхээс хүссэн байна. Уг хэрэгт сонирхогч этгээд Улсын эрүүл мэндийн газрын үйлчлүүлэгчийн картыг үзүүлээгүй бөгөөд хуулиар заасан хугацаанд багтаж ийм карт авсан эсхүл авахаар хүсэлт өгснийг нотлох баримт гаргаагүй байна. Үндсэн хуулийн шүүх уг зохицуулалтыг үндсэн хуультай үндсээрээ нийцээгүй гэж гурван урьдчилсан ажиллагаагаар тогтоосон байжээ. Гэхдээ 221/2009 шийдвэрээр шүүх бүрэлдэхүүн үндсэн хуультай зөрчилдсөн гэж нийтэд дагаж мөрдөх шийдвэр гаргахгүй байхаар шийдсэн. Улсын прокурорын газар нийтлэг үйлчлэх хууль ёсыг тогтоох процесс хийлгэх хүсэлт гаргах эрхтэй ч энэхүү процессыг Үндсэн хуулийн шүүхийн шүүгч мөн санаачилж болохыг дурдах нь зүйтэй.

²¹⁸ Ginsberg, T., "Comparative Constitutional Review", United States Institute for Peace Projects, 2008, p. 5, available at:

https://www.usip.org/sites/default/files/ROL/TG_Memo_on_Constitutional_Review%20for%202011_v4.pdf

²¹⁹ Kucsko-Stadlmayer, G., "Die Beziehungen zwischen den Verfassungsgerichtshöfen und den übrigen einzelstaatlichen Rechtsprechungsorganen, einschließlich der diesbezüglichen Interferenz des Handelns der europäischen Rechtsprechungsorgane", Report for the XIIth Conference of European Constitutional Courts, 2002, p. 23.

тогтоогдсоноос хойш хэдэн жилийн дараа л гомдол гаргаж болно. Ийм хязгаарлалт нь шүүхийг огт өөр нөхцөл байдалд Үндсэн хууль зөрчсөн гэдгийг тогтооход саад учруулдаг тул хэт хатуу байж магадгүй юм.

2. *Ratione temporis* нөлөө

175. Норматив актыг үндсэн хууль зөрчсөн гэх шийдвэр хугацаанаас хамаарч өөр өөр үр дагавартай байж болно. Энэ нь зарим тохиолдолд бууруулах шаардлагатай өөр өөр асуудал үүсгэж болно.

a. Ex tunc болон ex nunc хүчингүй болгох

176. Үндсэн хууль зөрчсөн заалтыг хүчингүй болсонд тооцох хугацааны тухайд Венецийн Комисс дараах хоёр үзэл баримтлал байгааг ажиглалаа: “Хэрэв үндсэн хуультай нийцээгүй хуулийг хүчингүй гэж үзсэн бол уг хуулийг үндсэн хууль зөрчсөн гэж үзсэн үндсэн хуулийн шийдвэр нь *ex tunc* (анхнаасаа) нөлөөтэй байна. Үүнийг мөн хүчингүй байдлын үзэл (*doctrine of nullity*) гэж нэрлэдэг. Үндсэн хуульд нийцээгүй хуулийг хүчингүй болгох хүртэл хүчинтэй гэж үзвэл үндсэн хууль зөрчсөн гэж үзсэн үндсэн хуулийн шүүхийн шийдвэр *ex nunc* (шийдвэр гарсан мөчөөс эхлэн) нөлөөтэй.”²²⁰ Өөрөөр хэлбэл, хууль нь *ex tunc* байдлаар хүчингүй болсон тохиолдолд уг хууль огт байгаагүй мэт болно. *Ex nunc* байдлаар хүчингүй болсон хууль, уг хүчингүй болгосон шийдвэр гарснаас хойш л хүчинтэй байхаа больж өмнөх хугацаанд хүчинтэй байсан гэж үзнэ.

177. Үндсэн хуульд нийцээгүй хэм хэмжээг хүчингүй болгох үндсэн хуулийн шүүхийн шийдвэрийн хамгийн түгээмэл хэлбэр бол *ex nunc* байдлаар хүчингүй болгох юм (жишээлбэл, Албани, Андorra, Алжир, Армен, Австри, Беларусь, Бразил, Чили, Хорват, Чех,²²¹ Франц, Гүрж, Грек, Унгар, Итали, БНСУ, Косово, Латви, Лихтенштайн, Литва,²²² Люксембург, Мексик, Бүгд Найрамдах Молдова,

²²⁰ Venice Commission, CDL-AD(2018)012, Amicus Curiae Brief for the Constitutional Court of Georgia on the effects of Constitutional Court decisions on final judgments in civil and administrative cases, para. 44.

²²¹ Бүгд Найрамдах Чех улсын хувьд Үндсэн хуулийн шүүх урьд өмнө хэзээ ч *ex tunc* нөлөө бүхий шийдвэр гаргаж байгаагүй ч хууль зүй, үндсэн хуулийн эрдэмтэд ийм тохиолдол гарч болохыг үгүйсгэж болохгүй гэж үздэг. (see, for instance, Wagnerová, E., Dostál, M., Langášek, T., et al., *Zákon o Ústavním soudu s komentářem* [The Act on the Constitutional Court with Commentary], ASPI, Praha 2007, p. 206).

²²² Үндсэн хуулийн шүүхийн 2012 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн шийдвэр нь *ex tunc* нөлөөтэй байж болох зарим онцгой тохиолдлыг гаргасан. Эдгээр онцгой тохиолдолд, тухайлбал, хуулиар үндсэн хууль зөрчсөн гэж хүлээн зөвшөөрсөн хууль тусгаар тогтнол, ардчилал, бүгд найрамдах тогтолцоо, хүний эрх, эрх чөлөөний төрөлхийн жам ёсны мөн чанар зэрэг үндсэн хуулийн үндсэн зарчмуудыг (“мөнхийн заалтууд”) зөрчсөн гэж үзсэн тохиолдлууд үүнд хамаарна.

Монтенегро, Хойд Македон, Перу, Польш, Португал, Румын, Орос, Сан Марино, Серби, Словак, Словени,²²³ Украин).

178. *Ex nunc* нөлөөллийн хэд хэдэн хувилбар байдаг. Хамгийн хатуу хэлбэр нь аливаа хэм хэмжээг үндсэн хууль зөрчсөн гэсэн шийдвэр хүчинтэй болохоос өмнө үүссэн тохиолдлуудад ч тухайн хэм хэмжээг хэрэглэх боломжтой хэвээр байна. Иймд үндсэн хуулийн шүүхийн шийдвэр нь уг шийдвэрийг нийтлэгдэхээс өмнө эцэслэсэн эрх зүйн харилцаанд нөлөөлөхгүй. Энэхүү шийдлийн үндэслэл нь хувь хүний эрхийг хамгаалахаас илүү хууль зүйн тодорхой байдлын зарчмыг нэн тэргүүнд тавих явдал юм.²²⁴ Хэрэв шүүхийн тухайн хэм хэмжээг хүчингүй болгосон шийдвэр ирээдүйд үйлчлэх тохиолдолд өргөдөл гаргагчийн хэрэг өмнө нь болсон учир үндсэн хууль зөрчсөн хэм хэмжээг арилгаснаар түүний асуудал нь шийдэгдэхгүй.²²⁵ Иймээс үндсэн хууль зөрчсөн гэдгийг тогтоосон ч өөрсдийнх нь хэргийн үр дүнг өөрчлөхгүй тул өргөдөл гаргагчид норматив актыг үндсэн хууль зөрчсөн эсэхээр гомдол гаргах сонирхол бага байна. Тиймээс, зарим улс хувь хүмүүсийг гомдол гаргахыг идэвхжүүлэхийн тулд өргөдөл гаргагчийн хэрэг дээр мөн шийдвэр үйлчлэхийг зөвшөөрдөг ба үүнийг "*premiur for the catcher*" гэж нэрлэдэг²²⁶ (жишээлбэл, Армен,²²⁷ Австри, Унгар, Лихтенштайн).

179. Зарим улс оронд *ex nunc* нөлөөллийн уян хатан хувилбар байдаг. Ийм нөлөөллийн хэлбэрт, шүүхийн шийдвэрийн үндэслэл болсон хэм хэмжээ нь хүчингүй болсон ч шүүхийн эцсийн шийдвэрт нөлөөлөхгүй. Үндсэн хууль зөрчсөн хэм хэмжээг хүчингүй болгох тухай үндсэн хуулийн шийдвэр нь тухайн шийдвэрийг зарласан өдрөөс хүчин төгөлдөр болдог. Зарчмын хувьд тухайн хэм хэмжээ нь шийдвэр гарахаас өмнөх хууль тогтоомжийн нэг хэсэг хэвээр байна. Гэвч, одоо хэлэлцэж байгаа хэрэг болон шинээр гарч байгаа хэрэг нь Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрт үндэслэгдэх ёстой бөгөөд шийдвэр гарахаас өмнө гарсан факттай холбоотой хэрэгт хүртэл үндсэн хууль зөрчсөн заалт үйлчлэхгүй. Үүний үр дүнд өргөдөл гаргагчийн ердийн шүүхийн эцсийн шийдвэр хүчингүй

²²³ Үндсэн хуулийн шүүх нь хуулийг үндсэн хууль зөрчсөн гэж үзвэл уг хуулийг *ex nunc* байдлаар хүчингүй болгодог. Төрийн эрх бүхий этгээдээс гаргасан журам, ерөнхий актыг Үндсэн хууль зөрчсөн эсхүл хууль бус гэж үзвэл түүнийг *ex nunc*, эсхүл *ex tunc* байдлаар хүчингүй болгох шийдвэр гаргаж болно (Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн 43, 45 дугаар зүйл).

²²⁴ Venice Commission, CDL-AD(2018)012, Amicus Curiae Brief for the Constitutional Court of Georgia on the effects of Constitutional Court decisions on final judgments in civil and administrative cases, paras. 49-51

²²⁵ 53 дугаар догол мөрийг харна уу.

²²⁶ Энэ нэр томъёо нь Австрид мөн байдаг ("Ergreiferprämie") (Venice Commission, CDLAD(2008)029, Opinion on the draft laws amending and supplementing (1) the Law on constitutional proceedings of Kyrgyzstan and (2) the Law on the Constitutional Court of Kyrgyzstan, 2008, para. 27 and Venice Commission, CDL-AD(2014)017, Opinion on the Draft Constitutional Law on the Constitutional Court of Tajikistan, para. 61).

²²⁷ Venice Commission, CDL-AD(2006)017, Opinion on Amendments to the Law on the Constitutional Court of Armenia, para. 7.

Венецийн комисс

болж, шинэ шийдвэр хүчингүй болсон хуулийн заалтад үндэслэгдэхгүй тул тухайн хэргийн хувьд тусгай журам гаргах шаардлагагүй болно.²²⁸

180. Харьцангуй цөөхөн улс үндсэн хуулийн шүүхийн шийдвэрт *ex tunc* нөлөөг нэвтрүүлсэн байдаг. Тухайлбал, Германд шүүхийн шийдвэрийн хууль зүйн тодорхой байдлыг хадгалахын тулд шүүхийн эцсийн шийдвэрээс бусад актыг анхнаасаа хүчингүй байсан гэж үзэхийг хязгаарладаг.²²⁹

b. Хүчингүй болгосны үр дагаврыг зохицуулах нь

181. *Ex tunc* болон *ex nunc* байдлаар хүчингүй болгох нь заримдаа үр дагаврыг бууруулах шаардлагатай нөхцөл байдалд хүргэж болзошгүй. Бараг бүх улс шүүхэд хүчингүй болсон тухай тогтоол хүчин төгөлдөр болох хугацаа болон буцаан хэрэглэх нөхцөл байдлыг өөр өөрөөр тогтоох боломжийг олгодог. Үүний шалтгаан нь хувь хүний үндсэн эрхийг хамгаалах (жишээ нь, Албани), хохирлыг арилгах буюу урьдчилан сэргийлэх (жишээ нь Армени, Азербайжан, Словени гэх мэт), эсхүл хууль тогтоох болон гүйцэтгэх засаглалд асуудалтай байгаа хууль тогтоомж буюу төр засгийн практикт өөрчлөлт оруулах боломжтой болгох юм (жишээ нь, Өмнөд Африк, Израил).

182. Нэг боломжит арга нь нь үндсэн хуулийн шүүхэд шийдвэрээ хэзээ хүчин төгөлдөр үйлчлэхийг шийдэхийг зөвшөөрөх явдал юм. ХБНГУ-ын Холбооны Үндсэн хуулийн шүүх нь шүүхийн шийдвэрийн *ex tunc* нөлөөг нэлээн ялгаатайгаар зохицуулах эрхтэй. *Ex tunc* (жишээ нь, Герман) болон *ex nunc* системд (жишээ нь, Франц), парламентад хууль засах хугацаа олгохын тулд шүүх шийдвэрээ хүчин төгөлдөр болох хугацааг хойшлуулж болдог. Үүний нэгэн адил Марокко, Израилд шүүх хүчингүй болгох шийдвэрийн хүчинтэй болох хугацааг тодорхой хугацаагаар хойшлуулаагүй тохиолдолд *ex nunc* шийдвэр батлагдсан өдрөөсөө хүчин төгөлдөр болно.²³⁰ Сан-Маринод *Collegio Garante* -ээс норматив актыг хүчингүй болгосноор үр дагавар нь нь зөвхөн холбогдох талуудад л шууд үйлчилнэ. Бусад бүх хүмүүсийн хувьд шийдвэр зургаан сарын дараа үйлчилнэ. Энэ хугацаанд парламент шүүхийн шийдвэрийн дагуу шинэ акт гаргаж болно.²³¹ Өмнөд Африкт норматив актыг үндсэн хуультай зөрчилдсөн гэдэг үндэслэлээр

²²⁸ Venice Commission, CDL-AD(2018)012, Amicus Curiae Brief for the Constitutional Court of Georgia on the effects of Constitutional Court decisions on final judgments in civil and administrative cases, para. 58.

²²⁹ Холбооны Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн 79(1), 79(2)-т зааснаар хүчингүй болсон тооцсон хууль тогтоомжид үндэслэсэн эцсийн шийдвэр нь, тухайн хуулийн зүйл заалтыг *ex tunc* байдлаар хүчингүй болсон гэж үзсэн байсан ч хэвээр үлдэнэ. Зөвхөн ялыг эцэслэн тогтоох тохиолдолд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хуулийн зүйл заалтын дагуу шинээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж болно.

²³⁰ Мароккогийн Үндсэн хуулийн шүүхийн тухай 066-13 тоот органик хуулийн 27 дугаар зүйл.

²³¹ Иргэдийн эрхийн тунхаглал ба Сан-Мариногийн үндсэн хуулийн дэг журмын зарчмуудын 16(7).

хүчингүй гэж тогтоосон ердийн шүүх ч гэсэн актыг зөвхөн тодорхой хугацааны туршид түдгэлзүүлэх, мөн буцаан хэрэглэхтэй холбоотой шийдвэр гаргах эрхтэй.

183. Ялангуяа, *ex tunc* хүчингүй болгох нь нэлээн хууль зүйн тодорхойгүй байдалд хүргэж болзошгүй. Тийм ч учраас энэхүү тайлангийн хүрээнд судлагдсан аль ч улс үндсэн хуулийн шүүхдээ тодорхой орон зай үлдээлгүйгээр энэхүү шийдлийг сонгоогүй. Учир нь нэг бүрчилсэн олон актын үндэслэл болсон чухал норматив актыг хүчингүй болговол тоймгүй үр дагавар учруулж болно. Венецийн комисс нь ***ex tunc* нөлөөлөл бүхий хүчингүй болгох явдлыг томоохон хууль зүйн тодорхойгүй байдалд хүргэж болзошгүй тул уг хэлбэрийг хатуу хэрэглэхийн эсрэг байр суурьтай байна.**²³² Эрх зүйн хийдлээс зайлсхийхийн тулд үндсэн хуулийн шүүх нь үндсэн хуультай нийцээгүй гэж тогтоосон заалтыг хүчингүй болгосон шийдвэрээ тодорхой хугацаагаар хойшлуулах (ихэвчлэн нэг жил хүртэл) бүрэн эрхтэй байж болно. Ингэснээр Үндсэн хуульд нийцээгүй заалтууд хүчин төгөлдөр бус болохоос өмнө парламент шинэ хууль тогтоомжийг шат дараатай боловсруулах боломжтой болно.²³³

3. *Ratione materiae* нөлөө

184. Үндсэн хуулийн шүүх ихэнхдээ хохирол барагдуулах эрхгүй байдаг. Харин үүний оронд үндсэн хуулийн шүүхийн шийдвэр нь ихэвчлэн тухайн хэргийг дахин хэлэлцэхэд хүргэж доод шатны шүүх зохих хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмын дагуу хохирлыг барагдуулах шийдвэр гаргаж болно. Тэгээд ч үндсэн хуулийн шүүхийн хяналтын хүрээ нь зөвхөн үндсэн хуулийн асуудлаар л хязгаарлагдах ёстой.

a. Хохирол ба нөхөн төлбөр

185. Энэхүү тайланд авч үзсэн ихэнх үндсэн хуулийн шүүхүүд нэг бүрчилсэн акт болон норматив актаас болж эрх нь зөрчигдсөн хувь хүний хохирлыг барагдуулах эрх хэмжээгүй байна. Үүнд үл хамаарах улсад Андорра, Чили, Хорват, Монтенегро, Словак, Өмнөд Африк, АНУ багтана. **Үндсэн хуулийн шүүх хүний эрхийн**

²³² Venice Commission, CDL-AD(2018)012, Amicus Curiae Brief for the Constitutional Court of Georgia on the effects of Constitutional Court decisions on final judgments in civil and administrative cases, para. 47; see also Venice Commission, CDL-AD(2008)029, Opinion on the Draft Laws amending and supplementing (1) the Law on Constitutional Proceedings and (2) the Law on the Constitutional Court of Kyrgyzstan, para. 26; see also Venice Commission, CDL-AD(2008)030, Opinion on the Draft Law on the Constitutional Court of Montenegro, para.s 58, 67; Venice Commission, CDLAD(2011)018, Opinion on the draft constitutional law on the constitutional chamber of the Supreme Court of Kyrgyzstan, para. 61.

²³³ Venice Commission, CDL-AD(2018)028, Malta - Opinion on Constitutional arrangements and separation of powers and the independence of the judiciary and law enforcement, para. 78; Venice Commission, CDL-AD(2018)012, Amicus Curiae Brief for the Constitutional Court of Georgia on the effects of Constitutional Court decisions on final judgments in civil and administrative cases, paras. 43; Venice Commission, CDL-AD(2015)024, Opinion on the Draft Institutional Law on the Constitutional Court of Tunisia, para. 11.

зөрчлийг засаж залруулахын тулд эрхийн зөрчлийн нөхөн төлбөр олгохыг өөртөө зөвшөөрөх эсэх нь маргаантай.

186. Үүний оронд үндсэн хуулийн шүүхийн шийдвэр нь ихэвчлэн бие даасан хэргийг (нэг бүрчилсэн актыг эсэргүүцсэн эсхүл "*premium for the catcher*" тохиолдолд) дахин хэлэлцэхэд хүргэдэг. Тухайлбал, Серби, Хойд Македонд хувь хүн хүчингүй болсон норматив актыг үндэслэн эцсийн шийдвэр гаргасан бүхий л хэрэгт хянан шийдвэрлэх ажиллагааг дахин эхлүүлэх хүсэлт гаргаж болох зохицуулалттай. Үүний үндсэнд холбогдох хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмын дагуу доод шатны шүүх хохирол барагдуулах шийдвэр гаргаж болно.

187. Нийтлэг эрх зүйн системтэй улсад хохирол бол гэм хорын эрх зүйн нэг хэсэг; хэрэв нийтийн эрх зүйн этгээд хувь хүний эрхийг зөрчсөн бол тухайн хүн нөхөн төлбөр авах эрхтэй. Төвлөрсөн бус хяналттай улсад хувь хүн ердийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үед тодорхой нөхцөлтэйгөөр хувь хүний эрхийг зөрчих үйлдэл гаргасан төрийн эрх бүхий этгээдийн эсрэг нөхөн төлбөр гаргуулах нэхэмжлэл гаргаж болно. Өмнөд Африкт зөвхөн үндсэн хуулиар олгогдсон эрхийг зөрчсөн тохиолдолд "үндсэн хуулийн хохирол" гэж нэрлэгддэг нөхөн төлбөр авах эрхтэй. Үндсэн хуулийн шүүх нь "зохих хохирол барагдуулах"-аар шүүхийн харьяаллын дагуу уг хохирлыг гаргуулах эрх хэмжээтэй.²³⁴ Кипрт дээд шүүх захиргааны байгууллагаас гаргасан шийдвэрийг хүчингүй болговол захиргааны байгууллага нь хүчингүй болсон шийдвэр гарахаас өмнөх нөхцөл байдлыг сэргээх үүрэгтэй.²³⁵

b. Хяналтын эрх

188. Онолын хувьд үндсэн хуулийн шүүх болон ердийн шүүхийн хоорондох харилцаа нь бүрэн хувь хүний гомдлоос илүү норматив үндсэн хуулийн гомдлын хувьд зөрчил багатай байдаг.²³⁶ Учир нь үндсэн хуулийн шүүх нь ердийн шүүхийн норматив актын хэрэглээг шууд хянадаггүй. Гэхдээ норматив үндсэн хуулийн гомдол гаргах зохицуулалттай улсуудад ч зөрчилдөөн үүсдэг. Венецийн комиссын ажигласнаар "Зарим үндсэн хуулийн шүүх үндсэн хуулийн гомдлыг хянахад ердийн шүүхийн хөндлөнгийн оролцоотой тулгарсан. Ердийн шүүхийн шийдвэрийг хянах нь ердийн шүүх болон Үндсэн хуулийн шүүхийн хооронд

²³⁴ *Fose v Minister of Safety and Security*, CCT14/96, 05/06/1997, ZACC 6, in CODICES.

²³⁵ Киприйн Үндсэн хуулийн 146(5). 146(6) -д заасны дагуу хохирлыг нөхөн төлүүлэх иргэний нэхэмжлэлийг хангахын тулд хохирол нь үйлдэл, шийдвэр, эс үйлдлээс шалтгаалсан байх ёстой.

²³⁶ Sadurski, W. (ed.) *Rights before Courts: A Study of Constitutional Courts in Postcommunist States of Central and Eastern Europe* (2nd ed.) Springer Netherlands, Dordrecht, 2014, p.36

хурцадмал байдал, бүр зөрчилдөөн үүсгэж болзошгүй юм.”²³⁷ **Хурцадмал байдал, эрх мэдлийн зөрчлөөс зайлсхийхийн тулд, Үндсэн хуулийн шүүхийг ердийн шүүхийн хууль хэрэглээнд хөндлөнгөөс оролцож "Дээдийн дээд шүүх" эсхүл "дөрөвдүгээр шатны" шүүхийн үүрэг гүйцэтгэхээс зайлсхийж, зөвхөн үндсэн хуулийн асуудлыг л хэлэлцэж, *ratione materiae* -гаар гомдол хүлээн авах хүрээг хязгаарлаж, өөрийгөө хэт ачаалалтай болгохоос сэргийлэхийг Венецийн Комисс зөвлөж байна.**²³⁸

189. Түүнчлэн үндсэн хуулийн шүүх болон "ердийн" дээд шатны шүүхүүдийн (жишээлбэл, дээд шүүх эсхүл давж заалдах шатны шүүх) харилцааг тодорхой томъёолсон байх ёстой.²³⁹ Үндсэн хуулийн шүүх зөвхөн үндсэн хуулийн асуудлыг авч үзэх ёстой бөгөөд ердийн хуулийн тайлбарыг ердийн шүүхэд үлдээх хэрэгтэй.²⁴⁰ Ердийн шүүхийн процедурын журмыг зөрчсөн зөрчлийг шударга шүүхээр шүүлгэх эрхийн зөрчил гэж үзэж болох тохиолдолд шударга шүүхээр шүүлгэх эрхийн хүрээнд үндсэн хуулийн асуудлыг тодорхойлоход хүндрэлтэй байж болно. Үндсэн хуулийн шүүхийн хувьд дан ганц өөрийн хэт ачааллаас зайлсхийхийн тулд төдийгүй ердийн шүүхийн харьяаллыг хүндэтгэн үзэх үүднээс зарим нэг хязгаарлалтыг өөртөө тавих нь зохистой гэж үзэж байна. Зөвхөн ердийн шүүх илт дур зоргоороо хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зөрчил гаргасан тохиолдолд үндсэн хууль болон шударга шүүхээр шүүлгэх эрхийг зөрчсөн гэж үзвэл зохино.

4. Үндсэн хуулийн шийдвэрийг эцэслэх нь

190. Зарчмын хувьд норматив эсхүл нэг бүрчилсэн акт үндсэн хуульд нийцсэн эсэх тухай үндсэн хуулийн шүүхийн шийдвэр нь эцсийн бөгөөд заавал биелүүлэх шинжтэй байдаг. Өөрөөр хэлбэл, давж заалдах боломжгүй гэсэн үг. Венецийн комиссын ажигласнаар “**Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрийг эцсийнх гэж үзэж, түүний шийдвэрийг хүндэтгэх нь үндсэн хуулийн дэг журам болон хууль зүйн тодорхой байдлын эрх ашигтай нийцэх тул Үндсэн хуулийн шүүхийн дүгнэлтийг хянан гэсэн явдал байхгүй.**”²⁴¹ Түүнээс гадна ижил асуудлаар гаргасан гомдлыг ерөнхийдөө дахин хүлээж авдаггүй. Үндсэн хуулийн шүүхийн тайлбарыг төрийн бүх салбар заавал дагаж мөрддөг тогтолцоонд

²³⁷ Venice Commission, CDL-AD(2004)024, Opinion on the Draft Constitutional Amendments with regard to the Constitutional Court of Turkey, para. 44.

²³⁸ Ibidem; Venice Commission, CDL-AD(2011)040, Opinion on the Law on the Establishment and Rules of Procedure of the Constitutional Court of Turkey, paras. 102-103

²³⁹ Venice Commission, CDL-AD(2004)024, Opinion on the Draft Constitutional Amendments with regard to the Constitutional Court of Turkey, para. 44.

²⁴⁰ Venice Commission, CDL-AD(2009)014, Opinion on the Law on the High Constitutional Court of the Palestinian National Authority, para. 25.

²⁴¹ Venice Commission, CDL-AD(2019)028, Republic of Moldova – Amicus Curiae Brief on the criminal liability of the Constitutional court judges, para. 45.

Венецийн комисс

үндсэн хуулийн шүүх нь үндсэн хуулийн утгыг эцэслэн тодорхойлох эрхийг хадгалдаг.

191. Онцгой тохиолдолд үндсэн хуулийн шүүхийн шийдсэн хэргийг дахин нээж болно. Талуудын мэдээгүй байсан шинэ баримтууд гарч ирсэн,²⁴² үндсэн хуулийн шүүхийн алдааг засах²⁴³ эсхүл үндсэн хууль өөрчлөгдсөн зэрэг нь хэргийг дахин шинээр эхлүүлэх түгээмэл нөхцөл байдал юм.²⁴⁴ Жишээлбэл, АНУ-д Дээд шүүхийн үндсэн хуулийн асуудлаар гаргасан шийдвэр нь бараг эцсийнх бөгөөд үүнийг зөвхөн Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах эсхүл шүүхийн шинэ шийдвэрээр өөрчлөх боломжтой боловч энэ нь маш ховор тохиолддог. Словени болон Хойд Македонид²⁴⁵ завсрын байр суурийг баримталдаг бөгөөд Үндсэн хуулийн шүүх энэ удаад өөр шийдвэр гаргана гэж үзэх үндэслэл байхгүй тохиолдолд хэргийг хүлээж авдаггүй. Хэрэв үндэслэл бүхий эргэлзээ байвал өргөдлийг хүлээн авна. Армен, Турк улсад үндсэн хуультай холбоотой асуудлаар дахин асуудал тавихыг хориглосон нь зөвхөн тодорхой хугацаанд хүчинтэй байдаг.

VIII. ЕВРОПЫН ХҮНИЙ ЭРХИЙН ШҮҮХ

192. Зарчмын хувьд үндсэн хуулийн шүүхийн гаргасан үндсэн хуульд нийцсэн эсэх тухай шийдвэр нь эцсийнх бөгөөд давж заалдах боломжгүй байдаг. Европын хүний эрхийн шүүх нь давж заалдах шатны шүүх биш гэдгийг юун түрүүнд онцлон тэмдэглэх нь зүйтэй. Түүний бүрэн эрх нь хэлэлцэн тохирогч улсууд

²⁴² Жишээ нь, Австрийн Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн 34-р зүйлийг харна уу: "nova pererta" (шинээр илэрсэн нөхцөл байдал)-ийн эсрэгээр "nova producta" – талууд өмнө нь мэдэж болох байсан нөхцөл байдлын талаар анхан шатны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дууссаны дараа ерөнхийдөө аргумент гаргаж болдоггүй.

²⁴³ АНУ-ын Дээд шүүхийн дүрмийн 44-ийг үзнэ үү: "1. Шүүх, шүүгч уг хугацааг богиносгож, эсхүл сунгаагүй бол шүүхийн аливаа тогтоол, шийдвэрийг дахин хэлэлцүүлэх тухай гомдлыг шийдвэр гарснаас хойш 25 хоногийн дотор гаргана." Мөн Швейцарын Холбооны дээд шүүхийн хуулийн 121-ийг харна уу: "Холбооны шүүхийн шийдвэрт дараах тохиолдолд өөрчлөлт оруулах хүсэлт гаргаж болно: а. хэрэв шүүх бүрэлдэхүүн, эсхүл тэдгээрийг татгалзахтай холбоотой заалтыг дагаж мөрдөөгүй бол; б. хэрэв шүүх аль нэг талд илүү, эсхүл хуулиар зөвшөөрөөгүй, асууснаас өөр зүйл, эсхүл эсрэг талын мэдэхийг хүссэн зүйлээс бага зүйл шийдсэн; в. шүүх тодорхой дүгнэлт гаргаагүй бол; г. шүүх санамсаргүйгээр хэргийн материал дахь холбогдох нотлох баримтыг харгалзан үзээгүй бол".

²⁴⁴ Арменийн Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн 68 дугаар зүйлийн 16-18:

"(16). Үндсэн хуулийн шүүх энэ зүйлийн 9 дэх хэсгийн 1, 2 дахь хэсэгт заасан шийдвэрийг энэ хуульд заасан журмын дагуу хянан үзэж болно: 1/ тухайн хэрэгт хэрэглэсэн Үндсэн хуулийн заалт өөрчлөгдсөн, эсхүл 2/ тухайн асуудалд хэрэглэсэн Үндсэн хуулийн заалтын талаарх шинэ ойлголт үүссэн, үүний улмаас тухайн асуудлаар Үндсэн хуулийн шүүх өөр шийдвэр гаргах боломжтой, энэ асуудал нь үндсэн хуулийн эрх зүйн ач холбогдолтой бол.

(17). Энэ зүйлийн 16 дахь хэсэгт заасан үндэслэлээр хэргийг хянан шийдвэрлэх тухай Үндсэн хуулийн шүүхийн хянан шийдвэрлэх ажиллагааг нийт шүүгчийн гуравны хоёроос доошгүй саналаар гаргана.

(18). Энэ хуулийн 16 дахь хэсэгт заасан үндэслэлээр үндсэн хуулийн шүүхийн шийдвэрийг хянаж гэж байгаа тохиолдолд энэ хуулийн 29 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалтыг үндэслэн татгалзах боломжгүй."

²⁴⁵ Үндсэн хуулийн шүүхийн дэгийн 28 дугаар зүйлийг үзнэ үү.

конвенцод нэгдсэнээр хүний эрхтэй холбоотой үүргээ биелүүлж байгаа эсэхийг шалгах хүрээнд хязгаарлагддаг.

193. Гэсэн хэдий ч дотоодын түвшинд хувь хүн үндсэн хуулийн хяналтад хамрагдах боломжид наад зах нь гурван янзаар нөлөөлж ирсэн. Нэгдүгээрт, зарим улсын шүүхүүд үндсэн хуульд заасан эрхийг Европын хүний эрхийн конвенцод нийцүүлэн тайлбарлах ёстой байдаг. Хоёрдугаарт, Европийн Хүний Эрхийн Шүүх (ЕХЭШ)-ийг үндсэн хуулиар хамгаалагдсан эрхийг Конвенцод заасан эрхүүдтэй давхцах хэмжээгээр үр дүнтэй хамгаалдаг гэж ойлгож болно. Гуравдугаарт, ЕХЭШ нь Европын хүний эрхийн конвенцын 6-р зүйлд заасны дагуу үндсэн хуулийн хяналтын үйл ажиллагаа нь шударга шүүхээр шүүлгэх шаардлагыг бүрэн хангах баталгаа болдог.

А. Конвенцод нийцүүлэн тайлбарлах

194. Дотоодын шүүхүүд нь үндсэн хуулиар хамгаалагдсан эрхийг Европын хүний эрхийн конвенцод нийцүүлэн тайлбарлах үүрэгтэй, эсхүл ингэх тусгай үүрэг хүлээгээгүй ч тайлбарладаг улсад ЕХЭШ-ийн прецедентүүд (case-law) хувь хүн өөрсдийн улсын үндсэн хуулийн дагуу гомдол гаргаж болох материаллаг эрхэд нөлөөлнө.

195. Жишээлбэл, Германд Европын конвенц, түүний протоколууд нь Германы холбооны хуулийн (*Gesetzesrang*) статустай байдаг. Германы шүүхүүд дотоодын хуулийг тайлбарлахдаа тус конвенцыг дагаж хэрэглэх ёстой. Үндсэн хуулийн эрх зүйн түвшинд Конвенц болон Европын хүний эрхийн шүүхийн прецедент нь Суурь хуулийн дагуу хувь хүний үндсэн эрхийн хамгаалалтыг хязгаарлах буюу багасгахгүй байх хэмжээнд Суурь хуулийн үндсэн хуулийн зарчим болон үндсэн эрхийн агуулга, хүрээг тодорхойлох, тайлбарлахад туслах үүрэгтэй.²⁴⁶

В. Үндсэн хуулийн хяналтыг ЕХЭШ-ээр орлуулах нь

196. Дотоодын үндсэн хуулиар хамгаалагдсан эрхийн ихэнх нь Европын хүний эрхийн конвенцоор хамгаалсан эрхтэй давхцадаг. Иймээс эдгээр эрхийн хувьд ЕХЭШ-ийг үндсэн хуулийн хяналтын өөр нэг үр дүнтэй хувилбар буюу нэмэлт арга зам гэж үзэж болох юм. Тус Конвенцын туслах чанарын механизмыг харгалзан үзвэл тухайн хувь хүн ЕХЭШ-д өргөдөл гаргахаасаа өмнө дотоодын шүүхээр эрхээ хамгаалуулах бүх механизмыг ашиглаж дууссан байх ёстой. Түүнээс гадна эдгээр хамгаалалтууд нь зөрчигдсөн эрхийг сэргээх үр дүнтэй механизм байвал зохино. Практикт, зөвхөн үндсэн хуулийн иж бүрэн гомдол л үр дүнтэй эрхийн хамгаалалт болж чадна. ЕХЭШ нь гишүүн орнуудыг ерөнхийдөө үр

²⁴⁶ BVerfGE 111, 307, 14 October 2004, 2 BvR 1481/01.

Венецийн комисс

дүнтэй эрхийн хамгаалалтын арга хэмжээ авах, ялангуяа үндсэн хуулийн иж бүрэн гомдол гаргах боломжийг өргөжүүлэхэд хүргэсэн.

197. Үүний зэрэгцээ үндсэн хуулийн иж бүрэн гомдол нь үндэсний хэмжээнд "шүүлтүүр"-ийн үүрэг гүйцэтгэж ЕХЭШ-д хүрэх хэргийн тоог хязгаарладаг. Энэ нь ЕХЭШ-ийн өндөр ачааллын зүгээс үр дүнтэй бөгөөд хүний эрхийн асуудлыг үндэсний хэмжээнд шийдвэрлэхийг илүүд авч үзэхэд онцгой ач холбогдолтой юм.

1. Эрх зүйн хамгаалалтыг бүгдийг хэрэглэх

198. ЕХЭШ-ийн бүрэн эрх нь "субсидиар" зарчмаар хязгаарлагддаг. Өөрөөр хэлбэл, дотоодын эрх зүйн системийн бүх үе шатыг дуусгасны дараа л маргаантай актыг шийдвэрлэж болно гэсэн үг. Тус конвенцын механизмын туслах шинж чанарыг зохицуулсан Интерлакены тунхаглалд:

"4. Конвенцыг хэрэглэх, хэрэгжүүлэхийг баталгаажуулах нь оролцогч улсуудын нэн тэргүүний үүрэг гэдгийг бага хурал тэмдэглэж, улмаар оролцогч улсуудад дараах үүрэг харцуцлага хүлээхийг дурдаж байна:

d) конвенцод заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж маргах боломжтой аливаа этгээдэд зохих эрх зүйн хамгаалалт үзүүлэх үндэсний байгууллагын өмнө хохирлоо үр дүнтэй барагдуулах боломж олгох тусгай шинж чанарын эсхүл ерөнхий дотоодын ч байж болох шинэ хамгааллын тогтолцоог шаардлагатай бол бий болгон, баталгаажуулна;..."²⁴⁷

199. Түүнчлэн Европын хүний эрхийн конвенцод нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 15 дугаар Протоколд (одоохондоо хүчин төгөлдөр болоогүй) конвенцын оршил хэсгийн 1 дүгээр зүйлд заасан субсидиар зарчмыг дурдсан: "Хэлэлцэн тохирогч талууд субсидиар зарчмын дагуу энэхүү конвенц болон түүний Протоколд тодорхойлсон эрх, эрх чөлөөг хангах үндсэн үүрэгтэй бөгөөд ингэснээрээ энэхүү Конвенцоор байгуулсан Европын шүүхийн харьяаллын хүрээнд өөрсдийн үзэмжээр шийдвэрлэх эрх эдэлнэ".

200. Иймд хүний эрхийн зөрчлийн талаар хувь хүний гомдлыг үндсэн хуулийн шүүхэд гаргахтай холбоотой нэг чухал асуулт нь Европын хүний эрхийн шүүхэд хувь хүн давж заалдахаас өмнө Европын хүний эрхийн конвенцын 35.1-д заасны дагуу эхлээд бүхий л дотоодын эрх зүйн хамгаалалтад хандсан байх тухай явдал юм.

²⁴⁷ Европын зөвлөлийн сайд нарын хорооны Швейцар тэргүүний санаачилгаар 2010 оны 2-р сарын 18-19-ний өдрүүдэд Интерлакен хотноо болсон Дээд түвшний бага хурлын уулзалт.

2. Үр дүнтэй хамгаалуулах эрх: үндсэн хуулийн иж бүрэн гомдол

201. Европын хүний эрхийн конвенцын 35.1-д заасны дагуу эрх зүйн бүх боломж дууссан гэж үзэхийн тулд тус конвенцын 13 дугаар зүйлд заасны дагуу тэдгээр үндэсний эрх зүйн хамгаалал үр дүнтэй байх шаардлагатай. Гэвч эрх зүйн хамгааллыг үр дүнтэй байлгахын тулд иргэний өргөдлийг хэрхэн яаж гаргах вэ гэдэг нь төвөгтэй асуудал юм. Ерөнхийдөө, ЕХЭШ үндсэн хуулийн шүүх хангалттай эрх мэдэлтэй байж, зөрчигдсөн эрхийг сэргээж чаддаг л бол үндсэн хуулийн гомдлыг “эрх зүйн үр дүнтэй хамгаалал” болно гэж үздэг.²⁴⁸

202. Хариулт улс орон бүрээр харилцан адилгүй байна. Аливаа тухайлсан улсын хувьд үндсэн хуулийн гомдол нь конвенцын зарим зөрчлийн хувьд үр дүнтэй хамгаалах арга байж болох ч ЕХЭШ-ийн прецедентээс үзвэл бусад зөрчлийн хувьд төдийлөн үр дүнтэй байдаггүй байна. Ялангуяа, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа хэт сунжирсан байж болох хэргүүд болон “бусад” хүний эрхийн зөрчлүүдийг хооронд нь ялгах шаардлагатай юм.

203. Конвенцын 13 дугаар зүйлийн хүрээнд аливаа хамгаалал нь үр дүнтэй эсэхийг тодорхойлохдоо олон янзын элементүүдийг харгалзан үзэх шаардлагатай. Хэрэв хувь хүн Конвенцод заасан эрх зөрчигдсөний улмаас хохирсон гэж маргах гомдолтой бол үндэсний эрх бүхий байгууллагад хандах боломжтой байх ёстой. Уг эрх бүхий байгууллага нь заавал шүүх байгууллага байх албагүй ч гаргасан нэхэмжлэлийг шийдвэрлэх, зөрчигдсөн эрхийг нөхөн сэргээх эрхтэй байх ёстой.²⁴⁹ Хэлэлцэн тохирогч улсууд өөрсдийн санал болгож буй хамгааллын аргаа чөлөөтэй сонгох боломжтой ба зарим тохиолдолд хэд хэдэн хамгаалах арга хэмжээний цогц хамгаалал ч байж болно.²⁵⁰

204. Үндсэн хуулийн шүүхэд иргэний өргөдөл гаргасан тохиолдолд тухайн байгууллагын шүүхийн шинж чанарыг хэлэлцэх шаардлагагүй юм. Гэвч хэргийн тохиолдол бүрд үндсэн хуулийн шүүхийн бүрэн эрх хангалттай байх уу гэсэн асуулт гарч болно. Шүүх тухайн хэрэгт заавал биелүүлэх шийдвэр гаргах замаар зөрчигдсөн эрхийг нөхөн сэргээж, хохиролгүй болгох эрхтэй байх ёстой. Үндсэн хууль зөрчсөн тухай тунхаглалын шинжтэй шийдвэр хангалтгүй бөгөөд гомдол нь практикт төдийгүй эрх зүйн хувьд “үр дүнтэй” байх ёстой.²⁵¹ Хэрэв конвенцын эрх болон Үндсэн хуулийг зөрчсөн нь эерэг нөлөөлөл бүхий үүрэгтэй холбоотой

²⁴⁸ Venice Commission, CDL-AD(2014)026, Opinion on the Seven Amendments to the Constitution of “The former Yugoslav Republic of Macedonia” concerning, in particular, the Judicial Council, the Competence of the Constitutional Court and Special Financial Zones, paras. 87-89.

²⁴⁹ Тухайн хувь хүн дотоодын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад Конвенцод заасан эрх зөрчигдсөн талаар гомдол гаргах ёстой. Хэрэв тэгэхгүй бол Европын хүний эрхийн шүүх дотоодын шүүхээр эрхээ хамгаалуулах арга замуудаа дуусаагүй байна гэсэн дүгнэлтэд хүрнэ. Жишээ нь дараахыг харна уу: ECtHR, Debono v. Malta, 10.06.2004, no. 34539/02).

²⁵⁰ ECtHR, Silver v. UK, 25.03.1983, nos. 5947/72 болон бусад жишээг харна уу.

²⁵¹ ECtHR, lhan v. Turkey [GC], 27.06.2000, no. 22277/93, para. 58.

Венецийн комисс

бол шүүх төрийн эрх бүхий байгууллагад тухайн хэргийн хувьд биелүүлээгүй арга хэмжээгээ авч хэрэгжүүлэхийг үүрэг болгож болно. Шүүх хэргийг хянан хэлэлцэх, эсхүл наад зах нь гаргасан гомдлыг хүлээн авч хянан үзэх үүрэгтэй байх ёстой. Шүүх нь мөн хандах боломжтой байх ёстой: жишээ нь, зардал, эсхүл төлөөлөлтэй холбоотой зохих ёсны бус шаардлага нь гомдлыг "үр дүнгүй" болгож болзошгүй. Авсан арга хэмжээний үр дагаврыг буцаах боломжгүй үед үндсэн хуулийн шүүх эдгээр арга хэмжээг авч хэрэгжүүлэхээс урьдчилан сэргийлэх боломжтой байх ёстой.²⁵²

205. "Хянан шийдвэрлэх ажиллагаа хэт сунжрахтай холбоотой үндэсний хамгааллын үр дүнтэй байдлын тухай" тайлангийн хүрээнд²⁵³ Венецийн комисс үндсэн хуулийн гомдлын хамгааллын үр нөлөөний талаар хэлэлцсэн. Европын хүний эрхийн шүүхийн прецедентэд (case-law)²⁵⁴ үндэслэн Комисс "шүүхийн тогтолцоогоо Конвенцын 6.1-д заасан шаардлагад нийцсэн байдлаар зохион байгуулах үүрэг нь Үндсэн хуулийн шүүхэд мөн хамаарна" гэж үзсэн.²⁵⁵ Энэ нь хэрэв тухайн улс иргэний өргөдөл гаргах процессыг үндсэн хуулийн шүүхэд нэвтрүүлэх гэж байгаа бол энэ нь хянан шийдвэрлэх ажиллагааны нийт хугацааг хэт уртасгахгүй байх замаар хийх ёстой гэсэн үг юм. Улмаар, шүүх нэмэлт хэргийн ачааллыг үр дүнтэй шийдвэрлэх чадамж, нөөцтэй байх ёстой.²⁵⁶

206. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа хэт сунжрахтай холбоотой хэлэлцэх гол асуудал бол жишээ нь, тухайн хянан хэлэлцэгдэж буй хэргийг дуусгах нь эерэг үр нөлөөтэй байх тэдгээр арга хэмжээг түргэсгэх болон нөхөн олговор олгох арга хэмжээ хоёрын хоорондын ялгааг ялгах явдал юм. Тэрээр Венецийн Комисс "[Страсбургийн] шүүхийн прецедентийн (case-law) хувьд энэ нь 13-р зүйлд шаардсан үр дүнг гаргах үүрэг юм. Хэдийгээр эрхийг хамгаалах арга хэрэгслүүдийн аль нь ч хувь хүнд дангаар нь хэрэглэхэд 13 дугаар зүйлийн шаардлагыг хангахгүй бол дотоодын хууль тогтоомжоор олгосон эрхийг хамгаалах арга хэрэгслийн нийлбэрүүдийг энэ зүйлийн хүрээнд "үр дүнтэй" хэмээн тооцож болно хэмээн

²⁵² ECtHR, *Conka v. Belgium*, 05.02.2002, no.51564/99, para. 79.

²⁵³ Venice Commission, CDL-AD(2006)036rev, Report on the "Effectiveness of National Remedies in Respect of Excessively Lengthy Proceedings".

²⁵⁴ ECtHR, *Gast and Popp v. Germany*, 25.02.2000, no. 29357/95, para. 75.

²⁵⁵ Venice Commission, CDL-AD(2006)036rev, Report on the "Effectiveness of National Remedies in Respect of Excessively Lengthy Proceedings", para. 33.

²⁵⁶ Concerning doubts on the promptness of an individual complaint see ECtHR, *Belinger v. Slovenia*, 02.10.2001, no. 42320/98.

үзсэн байна.²⁵⁷ Аливаа эрхийн хамгааллын арга зам үр дүнтэй байхын тулд түргэсгэдэг²⁵⁸ болон нөхөн олговортой байх ёстой гэж Комисс үзэж байна²⁵⁹

“182. Дотоодын эрх зүйн тогтолцоонд нь хурдасгах арга зам байхгүй тохиолдолд (ихэнх дотоодын хууль эрх зүйн тогтолцоонд байдаггүй) тухайн хүн Страсбурггаас тогтоолгож болох нөхөн олговортой тэнцэх хэмжээний олговрыг өөрийн эрх бүхий байгууллагаас тогтоолгодоггүй, учир нь тэнд субсидиар зарчим хангалтгүй байна. Ийм нөхцөлд тухайн хүн дотоодын журмаар (зөвхөн) мөнгөн нөхөн олговор авсны дараа ч хохирогчийн статусаа алдаагүй гэж маргаж болох бөгөөд тухайн хүн дотоодын эрх зүйн хамгаалалтаа дуусгахаар нэхэмжлэл гаргаж болно.183. Эцэст нь Венецийн Комисс конвенцын 6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан хангалттай хугацааны шаардлагыг Конвенцын 13 дугаар зүйлд заасан шаардлагатай нийцүүлэн биелүүлэхийн тулд Европын зөвлөлийн гишүүн орнууд дараах шаардлагыг хангах ёстой гэж үзэж байна. Эхний ээлжид хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дуусгавар болох хүртэл ямар ч үед (цаашид) хэтэрхий удахаас урьдчилан сэргийлэх зорилготой хурдасгах хамгааллын аргатай болох.

184. Түүнчлэн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад (үр дүнтэй хурдасгах аргыг нэвтрүүлэхээс өмнө) тохиолдсон байж болох зохих хугацааны шаардлагыг зөрчсөн тохиолдолд нөхөн олговор олгох ёстой.”²⁶⁰

²⁵⁷ Venice Commission, CDL-AD(2006)036rev, Report on the “Effectiveness of National Remedies in Respect of Excessively Lengthy Proceedings”, para. 135.

²⁵⁸ ECtHR, Slavicek v. Croatia, 04.07.2002, no. 20862/02: “Шинэ хуулийн дагуу иргэний эрх, үүргийг нь тогтоох, түүнд холбогдох эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа зохих хугацаанд дуусаагүй гэж үзсэн хүн бүр үндсэн хуулийн гомдол гаргаж болно. Үндсэн хуулийн шүүх уг гомдлыг хянан үзэж, үндэслэлтэй гэж үзвэл уг хэргийг маргааны зүйлийн хувьд шийдвэрлэх хугацаа тогтоож, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа хэт уртассаны нөхөн олговор олгох шийдвэр гаргах ёстой. Энэ нь Конвенцын 35.1 дэх хэсгийн шаардлагыг хангахын тулд өргөдөл гаргагчийн шүүхээр эрхээ хамгаалуулах арга хэрэгслээ дуусгах ёстой арга гэж шүүх үзэж байна. See also ECtHR, Debono v. Malta, 10.06.2004, no. 34539/02; ECtHR, Andrásik v. Slovakia, 22.10.2002, no. 57984/00 and ECtHR, Fernandez-Molina Gonzalez and others v. Spain, 08.10.2002, no. 64359/01.

²⁵⁹ Нөхөн олговор нь өргөдөл гаргагчийн Страсбургийн шүүхээс авах байсан хэмжээтэй зохих ёсоор уялдаатай байх ёстой (see ECtHR, Dubjakova v. Slovakia, 10.10.2004, no. 67299/01: “Шийдвэрээр тогтоосон нөхөн олговрын хэмжээ зохих хэмжээний гэж тооцогдож болох ч, тийнхүү тооцоолохдоо хэргийн бүхий л нөхцөл байдлыг үнэлэх ёстой. Үүнд зөвхөн тухайн хэргийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны сунжирсан хугацаа төдийгүй тухайн улсын амьжиргааны түвшин, үндэсний тогтолцооны дагуу нөхөн олговрыг ерөнхийд нь олгохоор шийдвэрлэх бөгөөд мөн хэрэв хэргийг Конвенцын 41 дүгээр зүйлд заасны дагуу [Страсбургийн] шүүх шийдвэрлэх байсан тохиолдолд нөхөн олговрыг олгох байсан хугацаанаас илүү хурдан олгох нөхцөлийг үндэслэн.”)

²⁶⁰ Venice Commission, CDL-AD(2006)036rev, Report on the “Effectiveness of National Remedies in respect of Excessively Lengthy Proceedings”, paras. 182-184.

207. Үндэсний түвшинд хүний эрх зөрчигдөхийн эсрэг хангалттай хамгаалалт бий болгохын тулд **Венецийн Комиссоос үндсэн хуулийн иж бүрэн гомдлыг хараахан нэвтрүүлээгүй байгаа тохиолдолд тийнхүү нэвтрүүлэхийг зөвлөж байна.**²⁶¹

208. Хэрэв тухайн улс үндэсний эрх зүйн хамгаалал бий болгох, эсхүл ЕХЭШ-д хандах хэргүүдийн шүүлтүүрийг хангах зорилгоор үндсэн хуулийн шүүхэд хувь хүний гомдлын журмыг нэвтрүүлэх гэж байгаа бол (Европын хүний эрхийн конвенцын 13 дугаар зүйлийн агуулгаар үр дүнтэй хамгаалал бий болгох үүднээс уг конвенцын 35.1-д заасны дагуу [ердийн шүүхээр эрхээ хамгаалуулах бүх арга замыг] ашиглаж дуусгасан байхыг шаарддаг) тус журам нь заавал биелүүлэх шийдвэрээр зөрчигдсөн эрхийг нөхөн сэргээдэг байх ёстой. Үндсэн хуулийн шүүх уг хэргийг хянан шийдвэрлэх үүрэгтэй бөгөөд зардал, төлөөлөлтэй холбоотой зохих ёсны бус шаардлага тавьж болохгүй.

209. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа хэт удаан үргэлжилсэн гэж үзсэн тохиолдолд үндсэн хуулийн шүүхэд хандсан хувь хүний гомдол нь ердийн шүүх дээр уг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг яаралтай сэргээх, дуусгавар болгох эсхүл уг асуудлыг үндсэн хуулийн шүүх өөрөө шийдвэрлэх боломжтой болгох ёстой. Энэ төрлийн тохиолдлуудад үндсэн хуулийн шүүх нь өргөдөл гаргагч ЕХЭШ-д гомдол гарган тогтоолгон авах дүнтэй тэнцэх хэмжээний нөхөх олговор тогтоох боломжтой байх ёстой.²⁶²

3. Үндсэн хуулийн иж бүрэн гомдлыг дотоодын “шүүлтүүр” болгох нь

210. Европын Зөвлөлийн гишүүн орнуудын ихэнх үндсэн хуулийн шүүхүүдэд нэг бүрчилсэн актыг хувь хүн эсэргүүцэж иж бүрэн гомдол гаргах механизм байдаг. Конвенцоор хамгаалагдсан зөрчигдсөн эрхийг сэргээх цорын ганц үр дүнтэй арга болох үндсэн хуулийн иж бүрэн гомдол нь дотооддоо зөрчлийг хянан шийдвэрлэх замаар Европын хүний эрхийн шүүхэд хандах хэргүүдийн тоог багасгах буюу шүүлтүүрийн үүрэг гүйцэтгэдэг.²⁶³ Үүнтэй зэрэгцээ тогтолцоог Латин Америкийн орнуудын Америк хоорондын хүний эрхийн шүүхээс харж болно.

211. Үндсэн хуулийн дагнасан шүүхтэй улсуудад тус шүүхэд хувь хүний гомдол гаргах нь эрхээ хамгаалуулах логиктой сонголт байх болно. Учир нь хувь хүний гомдол нь үндэсний хэмжээнд нэмэлт шинж чанартайн дээр ийм гомдлыг гагцхүү ердийн шүүхэд давж заалдах шатыг дууссаны дараа гаргадаг. Европын

²⁶¹ Venice Commission, CDL-AD(2013)034, Opinion on Proposals Amending the Draft Law on the Amendments to the Constitution to strengthen the independence of judges of Ukraine, para. 11.

²⁶² See ECtHR, *Cocchiarella v. Italy* [GC], 29.03.2006, no. 64886/01, paras. 76-80 and 93 to 97.

²⁶³ See Stone-Sweet, A. and Keller, H. (Eds.), *A Europe of Rights: The Impact of the ECHR on National Legal Systems*, Oxford University Press, 2008, ch. 10.

хүний эрхийн шүүхэд хандахаас өмнө үндэсний хэмжээнд авах боломжтой бүхий л эрх зүйн хамгаалалтыг хэрэглэх нь чухал.

212. *Actio popularis* болон норматив гомдол нь үр дүнтэй “дотоодын хамгаалалт” болж чадахгүй. *Actio popularis* нь хэм хэмжээг абстрактаар буюу хийсвэрлэн хянахад чиглэгддэг ба хүний эрхийн тодорхой зөрчлийн эсрэг зохих арга хэрэгсэл байж чаддаггүй. Үүний нэгэн адил, тодорхой тохиолдол дахь норматив актын хэрэглээнд бус харин зөвхөн тухайн норматив актын эсрэг чиглэсэн хувь хүний норматив гомдол ихэнх хэрэгт үр дүнтэй хамгааллын арга хэмжээ болж чадахгүй.²⁶⁴

213. Европын хүний эрхийн шүүхэд Турктэй холбоотой хэргүүд хэт их ачаалал өгч байсантай холбогдуулан Турк улс хувь хүн иж бүрэн гомдол гаргах боломжийг нэвтрүүлснээр сонирхолтой жишээ болсон. Европын хүний эрхийн шүүхэд Турктэй холбоотой олон хэрэг очиж байгааг харгалзан Туркийн Үндсэн хуулийн шүүх 2004 онд Европын хүний эрхийн конвенцод тусгагдсан үндсэн хуулиар хамгаалагдсан эрхтэй холбоотойгоор тус шүүхэд хувь хүн гомдол гаргах боломжтой болгох санал гаргасан. Эдгээр нэмэлт, өөрчлөлтийн талаарх тайлбар санамж бичигт “үндсэн хуулийн гомдол гаргах боломжийг нэвтрүүлснээр Европын хүний эрхийн шүүх дэх Туркийн эсрэг гаргасан хэргийн тоо мэдэгдэхүйц багасна” гэж тодорхой заасан байдаг. Туркийн Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт оруулсан 148 дугаар зүйлд Европын хүний эрхийн конвенцоор хамгаалагдаж, Үндсэн хуулиар баталгаажсан үндсэн эрх, эрх чөлөөг төрийн эрх бүхий байгууллага зөрчиж байна гэж үзэж байгаа аливаа хүн Үндсэн хуулийн шүүхэд хандаж болно гэж заасан. Гэхдээ гагцхүү ердийн захиргааны болон шүүхийн эрх зүйн хамгаалалтыг бүгдийг хэрэглэж дуусгасны дараа л дээрх журмаар гомдол гаргах боломжтой юм.²⁶⁵ 2013 онд *Hasan Uzun v. Turkey* хэрэгт ЕХЭШ дараах зүйлийг тогтоосон:

²⁶⁴ Тухайлбал, Унгар улсын хувьд Европын хүний эрхийн шүүхэд гомдол гаргахад заавал өмнө нь үндсэн хуулийн шүүхэд өргөдөл гаргах шаардлагагүй гэж мэдэгдсэн, ECtHR, *Weller v. Hungary*, 30.06.2009, no. 44399/05. Гэсэн хэдий ч Европын хүний эрхийн шүүх Унгарын Э. Мендрей хэрэгт, “учирсан хохирлыг ямар нэгэн нэмэлт нөхөн олговоргүйгээр зөвхөн актыг хүчингүй болгох замаар хохирлыг барагдуулах боломжтой гэж үзсэн тохиолдолд хувь хүний норматив гомдол нь үр дүнтэй хамгааллын арга зам гэж үзэж болно” хэмээн үзсэн (ECtHR, *Mendrei v. Hungary*, 05.07.2018, no. 54927/15, para 42). Энэ хэрэг дээр нэг багш өөрийгөө *ipso iure* (хуулийн дагуу) Багш нарын танхимын гишүүн болсон гэж гомдоллосон. Норматив гомдол нь тухайн хуулийн *ipso iure* үр дагавар болсон маргаантай заалтуудыг хуулиас хассанаар гишүүнчлэл цуцлагдах боломжтой тул үр дүнтэй хамгааллын арга хэмжээ болсон.

²⁶⁵ Үндсэн хуулийн иж бүрэн гомдлын талаарх Венецийн Комиссын дараах дүгнэлтийг харна уу: Venice Commission, CDL-AD(2011)040, Opinion on the law on the establishment and rules of procedure of the Constitutional Court of Turkey, para. 76; Мөн түүнчлэн дараахыг харна уу: Council of Europe, Supporting the Individual Application to the Constitutional Court in Turkey, Needs Assessment Report on the Individual Application to the Constitutional Court of Turkey.

субсидиар зарчмын дагуу дотоодын эрх зүйн боломжит хамгаалалтыг дуусгасан өргөдөл гаргагчийн гаргасан аливаа гомдлын тухайд тус шүүх тухайн гомдлыг эцэслэн хянан шийдвэрлэх бүрэн эрхтэй ба, Үндсэн хуулийн шүүхийн жишгийн эрх зүйтэй нийцэж байгаа эсэхийг шалгах эрхтэй. Тиймээс энэхүү шийдвэр нь маргаантай байгаа эрх зүйн хамгааллын үр дүнтэй байдлын тухай шийдвэр биш юм. Хариуцагч болох Засгийн газар тухайн эрх зүйн хамгаалалтыг онолын хувьд ч, практикийн хувьд ч үр дүнтэй гэдгийг нотлох шаардлагатай."²⁶⁶

214. 2014 оны *Koçintar v. Turkey* ²⁶⁷ хэрэгт, Европын хүний эрхийн шүүх Туркийн Үндсэн хуулийн шүүхэд хувь хүн гомдол гаргах нь эрх чөлөөгөө хасуулсан хүмүүсийн гомдлыг шийдвэрлэх үндсэн хуулийн үр дүнтэй хамгааллын арга гэж хүлээн зөвшөөрсөн. 2018 онд *Mehmet Hasan Altan v. Turkey* ²⁶⁸ хэргийн тухайд ноён Алтанг Үндсэн хуулийн шүүхэд хандсаных дараа ч үргэлжлүүлэн баривчлан саатуулсан нь шүүх хуралдааны өмнөх баривчлан саатуулахтай холбоотойгоор Үндсэн хуулийн шүүхэд хувь хүний өргөдөл гаргахын үр нөлөөнд ноцтой эргэлзээ төрүүлж байна гэж үзсэн. Гэвч ЕХЭШ *Koçintar v. Turkey* хэргийн дүгнэлтээсээ буцаагүй. ЕХЭК-ийн 5-р зүйлд (Эрх чөлөө, аюулгүй байдлын эрх) заасан хэргүүдэд, ялангуяа цаашдаа Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрийн эрх бүхий этгээдтэй холбоотой анхан шатны шүүх, тэр дундаа эрүүгийн шүүхийн жишгийн эрх зүйг хөгжүүлэх талыг харгалзан хувь хүний гомдол гаргах системийн үр дүнтэй байдлыг шалгах эрхтэй гэдгээ мэдэгдэв.²⁶⁹

215. Турк улсад (2004, 2011 онд) хувь хүний гомдлыг нэвтрүүлсэн нэмэлт, өөрчлөлтийн төслийн талаар Венецийн комисс гаргасан саналдаа эдгээр нь "үндэслэлтэй бөгөөд Европын бусад улсад аль хэдийн мэдэх шийдлийг дагасан байх ба Европын стандартад нийцжээ" гэж үзсэн.²⁷⁰ Тийм ч учраас Венецийн комисс нь Үндсэн хуулийн шүүхэд үндсэн хуулийн иж бүрэн гомдол гаргах арга замыг ЕХЭШ-д хандахаас өмнөх дотоодын шүүлтүүр болж чадна гэж хүлээн

²⁶⁶ ECtHR, *Hasan Uzun v. Turkey*, 30.04.2013, no. 10755/13, para. 71.

²⁶⁷ ECtHR, *Koçintar v. Turkey*, 01.07.2014, no. 77429/12.

²⁶⁸ ECtHR, *Mehmet Hasan Altan v. Turkey*, 20.02.2018, no. 13237/17.

²⁶⁹ *Ibidem*, para. 142.

²⁷⁰ Venice Commission, [CDL-AD\(2004\)024](#), Opinion on the Draft Constitutional Amendments with Regard to the Constitutional Court of Turkey, p. 9. Венецийн комиссоос хувь хүний гомдол нь зөвхөн Конвенцод ч мөн адил туссан үндсэн хуулийн эрхийн асуудлаар хязгаарлагдах эсэх талаар асуулт дэвшүүлсэн. (Venice Commission, [CDL-AD\(2004\)024](#), Opinion on the Draft Constitutional Amendments with Regard to the Constitutional Court of Turkey, para. 36; Venice Commission, [CDL-AD\(2011\)040](#), Opinion on the law on the establishment and rules of procedure of the Constitutional Court of Turkey, para. 9) Энэхүү хязгаарлалтын зорилго нь нийгмийн эрхийг хувь хүний гомдлын хамрах хүрээнээс хасах зорилготой мэт санагдсан. Нийгмийн эрхийг үндэслэхээс цааргалсан нь мөн яагаад Австрийн Үндсэн хуульд "bill of rights"-ийг бүрэн тусгаагүй бөгөөд яагаад үүний оронд Конвенцыг үндсэн хуулийн эрх зүйн түвшинд соёрхон батлах болсон шалтгаан болсон мэт санагдсан.

зөвшөөрсөн.²⁷¹ Үүнийг тухайлбал, яагаад Герман эсхүл Испанийн эсрэг гарч буй өргөдлийн тоо Францын эсрэг гаргасан өргөдлийн тооноос бага болохыг тайлбарлах замаар олон судалгаагаар баталсан.²⁷²

216. Үндсэн хуулийн иж бүрэн гомдол нь үндсэн хуульд заасан эрхийн иж бүрэн хамгаалалт болж байгаагаас гадна Европын хүний эрхийн шүүхийн эрх зүйн хамгаалалтын субсидиар шинж чанар болон хүний эрхийн асуудлыг үндэсний хэмжээнд шийдвэрлэх зорилгын улмаас Венецийн комисс нь үндсэн хуулийн иж бүрэн гомдол гаргах арга замыг дэмжиж байна. Шүүхийн хэт ачааллын асуудал (2020 оны 6 дугаар сарын байдлаар 59,800 гаруй өргөдөл хүлээгдэж ²⁷³ байгаа) болон ЕХЭШ-д хандахаас өмнө дотоодын хэмжээнд хүний эрхийн асуудлыг шийдвэрлэх шаардлагатай байгаа тул энэ сэдвийг хэлэлцэх нь онцгой ач холбогдолтой юм.

4. Үндсэн хуулийн хяналтыг ЕХЭК-ээр орлуулах нь

217. Зарим улсад Европын хүний эрхийн конвенц дотоодын түвшинд үндсэн хуулийн хяналтаас өөр хувилбар бий болгосон. Жишээлбэл, Францад 2008 онд нэвтрүүлсэн Урьдчилсан асуулгаас ("*QPC*") өмнө ердийн шүүгчид үндсэн хуулийн хяналтыг хийх эрхгүй байсан ч "конвенцод нийцэж буй эсэхийг хянах" боломжтой байсан. Өөрөөр хэлбэл, тэд дотоодын хууль тогтоомжийг Европын хүний эрхийн конвенц зэрэг олон улсын гэрээнүүдтэй нийцэж буй эсэхийг тогтоож байсан. Конвенцоор хамгаалагдсан эрх нь үндсэн хуулиар хамгаалагдсан эрхтэй давхцаж байхын хэрээр конвенцын дагуу хянах нь нь үндсэн хуулийн хяналттай дүйнэ.

218. Үүний нэгэн адил Нидерландад Европын хүний эрхийн конвенцын өөрөө хэрэгжих заалт болон Европын хүний эрхийн шүүхийн шийдвэрийг, шүүхээс дотоодын хууль тогтоомжийг олон улсын эрх зүйн зүйл заалтуудтай нийцэж буй эсэхийг хянаж, тодорхой хэргүүдэд олон улсын эрх зүйг зөрчсөн хууль эсхүл бусад дотоодын эрх зүйн заалтын хэрэглээг түдгэлзүүлэх шүүхийн хянан шийдвэрлэх ажиллагаанд шууд ашиглаж болно. Иймд Нидерланд хууль тогтоомждоо үндсэн хуулийн хяналтыг заагаагүй ч хувь хүн шүүхийн өмнө Конвенцод заасан эрхээ хамгаалуулах боломжтой.

²⁷¹ Хувь хүний гомдлын энэ хэсэг нь 2010 оны есдүгээр сарын 12-нд бүх нийтийн санал асуулгаар батлагдсан Үндсэн хуулийн шинэтгэлийн багцын нэг хэсэг юм.

²⁷² Жишээ нь дараахыг харна уу: Stone-Sweet, A. and Keller, H. (Eds.), *A Europe of Rights: The Impact of the ECHR on National Legal Systems*, Oxford University Press, 2008, pp. 852; Мөн дараахыг харна уу: Szymczak, D., *La Convention européenne des droits de l'homme et le juge constitutionnel national*, Bruylant, Bruxelles, 2007, pp. 872.

²⁷³ https://www.echr.coe.int/Documents/Stats_pending_2020_BIL.pdf

С. ЕХЭШ болон шударга шүүхээр шүүлгэх эрх

219. Европын хүний эрхийн конвенцын 6 дугаар зүйлд зааснаар хувь хүн шударга шүүхээр шүүлгэх эрхтэй.²⁷⁴ Хэдийгээр энэ заалт нь үндсэн хуулийн шүүхэд хандах эрхийг баталгаажуулаагүй ч үндсэн хуулийн хяналтын ажиллагаанд үйлчилнэ. Энэ дагуу үндсэн хуулийн хяналтын ажиллагаа шударга бус явагдсан тохиолдолд хувь хүн ЕХЭШ-д хандаж болно. Тийм ч учраас үндсэн хуулийн хяналтын ажиллагаа Европын хүний эрхийн конвенцын 6 дугаар зүйлд заасан шударга шүүхээр шүүлгэх шаардлагыг хангаж буй эсэхийг ЕХЭШ баталгаажуулдаг.

220. Шударга шүүхээр шүүлгэх эрх нь үндсэн хуулийн шүүхийг хуулийн дагуу байгуулагдаж, хараат бус, бие даасан байхыг шаарддаг. Хууль ёсны байх шаардлага нь үндсэн хуулийн шүүх өөрийн эрх мэдлийн хүрээнд хууль дээдлэх зарчимд үндэслэн, зохих хэм хэмжээний дагуу тогтоосон журмаар хянан шийдвэрлэх ажиллагааг явуулсны дараа шийдвэр гаргахыг шаарддаг.²⁷⁵ Эс тэгвээс ардчилсан нийгмийн шаардлага болох хууль ёсны чанараа алдах болно.²⁷⁶ Шүүх буюу хэрэг хянан шийдвэрлэх бүрэлдэхүүнийг бүрдүүлэхэд хууль ёсны зарчим хамаатай.²⁷⁷ Үндсэн хуулийн шүүх нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг (жишээ нь, хэргийг хуваарилах) хэрхэн явуулахаа шийдэх эрхтэй. Гэхдээ энэхүү эрхийг хараат бус, бие даасан зарчмын шаардлагад нийцүүлэн хэрэгжүүлэх ёстой.²⁷⁸ Өөрөөр хэлбэл, тухайн хэргийг шийдвэрлэхээр томилогдсон шүүгчид гүйцэтгэх засаглалаас хараат бус байх ёстой бөгөөд тус томилгоо нь дан ганц шүүхийн үзэмжээс хамаарахгүй байх юм.²⁷⁹

221. Бие даасан байх гэдэг нь төрийн бусад салбар²⁸⁰ болон хэргийн талуудаас²⁸¹ хараат бус байхыг ойлгоно. Энэхүү шаардлагыг биелүүлж байгаа эсэхийг албан тушаалд томилогдсон хэлбэр, бүрэн эрхийн хугацаа, гаднын нөлөөллөөс хамгаалах хангалттай хамгаалалт байгаа эсэх зэрэг хуулийн шаардлагад

²⁷⁴ ЕХЭШ-ийн 6 дугаар зүйлийн хэрэглээ, холбогдох прецедентын талаар илүү нарийвчилсан тайлбарыг авахыг хүсвэл дараах руу хандаарай: Court's Guide on Article 6 of the European Convention on Human Rights (available at: https://www.echr.coe.int/documents/guide_art_6_eng.pdf).

²⁷⁵ ECtHR, Sramek v. Austria, 22.10.1984, no. 8790/79, para. 36; Cyprus v. Turkey [GC], 10.05.2001, no. 25781/94, para. 233; Sokurenko and Strygun v. Ukraine, 11.12.2006, nos. 29458/04 and 29465/04, para. 24.

²⁷⁶ ECtHR, Lavents v. Latvia, 28.11.2002, no. 58442/00, para. 81; Biagioli v. San Marino, 08.07.2014, no. 8162/13, para. 71.

²⁷⁷ ECtHR, Buscarini v. San Marino, 08.07.2014, no. 8162/13.

²⁷⁸ ECtHR, Pasquini v. San Marino, 02.05.2019, no. 50956/16, paras. 103 and 107.

²⁷⁹ Ibidem, para. 110.

²⁸⁰ ECtHR, Beaumartin v. France, 25.10.1994, no. 15287/89, para. 38.

²⁸¹ ECtHR, Sramek v. Austria, 22.10.1984, no. 8790/79, para.42.

үндэслэн үнэлдэг.²⁸² Түүнчлэн, шүүх бие даасан байдлаа хадгалах ёстой.²⁸³ Хэрэг хянан шийдвэрлэх Шүүхийн бие даасан байдал доголдоход түүнийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны дараагийн шатуудад засаж залруулах боломжгүй.²⁸⁴ Тухайлбал гүйцэтгэх эрх мэдлийн этгээд шүүхийн шийдэх гэж буй хэрэгт хөндлөнгөөс оролцвол хэргийн үр дүнд нөлөөлнө гэж үзэн шүүгчдийн бие даасан байдлыг алдагдуулна.²⁸⁵ Гэхдээ шүүгчид өөрсдийн үүргээ гүйцэтгэхдээ дарамт, нөлөөллөөс ангид байгаа тохиолдолд гүйцэтгэх засаглал эсхүл парламентаас шүүгчийг томилж, чөлөөлөх нь 6 дугаар зүйлийг зөрчсөн гэж үзэхгүй.²⁸⁶

222. Аливаа этгээдийг "бие даасан" эсэхийг тодорхойлохдоо ЕХЭШ тухайлбал гишүүдээ томилох арга хэлбэр; тэдний бүрэн эрхийн хугацаа; гаднын нөлөөллөөс ангид байгаа эсэх; тухайн этгээд бие даасан байдлаа хадгалж буй эсэхийг хардаг.²⁸⁷ Хараат буй байдал нь тухайн шүүгчийн хувийн итгэл үнэмшил, зан төлөвөөс (тухайлбал, тухайн хэрэгт түүний хувийн өрөөсгөл эсхүл нэг талыг барьсан үзэл), шүүх бүрэлдэхүүнийг бүрдүүлсэн байдал болон хараат бус байдалд үндэслэл бүхий эргэлзээ төрүүлэхгүй байхаар хангалттай баталгаа зэргээс хамаарна.²⁸⁸

223. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа шударга байх ёстой. Шударга шүүхийн тухай үзэл баримтлал нь талууд шүүхийн шийдвэрт нөлөөлөхүйц тэр байтугай дотоодын хууль зүйн салбарын бие даасан гишүүний гаргасан ажиглалт, бүхий л нотлох баримтын тухай ойлголт байж, тайлбар гаргах боломжийг олгоно.²⁸⁹ Энэхүү шаардлага нь Үндсэн хуулийн шүүхэд ч тавигдана.²⁹⁰ Үүнээс гадна талуудын хооронд "шударга тэнцвэртэй байдал" байх ёстой бөгөөд энэ нь аль нэг талыг илт хохиролтой байдалд оруулахгүйгээр

²⁸² ECtHR, Ramos Nunes de Carvalho e Sá v. Portugal [GC], 06.11.2018, nos. 55391/13 and two others, paras.153-156.

²⁸³ Ibid. at para. 144; ECtHR, Oleksandr Volkov v. Ukraine, 06.05.2018, no. 21722/11, para. 103; ECtHR, Grace Gatt v. Malta, 08.10.2019, no. 46466/16, para. 85.

²⁸⁴ ECtHR, Denisov v. Ukraine [GC], 25.09.2018, no. 76639/11, paras. 65, 67 and 72.

²⁸⁵ ECtHR, Sovtransavto Holding v. Ukraine, 25.07.2002, no. 48553/99, para. 80; ECtHR, Mosteanu and Others v. Romania, 13.11.2012, nos. 45886/07 and two others, para. 42.

²⁸⁶ ECtHR, Clarke v. the United Kingdom, 25.08.2005, no. 23695/02; ECtHR, Flux v. Moldova (no. 2), 03.07.2007, no. 31001/03, para. 27; ECtHR, Sacilor Lormines v. France, 09.11.2006, no. 65411/01, para. 67.

²⁸⁷ ECtHR, Langborger v. Sweden, 22.06.1989, no. 11179/84, para. 32; ECtHR, Kleyn and Others v. the Netherlands [GC], 06.05.2003, nos. 39343/98 and three others, para. 190.

²⁸⁸ ECtHR, Micallef v. Malta [GC], 15.10.2009, no. 17056/06, para. 93; ECtHR, Nicholas v. Cyprus, 09.01.2018, no. 63246/10, para. 49.

²⁸⁹ ECtHR, Ruiz-Mateos v. Spain, 23.06.1993, no. 12952/87, para. 63; ECtHR, McMichael v. the United Kingdom, 02.03.1995, no. 16424/90, para. 80; ECtHR, Lobo Machado v. Portugal, 20.02.1996, no. 15764/89, para. 31; ECtHR, Kress v. France [GC], 07.06.2001, para. 74.

²⁹⁰ ECtHR, Milatová and Others v. the Czech Republic, 21.09.2005, no. 61811/00 paras. 63-66; ECtHR, Gaspari v. Slovenia, 10.12.2009, no. 21055/03, para. 53.

тайлбар гаргах зохих боломжоор хангагдсан байх ёстой гэсэн үг.²⁹¹ 6 дугаар зүйлээр шүүхэд хүсэлт гаргагчийн гол тайлбарыг судалж,²⁹² тэдгээр тайлбарт хариу болгож шийдвэртээ үндэслэлээ тусгахыг үүрэг болгосон.²⁹³ Үндэсний шүүх, тэр дундаа үндсэн хуулийн шүүх, өргөдөл гаргагчийн үндсэн эрх, эрх чөлөөний талаарх тайлбарыг онцгой хянамгай, анхааралтайгаар шалгах үүрэгтэй.²⁹⁴ Үүний эсрэгээр, 6 дугаар зүйлд үндсэн хуулийн шүүх нь амжилттай шийдэгдэхээргүй хуулийн асуудлаарх давж заалдах гомдлыг хэрэгсэхгүй болгохдоо тайлбар гаргалгүйгээр хуулийн тодорхой заалтыг хэрэглэн шийдвэрлэх тохиолдолд дэлгэрэнгүй үндэслэл заахыг үүрэг болгоогүй.²⁹⁵

224. Үндсэн хуулийн шүүх ерөнхийдөө 6 дугаар зүйлд заасны дагуу нээлттэй хуралдаан явуулах шаардлагагүй. Анхан шатны шүүх хуралдааныг хийсэн тохиолдолд үндсэн хуулийн шүүх хуралдаан хийгээгүйгээ хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны онцлог шинжээр зөвтөж болно.²⁹⁶ Хэрэв үндсэн хуулийн шүүх аман процессын ажиллагаа явуулж байгаа бол зөвхөн явцуу тодорхойлсон хэргүүдэд мөрдөх хязгаарлалтаас хамаарч эдгээр ажиллагаа нээлттэй явагдвал зохино. Тэрчлэн үндсэн хуулийн шүүхийн шийдвэрийг нийтлэх ёстой.²⁹⁷

225. Ерөнхийдөө, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг зохих боломжит хугацаанд явуулах ёстой. Шүүхийн үр дүнтэй байдал, итгэлийг алдагдуулахгүйн тулд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг цаг алдалгүй явуулахын чухлыг ЕХЭШ удаа дараа онцолж ирсэн.²⁹⁸ Гэвч “боломжит хугацаанд” шийдвэр гаргах үүрэг нь үндсэн хуулийн шүүх болон ердийн шүүхэд харилцан адилгүй. Үндсэн хуулийн шүүх нь үндсэн хуулийг хамгаалагчийн хувьд хянан шийдвэрлэх хэргийн дарааллыг тогтоохдоо тухайн хэргийн мөн чанар, улс төр, нийгмийн ач холбогдлыг харгалзан үзэх ёстой.²⁹⁹ Хэдийгээр 6 дугаар зүйлээр хэрэг хянан

²⁹¹ ECtHR, *Regner v. the Czech Republic* [GC], 19.09.2017, no. 35289/11, para. 146; ECtHR, *Dombo Beheer B.V. v. the Netherlands*, 27.10.1993, no. 14448/88, para. 33.

²⁹² ECtHR, 09.12.1994, *Ruiz Torija v. Spain*, no. 18390/91, para. 30; ECtHR, *Hiro Balani v. Spain*, 09.12.1994, no. 18064/91 para. 28; ECtHR, *Donadze v. Georgia*, 07.03.2006, no. 74644/01, para. 35.

²⁹³ ECtHR, *Van de Hurk v. the Netherlands*, 19.04.1994, no. 16034/90, para. 61; ECtHR, *García Ruiz v. Spain* [GC], 21.01.1999, no. 30544/96, para. 26; ECtHR, *Jahnke and Lenoble v. France*, 29.09.2000, no. 40490/98; ECtHR, *Perez v. France* [GC], 12.02.2004, no. 47287/99, para. 81.

²⁹⁴ ECtHR, *Fabris v. France* [GC], 07.02.2013, no. 16574/08, para. 72; ECtHR, *Wagner and J.M.W.L. v. Luxembourg*, 28.06.2007, no. 76240/01, para. 96.

²⁹⁵ ECtHR, *Burg and Others v. France*, 28.01.2003, no. 34763/02; ECtHR, *Gorou v. Greece (no. 2)* [GC], 20.03.2009, no. 12686/03, para. 41.

²⁹⁶ ECtHR, *Helmers v. Sweden*, 29.10.1991, no. 11826/85, para. 36 (but contrast with paras. 38-39); ECtHR, *Salomonsson v. Sweden*, 12.02.2003, no. 38978/97, para. 36.

²⁹⁷ ECtHR, *Fazliyski v. Bulgaria*, 16.07.2013, no. 40908/05, para. 69; *Moser v. Austria*, 21.12.2006, no. 12643/02, para. 101.

²⁹⁸ ECtHR, *Scordino v. Italy (no. 1)* [GC], 29.03.2006, no. 36813/97, para. 224.

²⁹⁹ Cf. ECtHR, *Süßmann v. Germany*, 16.09.1996, no. 20024/92, paras. 56-58; ECtHR, *Voggenreiter v. Germany*, 08.01.2004, no. 47169/99, paras. 51-52; ECtHR, *Oršuš and Others v. Croatia* [GC], 16.03.2010, no. 15766/03, para. 109.

шийдвэрлэх ажиллагааг шуурхай явуулахыг шаарддаг ч үндсэн хуулийн шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг зохистой явуулахад хангалттай хугацаа олгохыг зөвшөөрдөг.³⁰⁰

226. ЕХЭШ нь дотоодын түвшин дэх үндсэн хуулийн хяналтын ажиллагаа шударга шүүхийн баталгаагаар хангагдсан эсэхийг хянах эрхээр л хязгаарлагддаг. Үндэсний шүүхээс албаар гаргасан факт тогтоох эсхүл хууль хэрэглээний алдаа нь илт бөгөөд Конвенцоор хамгаалагдсан эрх, эрх чөлөөг зөрчсөн байхаас бусад тохиолдолд ЕХЭШ шүүхийн ийм алдааг шийдвэрлэх үүрэггүй гэж өөрийгөө үздэг. Өөрөөр хэлбэл, үндсэн хуультай нийцсэн эсэх асуудлыг тогтоохгүй гэсэн үг. Үүний оронд ЕХЭШ зөвхөн үндэсний шүүхүүдийн дүгнэлтийг дур зоргоороо эсхүл илт үндэслэлгүй гаргасан байж болзошгүй гэсэн үндэслэлээр шалгаж болно. Гэсэн хэдий ч 6 дугаар зүйл нь шүүхийн шийдвэрийн эцсийн бөгөөд заавал биелэгдэх зарчмыг хамгаалдаг.³⁰¹

D. Үндэсний хэмжээнд хэрэг сэргээх

227. Хэдийгээр ЕХЭШ давж заалдах шатны шүүх биш бөгөөд үндэсний шүүхүүдэд хэрэг сэргээхийг үүрэг болгож болохгүй ч ЕХЭШ үндэсний шүүхийн дүгнэлтийг Европын хүний эрхийн конвенцыг зөрчсөн, эсхүл зөрчсөн хэм хэмжээн дээр үндэслэсэн гэж үзсэн тохиолдолд үндэсний хууль тогтоомжоор шүүхийг тухайн хэргийг дахин сэргээхийг шаардаж болно.³⁰² Зарим улсад ЕХЭШ-ийн шийдвэрийн дагуу хэргийг дахин сэргээх боломжийг хуульдаа тодорхой заасан байдаг (жишээ нь, Австри,³⁰³ Босни Герцеговина,³⁰⁴ Кипр, Чех, Эстони,³⁰⁵

³⁰⁰ ECtHR, Von Maltzan and Others v. Germany [GC], 02.03.2005, nos. 71916/01 and two others, para. 132.

³⁰¹ ECtHR, Ouzounis and Others v. Greece, 18.04.2002, no. 49144/99, para. 21.

³⁰² Council of Europe, Steering Committee for Human Rights, Committee of Experts on the Reform of the Court, Compilation of written contributions on the provision in the domestic legal order for re-examination or reopening of cases following judgments of the Court, 31.03.2016: <https://rm.coe.int/CoERMPublicCommonSearchServices/DisplayDCTMContent?documentId=090001680654d4f>

³⁰³ Австрийн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 363(a)-363(c) хэсгийг үзнэ үү. (Strafprozessordnung 1975-StPO).

³⁰⁴ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 327(e), Үл маргах журмаар хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 231(a).

³⁰⁵ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 366(7), Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 702(2)(8), Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 240(2)(8)-ыг үзнэ үү.

Венецийн комисс

Герман,³⁰⁶ Грек, Унгар,³⁰⁷ Итали,³⁰⁸ Литва,³⁰⁹ Нидерланд,³¹⁰ Норвег,³¹¹ Польш,³¹² Португал, Румын, Сан Марино, Словени,³¹³ Испани³¹⁴). Бусад улсуудын дотоодын шүүхүүд одоо хэрэгжиж буй хуулийн заалтуудыг ЕХЭШ-ны шийдвэрийн дагуу хэргийг дахин сэргээх боломжтой болгож тайлбарласан байдаг (жишээлбэл, Албани, Дани,³¹⁵ Латви, Словак, Швед). Тухайлбал, Латви улсад шүүхийн шийдвэр, тогтоол хүчин төгөлдөр болсон ч шинээр илэрсэн баримт, нөхцөл байдлын үндсэн дээр эрүүгийн, иргэний, захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг дахин эхлүүлэх боломжтой байдаг. Латвийн шүүхийн хүчин төгөлдөр болсон тогтоолыг Конвенцод нийцэхгүй гэж үзсэн ЕХЭШ-ны шийдвэрийг шинээр илэрсэн нөхцөл байдал, баримт гэж тайлбарлаж ирсэн.³¹⁶

228. Ихэвчлэн, ЕХЭШ-ээс Конвенц зөрчсөн нь тогтоогдсон хэргийг дахин сэргээх боломж нь иргэний болон захиргааны хэргээс илүү эрүүгийн хэргийн

³⁰⁶ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 359 дүгээр зүйл, Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 580 дугаар зүйл.

³⁰⁷ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 649 дүгээр зүйлийн 4-т зааснаар эрүүгийн хэргийн хувьд шүүх хурлын явц эсхүл шүүхийн эцсийн шийдвэр нь Конвенцын заалтыг зөрчсөн нь ЕХЭШ-ээс тогтоогдсон тохиолдолд хяналт хийх хүсэлт гаргаж болно.

³⁰⁸ Эрүүгийн хуулийн хүрээнд Италийн Үндсэн хуулийн шүүхийн 113/2011 тоот тогтоолын *sentenza additiva*-аар (нэмэлт өгүүлбэр) ЕХЭШ-ийн шийдвэрийн дагуу эрүүгийн хэргийг дахин үүсгэх боломжийг бүрдүүлсэн. Италийн эрх зүйд *sentenza additiva* нь тухайн заалтыг Үндсэн хуульд нийцүүлэхийн тулд Үндсэн хуулийн шүүх байх ёстой гэж үзсэн дутуу хэсгийг хуулийн эх бичвэрт нэмж оруулах явдал юм. Италийн Үндсэн хуулийн шүүх үндсэн хуулийн асуудлыг хүлээн зөвшөөрсөн бол шийдвэр нь *erga omnes* нөлөтэй байдаг.

³⁰⁹ Литвын 2003 оны Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 456 дугаар зүйл, 2003 оны Литвын Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 366 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 153 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх хэсэг.

³¹⁰ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 457 § 1 (b)

³¹¹ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 391 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Маргааны тухай хуулийн 31-3 дугаар зүйлийн 1.d хэсэг.

³¹² Польшийн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 540 § 3, 2002 оны Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 272 § 3.

³¹³ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 416 дугаар зүйл.

³¹⁴ 7 дугаар сарын 1-ний Органик хууль 6/1985-р нэмэлт өөрчлөлт орсон 2015 оны 7-р сарын 21-ний өдрийн 7/2015 тоот Шүүхийн тухай Органик хууль. Энэ хуулиас өмнө ЕХЭШ-ийн 12 дугаар сарын 16-ний өдрийн 245/1991 тоот шийдвэр болон түүний дараах ЕХЭШ-ийн удаа дараагийн шийдвэрийн үр дагавар болох 96/2001, 240/2005, 313/2005, 313/2006 хэргүүдийн шийдвэрээр Үндсэн хуулийн шүүх хэргийг дахин үүсгэх боломжтой болсон.

³¹⁵ Жишээлбэл, “хэрэв нотлох баримтыг зөв үнэлээгүй гэдгийг харуулсан онцгой тохиолдолд” (*særlige omstændigheder*) (Шүүхийн удирдлагын тухай хуулийн (*retsplejelov*) 977(1)) хэргийг дахин нээхийг зөвшөөрсөн зүйл заалтад үндэслэн дахин үүсгэсэн *Jersild* (1994 оны 9 дүгээр сарын 23-ний шийдвэр, Шийдвэр (95) 212).

³¹⁶ 2005 оны 4 дүгээр сарын 21-ний өдрийн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 655 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 5; Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 479 дүгээр зүйлийн 6 дахь хэсэг (2008 оны 06 дугаар сарын 25-ны өдөр хүчин төгөлдөр болсон 2008 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн нэмэлт, өөрчлөлтийн дараа), Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 353 дугаар зүйлийн 6 дахь хэсэг.

хувьд түгээмэл байдаг (жишээ нь, Австри, Кипр, Польш, Словени, Швед).³¹⁷ Жишээ нь, Австрийн эрүүгийн шүүх ЕХЭК-ийг зөрчсөн гэж үзсэн ЕХЭШ-ийн шийдвэрийн дагуу (Австрийн дээд шүүхийн эрүүгийн хэргийн шийдвэрийг оролцуулан) Австрийн Дээд шүүх эрүүгийн хэргийг сэргээж болно. Австрийн Дээд шүүх хэргийг дахин үүсгэх эсэхээ шийдэхдээ ЕХЭШ-ийн үндэслэлийг чанд дагаж мөрдөх ёстой. ЕХЭШ-ийн шийдвэрийн дагуу иргэний хэргийг дахин хэлэлцэх тухай тодорхой зохицуулалт байхгүй ч ЕХЭШ-ийн шийдвэрт үндэслэн эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг дахин шинээр үүсгэснээр эсхүл эрүүгийн шүүхийн шийдвэрийг хүчингүй болгосноор хэрэг дахин хэлэлцэх тухай Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн ерөнхий зохицуулалтын дагуу иргэний хэргтэй холбоотой ажиллагааг дахин үүсгэж болно.³¹⁸

IX. ДҮГНЭЛТ

229. Анхны судалгаа 2010 онд хэвлэгдсэнээс хойш Алжир, Унгар, Литва, Марокко, Тунис, Турк, Украин улсууд үндсэн хуулийн хяналтын системдээ хувь хүн хандах боломжийг нэмэгдүүлэх шинэчлэлийг хийсэн. Өнөөдрийн байдлаар Венецийн комиссын бүх гишүүн болон ажиглагч улсууд хувь хүн дээд шатны шүүхдээ ямарваа нэг байдлаар хандаж норматив акт, эсхүл нэг бүрчилсэн акт үндсэн хуульд нийцэж буй эсэх талаар хянах хүсэлт гаргах боломжийг олгож байна. "Үндсэн хуулийн хяналтын системийн талаар дагаж мөрдөх ёстой цогц стандарт байхгүй байна. Үндэсний тогтолцоонууд олон янз байгаа ба янз бүрийн шийдлүүд гаргадаг" гэж Венецийн Комисс ажигласан хэвээр байна.³¹⁹

230. Үндсэн хуулийн шүүх (эсхүл түүнтэй адилтгах харьяалалтай байгууллага) -д шууд хандах буюу тухайн хууль, акт үндсэн хуульд нийцсэн эсэх талаар хувь хүн өөрөө хандаж гомдол гаргах боломж болон шууд бусаар хандах буюу тухайн хууль, эсхүл акт үндсэн хуульд нийцсэн эсэх талаарх асуултаа үндсэн хуулийн шүүх (эсхүл түүнтэй адилтгах харьяалалтай байгууллага)-д бусад төрийн зуучлагч этгээдээр дамжуулан хандах хэлбэрийн хооронд ялгаа гаргаж болох юм. Ихэнх улс орнуудын үндсэн хуулийн хяналт нь шууд болон шууд бусаар хандах холимог тогтолцоотой байдаг. Зарим улс орнууд зөвхөн шууд хандах тогтолцоотой байдаг бол маш цөөн улс шууд бусаар хандах тогтолцоотой байдаг.

³¹⁷ Council of Europe, Steering Committee for Human Rights, Committee of Experts on the Reform of the Court, Reopening of cases following judgments of the Court; <https://www.coe.int/en/web/human-rights-intergovernmental-cooperation/echr-system/implementation-and-execution-judgments/reopening-cases>

³¹⁸ Council of Europe, Steering Committee for Human Rights, Committee of Experts on the Reform of the Court, Compilation of written contributions on the provision in the domestic legal order for re-examination or reopening of cases following judgments of the Court, 2016 оны 3-р сарын 31, <https://rm.coe.int/CoERMPublicCommonSearchServices/DisplayDCTMContent?documentId=0900010168066b316>

³¹⁹ Venice Commission, CDL-AD(2011)040, Opinion on the Law on the Establishment and Rules of Procedure of the Constitutional Court of Turkey, para. 13.

231. Энэхүү тайланд хамрагдсан улс орнуудад хувь хүн үндсэн хуулийн шүүхэд хандах үндсэн гурван үндсэн механизм байна: үндсэн хуулийн иж бүрэн гомдол, норматив үндсэн хуулийн гомдол болон *actio popularis*. Үндсэн хуулийн иж бүрэн гомдол нь үндсэн хууль зөрчсөн хуульд үндэслэсэн байж болох нэг бүрчилсэн актын эсрэг чиглэгддэг. Норматив үндсэн хуулийн гомдлыг зөвхөн Үндсэн хууль зөрчсөн хуулийн эсрэг гаргадаг. *Actio popularis* нь хууль батлагдсаны дараа заавал өөрийнх эрх зөрчигдсөн байхыг шаардахгүйгээр хэнд ч тус хуулийн эсрэг нэхэмжлэл гаргах эрх олгодог. Венецийн Комисс үндсэн хуулийн иж бүрэн гомдлыг илүүд үздэг, учир нь нь үндсэн хуулийн шүүхэд хувь хүн хамгийн өргөн хүрээгээр хандах боломжтой, улмаар хувь хүний үндсэн эрхийг бүрэн гүйцэд хамгаалах боломжийг олгодог хэмээн үздэг. Үндсэн хуульд нийцэхгүй байгаа асуудал нь хэм хэмжээг хэрэглэх явцад илэрсэн, гэвч хэм хэмжээ өөрөө үндсэн хуульд харшилсан бус бол норматив үндсэн хуулийн гомдол нь төдийлөн үр дүнтэй эрх зүйн хамгаалалт болохгүй юм. Үндсэн хуулийн шүүхэд (эсхүл түүнтэй адилтгах харьяалалтай байгууллагад) хэт ачаалал өгөх эрсдэлийг бий болгох тул Венецийн Комисс *actio popularis*-ийг нэвтрүүлэхгүй байхыг зөвлөж байна.

232. Шууд бусаар хандах тухайд, аливаа хэм хэмжээ үндсэн хуульд нийцсэн эсэх талаар хувь хүмүүс хүсэлт гаргах үйл явцад зуучлагч болж болох хэд хэдэн төрийн байгууллага байдаг. Тэдгээрийн дотроос хамгийн түгээмэл нь энгийн шүүх урьдчилсан хүсэлт гарган оролцох болон, омбудсманы институт юм. Венецийн комисс хүний эрхийг үр дүнтэй хамгаалах үүднээс зөвхөн дээд шүүхэд төдийгүй бүх шатны шүүхэд үндсэн хуулийн шүүхэд хандан урьдчилсан асуулт тавих боломжийг олгох нь оновчтой бөгөөд үр дүнтэй гэж үзэж байна. Үүний нэгэн адил, Омбудсманы институт байгаа тохиолдолд хүний эрх, эрх чөлөөг хөндсөн асуудлаар хууль тогтоомж үндсэн хуульд нийцсэн эсэх асуудлаар дүгнэлт гаргуулахаар Үндсэн хуулийн шүүхэд (эсхүл түүнтэй адилтгах харьяалалтай байгууллагад) хандах боломжийг тус институтэд олгох ёстой. Үндсэн хуулийн шүүх (эсхүл түүнтэй адилтгах харьяалалтай байгууллага) нэг бүрчилсэн актуудын үндсэн хуульд нийцэж байгаа эсэхийг хянан шалгах эрхтэй бол омбудсманд мөн үндсэн хуулийн шүүх (эсхүл түүнтэй адилтгах харьяалалтай байгууллага) -д бие даасан нэхэмжлэл гаргах эрхийг олгох ёстой.

233. Венецийн Комисс нь үндсэн хуулийн шүүх (эсхүл түүнтэй адилтгах харьяалалтай байгууллага) -д иргэний өргөдөл гаргах замаар шууд хандахыг илүүд үзэж байгаа ба, ялангуяа үндсэн хуулийн иж бүрэн гомдол нь үндсэн хуулийн хамгааллын үндсэн арга гэж үздэг. Үндсэн хуулийн шүүхэд шууд бусаар хандах нь үндсэн хуулийн түвшинд хувь хүний үндсэн эрхийг хамгаалах чухал арга хэрэгсэл мөн боловч үүнийг зөвхөн шууд хандах тогтолцооны нэмэлт үйл явц гэж үзэх ёстой. Венецийн комисс аль аль механизмуудын давуу болон сул талуудыг тэнцвэржүүлэхийн тулд шууд бусаар хандахыг шууд хандах процесстой хослуулах нь давуу тал гэж үзэж байна.

234. Хувь хүмүүст үндсэн хуулийн шүүхэд (эсхүл түүнтэй адилтгах харьяалалтай байгууллага) хандах эрхийг олгох нь тэдгээр шүүхэд хэт ачаалал өгөх эрсдэлийг бий болгож болох тул үндсэн хуулийн шүүхийн маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа нь ихэвчлэн олон төрлийн шүүлтүүрээс бүрддэг. Түүнчлэн, үндсэн хуулийн шүүх хянах хэргээ сонгоход ихээхэн эрхтэй байх боломжтой. Гэсэн хэдий ч үндсэн хуулийн шүүхийн хэт ачааллын эрсдэл нь үндсэн хуулийн шүүхэд хувь хүн үр дүнтэй хандах эрэлт, хэрэгцээтэй тэнцвэртэй байх ёстой. Венецийн комиссоос хүний эрхийг хамгаалах баталгаа болохынх нь үндсэн хуулийн шүүхэд (эсхүл түүнтэй адилтгах харьяалалтай байгууллага) хандах үйл явцыг хялбарчлахыг зөвлөж байна. Үүний зэрэгцээ, үндсэн хуулийн шүүхэд (эсхүл түүнтэй адилтгах харьяалалтай байгууллагууд) хөнгөмсгөөр хандсан, зүй бусаар, эсхүл давтан гомдол гаргахаас урьдчилан сэргийлэх арга хэрэгслийг өгөх ёстой.

235. Өргөдлийг буцаан татсан ч хэрэв нийтийн ашиг сонирхол хөндөгдөж байгаа бол үндсэн хуулийн шүүх (эсхүл түүнтэй адилтгах харьяалалтай байгууллага) уг гомдолд үргэлжлүүлэн дүн шинжилгээ хийх боломжтой байх ёстой. Гэхдээ, хэрэв маргаантай акт хүчин төгөлдөр бус байхаа больсон ч хүний эрхийн зөрчил хэвээр байвал уг хэргийг үргэлжлүүлэхгүй зогсоох нь хүний эрхийг хамгаалахад хангалтгүй байж мэднэ.

236. Түр арга хэмжээний тухайд маргаантай байгаа нэг бүрчилсэн эсхүл норматив актыг хэрэгжүүлэх нь цаашид хохирол, эсхүл зөрчилд нэмж хүргэж болзошгүй бөгөөд тухайн заалт үндсэн хууль зөрчсөн нь тогтоогдсон тохиолдолд түүнийг нэгэнт нөхөн сэргээх боломжгүй болохоор байвал тус актын хэрэгжилтийг түдгэлзүүлэх боломжийг Венецийн Комисс дэмжиж байна. Түдгэлзүүлэх нөхцөл нь хэт хатуу байх ёсгүй. Гэхдээ, ялангуяа норматив актуудын хувьд тэдгээрийг хэрэгжүүлэхгүй байх нь нэмэлт хохирол учруулж, засаж залруулах боломжгүй зөрчлийг үүсгэх эсэхийг мөн авч үзэх ёстой. Урьдчилсан асуултыг үндсэн хуулийн шүүх (эсхүл түүнтэй адилтгах харьяалалтай байгууллага) руу шилжүүлэхэд ердийн шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нэн даруй эсхүл ердийн шүүхийн шийдвэр гарахаас өмнө зогсох ёстой. Ердийн шүүхийн шүүгч үндсэн хууль зөрчсөн гэж өөрөө үзэж байгаа бөгөөд тухайн хэрэгт хэрэглэх хуулийн үндсэн хуульд нийцсэн эсэхийг үндсэн хуулийн шүүх хянан шийдвэрлэх хуулийг хэрэглэх шаардлагагүй Хувь хүний эрхийн нөхөж барахгүй хохирол учирсан тохиолдолд гүйцэтгэлийг түдгэлзүүлэх нь заавал биелэгдэх ёстой.

237. Шийдвэр гаргах хугацааны хязгаар тогтоосон тохиолдолд хэргийг бүрэн хянан шалгах хангалттай хугацааг үндсэн хуулийн шүүхэд олгох үүднээс хугацаа хэт богино байх ёсгүйгээс гадна үндсэн хуулийн шүүхээр хүний эрхийн хамгаалалтыг үр дүнгүй болгохоос сэргийлэх үүднээс хэт урт хугацаа тогтоох ёсгүй. Үндсэн хуулийн шүүх онцгой тохиолдолд дурдсан хугацааны хязгаарыг

Венецийн комисс

сунгах боломжтой байх ёстой ч мөн боломжит цаг хугацааны дотор шийдвэрлэх үүргээ сахих ёстой. Тэрчлэн, үндсэн хуулийн шүүх (эсхүл түүнтэй адилтгах харьяалалтай байгууллага) нь өөрөө хохирол барагдуулах шийдвэр гаргах боломжтой байх ёстой эсэх нь нээлттэй асуулт хэвээр байна.

238. Мөн Үндсэн хуулийн шүүхээс (эсхүл түүнтэй адилтгах харьяалалтай байгууллага) гаргасан эцсийн шийдвэрийн нөлөөлөл нь нэлээд олон янз байдаг. Шийдвэрийн нөлөө нь *inter partes* (талуудын хооронд) эсхүл *erga omnes* (бүгдэд хамаатай) аль аль нь байж болох бөгөөд *erga omnes* нь норматив актыг хүчингүй болгох, эсхүл дараа дараагийн хэрэгт хэрэглэх боломжгүй болгодог. Тайланд хамрагдсан ихэнх улс орнуудад аливаа хэм хэмжээ үндсэн хуульд нийцэж байгаа эсэх маргаан гарсан тохиолдолд үндсэн хуулийн шүүх (эсхүл түүнтэй адилтгах харьяалалтай байгууллага) түүнийг хүчингүй болгодог, эсхүл үндсэн хуульд нийцсэн эсэхийг шийдвэрлэж, шинэ хууль батлах үүргийг хууль тогтоогчид үлдээдэг. Үндсэн хуульд харшилж буй хуулийн заалтуудыг тогтоож, эдгээр заалтыг хүчингүй болгох нь үндсэн хуулийн шүүхийн үндсэн чиг үүрэг гэж Венецийн комисс үзэж байна. Иймд Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрийн үр нөлөө нь *erga omnes* байх ёстой гэж Комисс шийдвэр төгс үзэж байна.

239. Европын хүний эрхийн шүүх нь Европын Зөвлөлийн гишүүн орнуудад хувь хүн дотоодын түвшинд үндсэн хуулийн хяналтаар хамгаалуулах наад зах нь гурван арга замаар нөлөөлж болно. Нэгдүгээрт, зарим улсын дотоодын шүүхүүд үндсэн хуулиар хамгаалагдсан эрхийг Европын хүний эрхийн конвенцод нийцүүлэн тайлбарлах шаардлагатай байдаг. Хоёрдугаарт, Европын шүүх нь үндсэн хуулиар хамгаалагдсан эрхийг Конвенцын эрхтэй давхцах хэмжээнд үр дүнтэй хамгаалдаг гэж ойлгож болно. Гуравдугаарт, Европын шүүх нь Үндсэн хуулийн хяналтын үйл ажиллагаа нь Европын хүний эрхийн конвенцын 6 дугаар зүйлд заасан шударга шүүхийн шаардлагыг хангаж байгаа эсэхийг баталгаажуулдаг. Тодорхой нөхцөлд Европын шүүхээс гаргасан зөрчлийн талаарх дүгнэлт нь дотоодын хэмжээнд дахин хэрэг үүсгэх нөхцөлд хүргэж болзошгүй юм.

240. Үндсэн хуулийн шүүх эсхүл түүнтэй адилтгах байгууллагад гаргасан иргэний өргөдлийг Европын хүний эрхийн конвенцын зөрчлийн эсрэг авсан хамгаалалтын үр дүнтэй арга гэж Европын хүний эрхийн шүүхээс үзэж болох бөгөөд ингэснээр хэргүүд Страсбургийн шүүхэд хандахын өмнөх шүүлтүүрийн чиг үүрэг болж болох юм. Шүүхийн хэт их ачааллыг харгалзан Венецийн комисс Европын хүний эрхийн шүүхэд хэт ачаалал өгөхөөс зайлсхийхийн тулд энэхүү гомдол гаргах механизмыг нэвтрүүлэхийг зөвлөж байна.

